



# МОНГОЛ УЛС ШАДАР САЙДЫН ТУШААЛ

20 16 оны 5 дугаар  
сарын 18 -ны өдөр

Дугаар 53

Улаанбаатар  
хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Гал түймэр унтраах дүрэм"-ийг хавсралт ёсоор баталсугай.
2. "Гал түймэр унтраах дүрэм"-ийг мөрдөн ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Т.Бадралд үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 508 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Шадар сайд



Ц.ОЮУНБААТАР

## ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ ДҮРЭМ

### НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

## ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ АВРАХ АНГИ, ХЭСГИЙН ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭС

### Нэгдүгээр бүлэг

#### Нийтлэг үндэслэл

Гал түймэр унтраах аврах анги, хэсэг, аврах анги, эрэн хайх аврах анги, салбарууд аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын голомтод гал түймэр унтраах үүрэг гүйцэтгэх болон дадлага сургалт явуулах харилцааг зохицуулахад энэхүү дүрмийн зорилго оршино.

1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагч нэг бүр нь гал түймрийн болзошгүй аюулаас хүний амь бие, аж ахуйн нэгж, байгууллага, болон иргэдийн өмч хөрөнгө, байгалийн баялагийг авран хамгаалах "Гамшгаас хамгаалах тухай", "Галын аюулгүй байдлын тухай" Монгол Улсын хуулиудыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

2. Онцгой байдлын албаны албан хаагч нь өргөсөн тангартаа үнэнч байж, гал түймэр унтраах аврах үйл ажиллагааг мэргэжлийн ур чадвар, сэтгэл зүй, бие бялдрын хүч нөөцийг бүрэн дайчлан тэсвэр хатуужил, авхаалж самбаа гарган ямар ч үед бэрхшээлийг даван туулж, өгөгдсөн үүргийг биелүүлэх үүрэгтэй.

3. Онцгой байдлын албаны бие бүрэлдэхүүн, бусад хувийн болон гэрээт гал түймэр унтраах ангийн бие бүрэлдэхүүний гал түймэр унтраах үндсэн үүрэг бол объектын болон ой хээрийн гал түймрийн дуудлагаар гал түймэр унтраах аврах анги, хэсэг, Аврах тусгай анги, Эрэн хайх аврах анги, салбар, хүрэлцэн очиж хүний амь бие, эд хөрөнгийг авран хамгаалах, гал түймрийн тархан дэлгэрэлтийг зогсоон унтраах явдал юм.

4. Объектын болон ой хээрийн гал түймрийг унтраах үйл ажиллагаа нь нөхцөл байдлыг үнэн, зөв тодорхойлсоноор гал түймрийг унтраах шийдвэрлэх чиглэлийг тогтоож, хүч хэрэгслийг цаг алдалгүй төвлөрүүлэн байрлуулж, гал түймэр унтраах аврах анги, гал сөнөөгч, аврагчдын харилцан ажиллагааг удирдан зохион байгуулах, бие бүрэлдэхүүний гал түймэр унтраах тактикийн сэтгэлгээ, мэргэжлийн ур чадвар, сахилга бат, идэвхи санаачлагаас шууд хамаарна.

### Хоёрдугаар бүлэг

#### Гал түймэр унтраах бэлтгэл бэлэн байдал

5. Гал түймэр унтраах үйл ажиллагааг зохион байгуулах, бэлтгэл бэлэн байдлыг хангах ажлын үндсэн хэсэг нь дадлага, сургалт, соён гэгээрүүлэх ажил мөн.

6. Дадлага, сургалтын ажлыг Онцгой байдлын газар, хэлтэс, аврах тусгай анги, гал түймэр унтраах аврах анги, аврах анги, эрэн хайх аврах анги салбар, хэсгийн дарга болон сургалтын асуудал хариуцсан мэргэжилтэн, улсын хяналтын байцаагч, салааны захирагч нараас гал түймрийг унтраах, гал түймрийн аюулаас хүний амь бие, эд хөрөнгө, байгалийн баялагийг авран хамгаалахад чиглэгдсэн гал түймэртэй тэмцэх үүргийг амжилттай биелүүлэхэд бие бүрэлдэхүүнийг сэтгэл зүй, ур чадвар, бие бялдрын хувьд бэлтгэн дадлагажуулах зорилгоор зохион байгуулна.

7. Дадлага сургалтын ажил нь тодорхой чиглэл зорилготой, дайчин шуурхай, уян хатан байж, зөв шийдвэрийг оновчтой хурдан гаргах, гал түймэр унтраах хүнд бэрхшээлтэй болон өндөр ачаалалтай ажиллах үед санаачлагатай, мэргэжлийн ур чадвартай, ажиллахад чиглэгдэнэ.

8. Дадлага сургалтын зорилго нь:

8.1. Онцгой байдлын албаны бие бүрэлдэхүүнд байгууллагын бодлого шийдвэрийг хүргэх, түүнийг хэрэгжүүлэх арга зам болон сэтгэл зүй, бие бялдар, гал унтраах бэлтгэл бэлэн байдлыг хангуулах

8.2 Гал сөнөөгч, аврагч, шүхэрчин нэг бүрт эр зориг, тэвчээр хатуужил, санаачлага, авхаалж самбаа, нягт нямбай, шуурхай, багаар ажиллах ажиллагаа, харилцан ойлгох, туслах, үйл явдалд бодит дүгнэлт хийж ашигтай хувилбарыг сонгон авах чадварыг эзэмшүүлэх

8.3. Онцгой байдлын албан хаагч нэг бүрт албаны үүргээ биелүүлэх хариуцлагыг ухамсарлуулах, гал унтраах техник хэрэгсэл, шүхрийн найдвартай ажиллагааг хангаж өөрийн мэргэжлийн ур чадварт бүрэн итгэдэг болгон дадлагажуулах

8.4. Онцгой байдлын албан хаагч нь төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, захирах захирагдах ёс, удирдлагын шийдвэр, тушаал, заавар, дүрмийн шаардлагыг даган биелүүлэхийн зэрэгцээ иргэдтэй зөв боловсон харьцаж сурах.

8.5. Удаан хугацаагаар үргэлжилсэн буюу томоохон гал түймэр унтраах үйл ажиллагааны явцад тухайн гал түймрийн онцлог, нөхцөл байдлыг бие бүрэлдэхүүнд тасралтгүй мэдээлэх, унтрааж дууссан гал түймрийн голомт дээр ажилласан талаар танилцуулга бэлтгэж бие бүрэлдэхүүнд ярилцлага зохион байгуулж үнэлэлт, дүгнэлт өгөх.

### **Гуравдугаар бүлэг**

#### **Гал түймэр унтраах аврах анги, хэсгийн гал түймэр унтраах үйл ажиллагаа, хүн хүч, техник хэрэгсэл**

9. Гал түймэр унтраах ажлыг зохион байгуулж гүйцэтгэхдээ Онцгой байдлын албаны гал түймэр унтраах дүрмийг баримтлан шаардлагатай хүн хүч, техник хэрэгслийг холбогдох хууль тогтоомжид зааснаар дайчилж болно.

10. Гал түймэр унтраах үйл ажиллагааны хүч хэрэгсэл:

10.1. Агаарын хөлөг, аврах болон гал түймэр унтраах зориулалтын техник, гал унтраах тусгай тоноглол бүхий автомашин, механизм, /өөрөө явагч хэрэгсэл/ шүхэр, гал түймэр унтраах автомат тоног төхөөрөмж, бусад гар багаж хэрэгсэл

10.2. Байгууллага, аж ахуйн нэгжийн ус тээвэрлэх автомашин, бусад техник, тоног төхөөрөмж гал унтраах зориулалтаар ашиглаж болох автомашин

10.3. Гал түймэр унтраах бодис /ус, хөөс, нунтаг, хий, бусад/

10.4. Мэдээллийн болон холбооны хэрэгсэл

10.5. Автомашин /тусгай тоноглол бүхий ус тээвэрлэгч/

10.6. Гал унтраах зориулалтын инженерийн усан хангамж, усан сан багтана.

11. Гал түймэр унтраах тусгай тоноглол бүхий автомашиныг зориулалтаар нь үндсэн, тусгай, туслах албаны гэж ангилна. Үүнд:

12. Үндсэн албаны автомашинд гал түймэр унтраах тасгийн бие бүрэлдэхүүнийг тээвэрлэх, гал түймэр унтраах бодисыг (ус, хөөс, нунтаг хий, бусад бодис) шатлагын бүсэд өгөх тусгай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл бүхий тээврийн хэрэгсэл. Үндсэн албаны автомашиныг ерөнхий зориулалтын (төв суурин газарт гарсан гал түймрийг унтраах), объектын зориулалттай (нефть болон химийн бүтээгдэхүүн, нисэх онгоцонд гарсан гал түймрийг унтраах, ой хээрийн түймрийг унтраах) гэж ангилна.

13. Тусгай албаны автомашинд автомеханик шат, өргөгч, гэрэл холбоо, утаа зайлуулагч, багны албаны, хоолойн албаны, хүн хүч, хэрэгслийг удирдлагаар хангах штабын автомашинууд хамаарна.

14. Туслах албаны автомашинд ус тээвэрлэгч, техникийн засвар үйлчилгээ, ухуулга, сурталчилгааны зориулалтаар тоноглогдсон автомашин, автобус, трактор, түрэгч, кран, авто өргөгч зэрэг туслах чанарын үүрэг гүйцэтгэх зориулалтын автомашин, техник хамаарна.

15. Тусгай зориулалтын техник тоног төхөөрөмжид агаарын хөлөг, шүхэр, цуравдагч, үлээгч, зөөврийн хөөрөг, барилгын хийц бүтээцийг нураах, задлах багаж хэрэгсэл, өндөрт гаргах үүрэг бүхий багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж хамаарна

16. Гал түймэр унтраах үндсэн албаны автомашин бүхий тасаг нь гал түймэр унтраах хүн хүч, эд материалыг аврах үүргийг дагнан гүйцэтгэх чадвартай Онцгой байдлын албаны гал түймэр унтраах тактикийн анхан шатны бие даасан нэгж юм.

17. Гал түймэр унтраах үндсэн албаны автомашин бүхий хоёр буюу түүнээс дээш тасагтай томилгоот ээлж нь гал түймэр унтраах үүргийг өөрийн хүч хэрэгслэлдээ тулгуурлан гүйцэтгэх чадвартай Онцгой байдлын албаны гал түймэр унтраах тактикийн биеэ даасан үндсэн хэсэг юм.

18. Холбооны зориулалттай автомашин нь зөөврийн радио станц, телефон утас, чанга яригч, өсгөх төхөөрөмж, бусад шаардлагатай холбооны хэрэгслээр тоноглогдож хангагдсан байна.

19. Гэрэлтүүлэх үүрэг бүхий автомашин нь үндсэн болон тусгай зориулалтын автомашин дээр тоноглогдсон зөөврийн тоног төхөөрөмж, аппарат хэрэгслээр хангагдсан байна.

20. Гал түймэр унтраах аврах анги, хэсгийн гүйцэтгэх үүрэг, хамгаалж байгаа объектын технологийн горим орон нутгийн онцлог байдлаас хамааран энэхүү бүлэгт заагдаагүй гал түймэр унтраах бусад төрлийн автомашин, техникийг ашиглаж болно.

#### **Гал түймрийн дуудлагаар гарах, хүрэлцэн очих**

21. Гал түймэр гарсан тухай дуудлага хүлээн авсан, хэсгийн томилгоот ээлж нь гал түймэр гарсан газар богино хугацаанд хүрэлцэн очих үүрэгтэй. Үүнд:

21.1. Мэдээлэл болон дуудлага хүлээн авагч нь шуурхай үйл ажиллагаагаар гал түймэр гарсан газрын хаягийг зааврын дагуу хүлээн авч гал түймэр унтраах

аврах анги, тасаг, хэсгийг гаргана. Зааврыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

21.2. Түгшүүрийн дохиогоор бие бүрэлдэхүүн шуурхай цуглаж, богино хугацаанд, гал түймэр гарсан газар хүрэлцэн очсоноор хангагдана.

21.3. Ой, хээрийн түймрийн дуудлага авмагц тогтоосон хугацаанд томилогдсон бүрэлдэхүүн бэлэн байдлыг хангаж, хаягийн дагуу дуудлагаар гарна.

22. Гал түймэр гарсан газар хүрэлцэн очих замд гал түймэр унтраах удирдагч нь удирдлагын төвийн холбогдох албан тушаалтан, гал түймэр унтраах аврах ангийн дуудлага хүлээн авагчтай байнга холбоо барих үүрэгтэй.

23. Томилгоот ээлжийн бүрэлдэхүүн гал түймрийн дуудлагаар яваа үед гарсан гал түймэр нь унтарсан буюу гал түймэр гараагүй гэсэн мэдээ хүлээн авсан тохиолдолд Нийслэлд удирдлагын төвийн холбогдох албан тушаалтан, орон нутагт холбогдох албан тушаалтан буцах шийдвэр өгөөгүй бол дуудлага өгсөн газар заавал хүрэлцэн очих үүрэгтэй.

24. Гал түймрийн дуудлагаар яваа үед өөр гал түймэр гарч байвал гал түймэр унтраах удирдагч нь гал унтраах зориулалтын мотопомп, хөөрөгтэй бол нэг автомашиныг уг гал түймрийг унтраах үүрэг өгөөд хаяг, гаргасан шийдвэрээ удирдлагын төв буюу гал түймэр унтраах аврах анги, хэсэгт нэн даруй мэдэгдэнэ. Хэрэв өөр автомашин байхгүй бол бэлтгэл автомашинаа дуудна.

25. Дуудлагаар яваа үед нэгдүгээр автомашинд ямар нэгэн саатал тохиолдож зогсоход цувааны бүх автомашин зогсож, зөвхөн гал түймэр унтраах удирдагчийн шийдвэрээр цаашид хөдөлгөөнөө үргэлжлүүлэх бөгөөд, харин дагалдан яваа аль нэг автомашин саатаж зогсвол түрүүчийн болон бусад автомашинууд хөдөлгөөнөө үргэлжүүлнэ. Гал унтраах автомашин замд саатаж зогссон шалтгааныг тухайн удирдлагын төв буюу гал түймэр унтраах аврах ангийн дуудлага хүлээн авагчид нэн даруй мэдэгдэнэ.

26. Гал түймэр гарсан газарт төмөр зам, усан болон агаарын тээврээр хүрэлцэн очих үед гал түймэр унтраах аврах анги, хэсгийг авч явах албан тушаалтаны үүрэг:

26.1. Автомашиныг ачих, буулгах үед аюулгүйн болон техникийн бүрэн бүтэн байдлыг хангах, тавцан дээр автомашиныг найдвартай бэхлүүлэх

26.2. Автомашин тус бүрийг жолоочоор нь сахиулах буюу шаардлагатай бол харуул гаргах

26.3. Бие бүрэлдэхүүнийг нэг дор байлгах, өвлийн улиралд дулаан байранд байрлуулах

26.4. Шүхэрчдийн буултын аюулгүй байдал, газардах цэг, салхины хурд, чиглэлийг найдвартай хангах

27. Гал түймрийн дуудлагаар гарсан гал түймэр унтраах аврах анги, хэсгийн хүч хэрэгслийн тооцоог 1 дүгээр, мэдээллийн болон захирамжийн тооцоог 2 дугаар, хүч нэмэгдүүлсэн болон автомат дуудлагыг 4 дүгээр хавсралтад зааснаар тус тус гүйцэтгэнэ.

### **Гал түймрийн нөхцөл байдлыг тодорхойлох хайгуулын ажиллагаа**

28. Гал түймрийн нөхцөл байдлыг тодорхойлох хайгуулын ажиллагааг /цаашид хайгуул гэнэ/ гал түймрийн дуудлагаар гарч голомтонд хүрэлцэн очсоноос хойш гал түймрийг бүрэн унтрааж дуусах хүртэл хугацаанд явуулна.

Гал түймрийн нөхцөл байдлыг тодорхойлох нь тухайн цагийн байдалд үнэлгээ өгч, гал түймэр унтраах аврах анги, хэсгийн үйл ажиллагааг зохион байгуулах шийдвэр гаргахад чиглэгдэнэ.

Хайгуулын ажиллагааны үр дүн нь гал түймрийн тархалтад нөлөөлөх, таслан зогсоох хүчин зүйлүүдэд тал бүрийн судалгаа хийж, үнэн зөв үнэлгээ дүгнэлт өгч гал түймэр унтраах үйл ажиллагааны зөв хувилбарыг сонгон авч бүрэн унтрааснаар хангагдана.

29. Объектын болон ой, хээрийн гал түймрийн хайгуулын ажиллагаа, эргүүлийн нислэг, бага оврын нисэх төхөөрөмжөөр дараах зүйлсийг тогтоох үүрэгтэй. Үүнд:

29.1. Хүмүүсийн байршил, тэдгээрт учирч болох аюул, аврах арга хэрэгсэл, зам гарцын байдал

29.2. Объектын болон ой, хээрийн гал түймрийн үеийн салхины чиглэл, түймрийн тархалтын хурд

29.3. Гал түймэрт юу шатаж байгаа болон гал түймрийн голомт, тархалтын талбай, чиглэл

29.4. Гал түймэр унтраах үйл ажиллагаанд хүн хүч, хэрэгслийг байрлуулах бололцоотой зам гарц, чиглэлийг тогтоох

29.5. Тэсэрч дэлбэрэх, хордуулах, нуралт үүсэх, цахилгаан гүйдэл бүхий тоног төхөөрөмж, цахилгаан шугам сүлжээний байдал, хялбар авалцан асах шингэлэг байгаа эсэх

29.6. Эд материал аврах, тэдгээрийг гал түймэр, ус, утаанаас хамгаалах шаардлага байгаа эсэх

29.7. Барилга байгууламжийн хийц бүтээцэд задаргаа хийж болох газар, шаардлага бий эсэх

29.8. Гал түймэр унтраах байнгын тоног төхөөрөмж, тэдгээрийг ажиллуулах боломжтой эсэх

29.9. Ойролцоо усны эх үүсвэр, тэдгээрийг ашиглах боломж, хайгуул, эргүүлийн нислэгийн явцад цагийн байдлаас хамаарч өөр үүрэг, зорилтыг шийдвэрлүүлэхээр давхар үүрэг өгч болно.

30. Гал түймрийн хайгуулын ажиллагаа, эргүүлийн нислэгийг гал түймэр унтраах удирдагч (ГТУУ) биечлэн эсвэл түүний томилсон хүмүүс, гал түймэр унтраах аврах анги, нисэн ажиглагч, бүлэг, хэсгийн дарга нар удирдан гүйцэтгэнэ.

31. Гал түймрийн хайгуулын ажиллагаа, эргүүлийн нислэгийн бүрэлдэхүүнд:

31.1. Гал түймэр унтраахаар нэг тасаг, хэсэг хүрэлцэн ирсэн бол гал түймэр унтраах удирдагч, тасаг, хэсгийн дарга, холбоочин

31.2. Гал түймэр унтраахаар хоёр буюу түүнээс дээш тооны тасаг, хэсэг хүрэлцэн ирсэн бол гал түймэр унтраах удирдагч, нэгдүгээр тасаг, хэсгийн дарга, холбоочин орно.

32. Гал түймэр гарсан газар хүрэлцэн ирэхэд нэгэн зэрэг хэд хэдэн чиглэлд гал түймрийн хайгуулын ажиллагаа хийх шаардлага гарвал хайгуулын хэд хэдэн хэсгийг зохион байгуулж ажиллуулна.

32.1. Гал түймрийн хайгуулын ажиллагааны хэсэг бүрийг салааны захирагч, тасгийн даргаас доошгүй албан тушаалтан ахлах бөгөөд хоёр буюу түүнээс дээш албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулна.

32.2. Харин утаа, хорт хий бүхий өрөө, тасалгаануудад хорт хий, утаанаас хамгаалах багтайгаар хайгуул хийх бол гурав буюу түүнээс дээш хүний бүрэлдэхүүнтэй байх ёстой.

33. Гал түймэр гарсан барилга байгууламжид хүн байгаа тухай мэдээ авсан үед яаралтай аврах, тусламж үзүүлэхийн тулд гал түймрийн хайгуулын бүрэлдэхүүний тоог нэмэгдүүлнэ.

34. Нэгэн зэрэг хэд хэдэн чиглэлд гал түймрийн хайгуул зохион байгуулах үед гал түймэр унтраах удирдагчийн /ГТУУ/ үүрэг:

34.1. Гал түймрийн хайгуулын хэсэг болон тэдгээрийн бүрэлдэхүүний тоог тогтоох

34.2. Барилга байгууламж, орон сууцны давхар хонгил, зэргэлдээх өрөө тасалгаанд, гал түймрийн хайгуулыг зэрэг зохион байгуулах

34.3. Хайгуулын хэсгийн ахлагч нарыг томилж, гүйцэтгэх ажлын чиглэлээр тодорхой үүрэг өгөх.

34.4. Гал түймрийн тархаж байгаа гол чиглэлд хийх хайгуулыг биечлэн удирдах

34.5. Мэдээлэл дамжуулах дараалал тогтоох

34.6. Гал түймрийн хайгуулын хэсгийн ашиглаж болох техник хэрэгсэл, бие бүрэлдэхүүний аюулгүй ажиллагааг хангах.

34.7 ГТУУ нь хайгуул хийсний үндсэн дээр шийдвэрлэх чиглэлийг өгнө.

35. Гал түймрийн хайгуул хийх бие бүрэлдэхүүний үүрэг:

35.1. Гал түймрийн голомт руу аюулгүй байдлаа хангаж очих

35.2. Барилга байгууламжийн хийц бүтээц, төлөвлөлт, үйлдвэрийн тоног төхөөрөмж, технологийн горим, газар орны онцлог шинж чанарыг сайн мэдэх иргэн, албан тушаалтны мэдээллийг ашиглах

35.3. Иргэдийн аюулгүй байдлыг ханган, аюулгүй бүсэд гаргаж, гал түймэрт өртсөн иргэдэд анхан шатны тусламж үзүүлэх

35.4. Гал түймрийн шатлагын тархалтыг таслан зогсоох, утаажилтийг багасгах арга хэмжээ авах

35.5. Үнэт материал, тоног төхөөрөмжийг эвдрэл, нуралтаас хамгаалах арга хэмжээ авах

35.6. Шатлага, утаа тархан дэлгэрэх боломжтой барилгын хийц бүтээц зам, өрөөнүүдийг сайтар шалгах, задаргаа хийх

35.7. Гал түймрийг унтраах явцад шуурхай штаб, гал түймэр унтраах удирдагчтай байнгын холбоо барьж, хайгуулын үр дүнг илтгэж байх

35.8. Шатлагын шинж тэмдэг илэрхий байгаа үед хайгуулыг хоолой шугам дэлгэхтэй зэрэг явуулж болно.

36. Гал түймрийн хайгуулын аюулгүй байдлыг хангахын тулд дараах зарчмыг баримтална. Үүнд:

36.1. Гал түймрийн хайгуул хийж буй бүрэлдэхүүн дулаан мэдрэгч, аврах олс, барилгын хийц бүтээцэд задаргаа хийх гар багаж, энгэрийн гэрэл, холбооны хэрэгсэл, галд тэсвэртэй бүтээлэг хорт хий, утаанаас хамгаалах багийг авч явах.

36.2. Утаа ихтэй байранд орох орцны дэргэд аюулгүйн хэсгийг томилж байнгын холбоо барьж байх.

36.3. Хорт хий, утаанаас хамгаалах багтай ажиллаж байгаа бүрэлдэхүүний ээлжийг солих хэсгийг бэлтгэн, нөөцийг хангах.

36.4. Хайгуулаар тогтоосон зам гарцыг судлан тогтоох

36.5. Шатаж буй өрөөний хаалгыг онгойлгохдоо халуун хий, дөлөнд түлэгдэхээс сэргийлж аюулгүй байдлаа хангах.

36.6. Хялбар авалцан асах шингэлэг, тэсэрч дэлбэрэх бодис, шатамхай хий бүхий байр, тасалгаанд ил гал хэрэглэхгүй байх.

36.7. Өндөр хүчдэл бүхий цахилгаан тоног төхөөрөмж, тэсэрч дэлбэрэх, хордуулах бодис, материал бүхий байр, тасалгаанд орохдоо эдгээр байр тасалгааг хариуцсан хүмүүс, техникийн албаны ажилтнуудын өгсөн зөвлөмжийн дагуу урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээ авсаны дараа орох.

36.8. Барилга байгууламжийн хийц бүтээц, нурж унах аюулаас урьдчилан сэргийлж даацын хана дагуу явж ажил үүрэг гүйцэтгэх.

#### **Гал түймрийн үед хүмүүсийг аврах**

37. Авралтын ажлыг дараах нөхцөл байдалд зохион байгуулж явуулна.  
Үүнд:

37. 1. Хүмүүст гал түймрийн ил дөл, өндөр температур шууд нөлөөлсөн буюу тэдгээрийн байгаа байр, тасалгаа нь утаа, хорт хийгээр дүүрсэн үед

37. 2. Хүмүүс аюулгүй бүс рүү бие дааж гарч чадахгүй болсон байвал

37.3. Гал түймрийн шатлага, утаа нь аврах зам гарцаар тархан дэлгэрч аюул учруулахаар болсон байвал

38. Гал түймрийн үед хүмүүсийг аврах ажлыг гал унтраах хүн хүч, хэрэгслийн төвлөрөлт, гал унтраах тархалттай нэгэн зэрэг явуулах бөгөөд ой, хээрийн түймрийн үед айл өрх, иргэдийг аврах, түймэр унтраах ажлыг нэгэн зэрэг явуулах хүн хүч, хэрэгсэл хүрэлцэхгүй байвал гал түймэр унтраах бүх бүрэлдэхүүнийг зөвхөн айл өрх, иргэдийг аврах ажилд оруулахын зэрэгцээ холбогдох мэргэжлийн албадыг татан оролцуулна

38.1. Гал түймэр нь хүмүүст илэрхий аюул учруулж байгаа болон авралтын зам нь галын дөл, утаанд автагдсан буюу автагдахаар байвал авралтын аюулгүй байдлыг хангах зорилгоор заавал хушуугаар ус өгөх.

38.2. Хэрэв хүмүүсийг аврах, гал түймэр унтраах ажлыг нэгэн зэрэг явуулах хүн хүч, хэрэгсэл хүрэлцэхгүй байвал гал түймэр унтрааж буй бүх бүрэлдэхүүнийг зөвхөн хүмүүсийг аврах ажилд татан оруулахын зэрэгцээ нэмэлт хүн хүч, хэрэгслийг дуудна.

38.3. Гал түймэр унтраах удирдагч болон авралтын ажлыг зохион байгуулж байгаа албан тушаалтан, тусламж үзүүлэх шаардлагатай хүмүүсийн биеийн байдал, тухайн нөхцлөөс хамааран хүмүүсийг аврах дэс дараалал, аргыг тодорхойлно.

39. Хүмүүсийг аврах үндсэн аргууд:

39.1. Аврах зам, гарц галын дөл, утаагаар таслагдаж, аврах бусад аргыг хэрэглэх боломжгүй болсон үед аврагдаж буй хүнийг барилгын гадна талын байнгын буюу зөөврийн шат, автомеханик шат, авто өргөгч, аврах олс болон авралтын бусад төхөөрөмж, хэрэгслийн тусламжтайгаар харин ой, хээрийн түймрийн үед агаарын хөлгийг ашиглах

39.2. Аюулгүй бүс, чиглэлд хүмүүсийг гаргах

39.3. Өөрөө явах чадваргүй хүнийг тэврэх, үүрэх бусад боломжтой аргаар гаргах



39.4. Хүүхэд, хөгшид, өвчтэй иргэдийг аюултай бүсээс гаргахдаа аврагч, гал сөнөөгчийг дагалдуулан түүний хяналтанд байнга байлгах.

40. Авралтын ажлыг явуулахдаа:

40.1. Хүмүүсийг үймээн сандралд оруулахгүй байх арга хэмжээг авч, дотоодын болон бусад мэдээлэх хэрэгслийг ашиглах

40.2. Энэ ажилд тухайн байгууллага, аж ахуйн нэгжийн ажилчин, албан хаагчид, сайн дурын туслах хүчин, мэргэжлийн албадыг татан оролцуулах

40.3. Эмнэлгийн яаралтай тусламж дуудаж, түүнийг хүрэлцэн ирэх хүртэл, гал түймэр унтраах аврах ангийн бие бүрэлдэхүүний хүчээр аврагдсан хүмүүст анхан шатны тусламж үзүүлэх

40.4. Аврагдсан хүмүүсийг байрлуулах газрыг урьдчилан тогтоох

#### **Гал түймэр унтраах тархалт**

41. Гал түймэр унтраах тархалтыг аврах үйл ажиллагаанд саад болохооргүй зохион байгуулах.

42. Гал түймэр унтраах тархалт гэдэг нь хүн хүч, гал түймэр унтраах бодис, техник багаж хэрэгслийг нэгтгэн төвлөрүүлж галын голомтод хүргэхэд бэлэн болгохыг хэлнэ.

Гал түймэр унтраах тархалт нь дараахь үе шатаас бүрдэнэ. Үүнд:

42.1. Гал түймэр унтраах тархалтад бэлтгэх

42.2. Урьдчилсан тархалт

42.3. Бүрэн тархалт

43. Тархалтад бэлтгэх үйл ажиллагааг гал түймэр гарсан газар хүрэлцэн ирсэн гал түймэр унтраах аврах анги, хэсгийн томилгоот ээлж нь хайгуултай нэгэн зэрэг явуулж дараах үйлдлийг гүйцэтгэсэн байна. Үүнд:

43.1. Гал унтраах автомашиныг усны эх үүсвэр дээр байрлуулж (ус тээвэрлэгчтэй холбох) сорох хоолойг залган хөөрөгт ус соруулсан байх

43.2. Гал түймэр унтраах багаж зэвсэглэмжийн бэхэлгээг тайлах

43.3. Тухайн орчин нөхцөлд зохицуулсан бусад арга хэмжээний бэлтгэлийг хангасан байх

43.4. Шүхэрээ аль болох хурдан эвхэж, ой, хээрийн түймрийн тархан дэлгэрч байгаа чиглэлд авах арга хэмжээг хангах

44. Гал унтраах автомашиныг усны эх үүсвэр дээр байрлуулахгүйгээр гал түймэр унтраах тархалтын бэлтгэлийг дараах дарааллаар хийнэ.

44.1. Хөөргийг ажлын байрлалд бэлтгэж залгасан байх

44.2. Гал унтраах хоолой шугамыг дэлгэж, хушууг залгаж хөөрөгний даралтын тотгонд холбох

45. Гал түймэр гарсан газар хүрэлцэн ирсэн тасаг, томилгоот ээлж нь урьдчилсан тархалтыг хийхдээ гал унтраах хоолойн төв шугамыг дэлгэх чиглэлийг гал түймрийн байдалд үнэлгээ өгч, тасаг, томилгоот ээлжийг тосч угтсан хүн тархалт хийх чиглэлийг зааж өгсөн тохиолдолд гүйцэтгэж болно. Урьдчилсан тархалтыг дараах дарааллаар хийнэ. Үүнд:

45.1. 43 дугаар зүйлд заасан ажлыг гүйцэтгэх

45.2. Гал унтраах хоолойн төв шугам дэлгэж, салаа билчирийг байрлуулан хоолой, хушуу, шат зэрэг гал унтраахад шаардагдах багаж хэрэгслийг бэлэн болгосон байх

45.3. Ой, хээрийн түймрийн зурвасаар ус өгөх, цурав тавих бусад багаж хэрэгслийг бэлэн болгож, газар орон, цаг агаарын нөхцөл байдлыг судалсан байх.

46. Гал түймэр гарсан газар хүрэлцэн ирмэгц гал түймрийн байдалд үнэн зөв үнэлгээ өгч, гал унтраах тархалтад бэлтгэх буюу урьдчилсан тархалт хийсний дараа бүрэн тархалтыг гүйцэтгэнэ.

Ой, хээрийн түймэр гарсан газар хүрэлцэн ирмэгц гал түймрийн нөхцөл байдлыг үнэлж, гал унтраах багаж хэрэгслийг бэлтгэн бүлгийн ажиллах дарааллыг тогтоосны дараа гал түймэр унтраах ажлыг эхлүүлнэ.

47. Гал түймэр унтраах тархалтын үед шүхэрчин гал сөнөөгч, хушуучин гал сөнөөгч нь гал түймрийн голомтод хамгийн ойр аюулгүй байрлалыг сонгож авсан байвал зохино. Хэрэв хушуучин гал сөнөөгч байрлах газраа хүрэх боломжгүй байвал барилгын хийц бүтээцэд задаргаа хийх замаар буюу автомеханик шат, авто өргөгч зэргийг ашиглаж болно.

48. Гал түймэр унтраах тархалт хийхдээ гал унтраах автомашин бусад төхөөрөмж, багаж хэрэгслийг дараах байдлаар байрлуулна. Үүнд:

48.1.Нэмэгдэл дуудлагаар ирж буй машин техникийг байрлуулахад саад болохооргүй байх

48.2.Шаардлагатай хэсэгт хүч хэрэгслийг богино хугацаанд төвлөрүүлэх бололцоог хангасан байх

48.3.Гал түймэр гарсан газрын ойролцоох гудамж, замын хөдөлгөөнийг аль болох саатуулахгүйгээр хоолойн шугамын хамгаалалтыг хийх

48.4.Нөөц машин техникийн байрлалыг гарган дараагийн гал түймрийн дуудлагад саадгүй гаргах боломжийг хангах

48.5.Гал түймрийн нөхцөл байдлаас шалтгаалан техник, зэвсэглэмжийг шилжүүлэн байрлуулахад саад болохооргүй байлгах

49. Гал түймрийн байдалд үнэлгээ өгч автомеханик шат болон авто өргөгч, эвхдэг шат, довтолгооны шат, гурав сунадаг шатыг барилгын давхар, дээврийн хөндий, дээвэрт байрлуулах тохиолдолд дараах нөхцлийг хангана.Үүнд:

49.1. Довтолгооны шатыг барилгын давхарт цонх, тагт дамжин орох, гурав сунадаг, автомеханик шат болон авто өргөгчтэй хавсран хэрэглэх. Мөн эвхдэг шатыг өрөө, тасалгаан дотор буюу барилгын нэгдүгээр давхарт нэвтрэн ороход ашиглах

49.2. Гурав сунадаг шатыг барилгын гадна, дотор (тухайлбал томоохон тасалгаа, байгууламж зэрэгт) ашиглах

49.3. Шатыг гал түймрийн тархалтын үед галын дөлд хайрагдахааргүй газрыг сонгож байрлуулах

49.4. Шатыг утаа, дөл гарч буй цонх руу сунгаж тавих шаардлага гарвал заавал усны хушуу ажиллуулж хамгаалах

50. Шатыг байрлуулсан газраас өөр байранд шилжүүлэх шаардлага гарвал энэ тухай уг шатаар гараад ажиллаж байгаа бүрэлдэхүүнд урьдчилан мэдэгдэж, шатыг хаана байрлуулахыг зааж өгсөний дараа гүйцэтгэнэ.

#### **Гал түймрийг унтраах тухай**

51. Гал түймрийг унтраах үед гарах хүндрэл:

51.1. Хүмүүс олноор цугларсан, айж сандран тэвдэж, тусламж хүссэн

51.2. Гал гарсан объектод хүрэлцэн очиход замын хөдөлгөөны ачаалал их байх, барилга байгууламжийн орчимд гал унтраах автомашин байрлуулах зай талбай багатай зэргээс шалтгаалж цаг хугацаа алдах

51.3. Барилгын өрөө, тасалгааны төлөвлөлтийн схем байхгүй, гал түймрийн голомтод очиход төвөгтэй байх

51.4. Барилгын хийц бүтээцийн хөндий, цонх, тагт, агааржуулалтын суваг, шатах материалаар дамжин гал түймэр тархан дэлгэрэх

51.5. Агаарын дулааны хэт өсөлт, дулааны урсгал нь онгорхой зай хэсгээр эрчимтэй тархах

51.6. Бодис, материал нь дулааны үйлчлэлээр задарч хий болон уурын хольц үүсгэх

51.7. Утаа болон хорт хий эрчимтэй ялгарах.

51.8. Тоног төхөөрөмж, цахилгаан гүйдлийн шугам хүчдэлтэй байх.

51.9. Даралттай аппарат, сав, баллонууд халалтаас дэлбэрэх.

51.10. Барилга байгууламжийн хийц бүтээц, технологийн тоног төхөөрөмж эвдэрч нурах.

51.11. Үнэт материал, шинжлэх ухаан болон түүхийн өв, олдвор хадгалагдсан байх.

51.12. Цаг агаарын хүндрэлтэй үед хүн хүч, машин, техник хэрэгсэл хүрэлцэн очих боломжгүй нөхцөлд гал түймэр гарсан байх.

51.13. Ой, хээрийн түймрийн голомтод салхины хүч их, айл өрх, мал амьтан олноор нутагласан, газар орон нь бартаа саад ихтэй, түймрийн тархан дэлгэрэлтийн талбай ихэссэн байх.

51.14. Олон нийтийн эмх замбараагүй байдал үүсч санаатай галдан шатаалт, террорист халдлага болох. Тухайн нөхцөлд үүрэг гүйцэтгэж байгаа бүрэлдэхүүнийг өөрийгөө хамгаалах хэрэгслээр хангах

52. Гал түймрийн тархалтыг зогсоож, унтрааж дуусах ажиллагаа нь дараах нөхцөлөөр хангагдана. Үүнд:

52.1. Шатаж байгаа материалын гадаргууг хөргөх.

52.2. Шатлагын бүсэд буюу орчинд нь үл шатах хий, уур бий болгох.

52.3. Шаардлагатай хүн хүч, хэрэгслийг богино хугацаанд төвлөрүүлэн ажиллуулах

52.4. Хушуучин гал сөнөөгч ажиллах байрлалаа хурдан эзэлж хушууг чадамгай, сэлгэн ажиллуулах.

52.5. Гал түймэр унтраах (ус, хөөс, нунтаг, бусад) бодисыг тасралтгүй өгөх.

52.6. Барилгын хийц бүтээцэд задаргаа хийх замаар тусгаарлах зай, завсар гаргах.

52.7. Ой, хээрийн түймрийг цурманд оруулснаар гал түймрийг тархан дэлгэрэх нөхцлийг таслан зогсоосонд тооцно

Ой, хээрийн түймрийг бүрэн унтрааж дууссаны дараа орон нутгийн удирдах албан тушаалтантай цурмыг хүлээлцсэн акт үйлдсэнээр түймрийг бүрэн унтраасанд тооцно.

53. Гал түймрийг унтраахад шийдвэрлэх чиглэлд анхны хушуугаар цаг алдалгүй гал түймэр унтраах бодис өгч чадсан эсэхээс ихээхэн шалтгаална.

Шүхэрчин болон хушуучны байрлал гэдэг нь гал сөнөөгчийн байрласан газрыг хэлнэ.

54. Гал түймэр унтраах үйл ажиллагааны шийдвэрлэх чиглэл гэдэг нь хүмүүст аюул учруулах байдал бий болсон, тэсрэлт, дэлбэрэлт үүсч болох, гал түймрийн тархалт идэвхтэй явагдаж байгаа буюу өөрөөр хэлбэл тухайн нөхцөлд гал түймрийг богино хугацаанд хохирол багатай унтраах чиглэлийг хэлнэ.

55. Гал түймэр унтраах үйл ажиллагааны шийдвэрлэх чиглэлийг тодорхойлохдоо дараахь үндсэн зарчмыг баримтлана.

55.1. Гал түймэр нь хүмүүст аюул учруулж тэдгээрийг гал унтраах ус, хөөсний хушуу ажиллуулахгүйгээр аврах бололцоогүй тохиолдолд гал түймэр унтраах гол хүч, хэрэгслээ авралтын ажлыг хангахад чиглүүлэн ажиллуулах.

55.2. Гал түймрийн үед тэсэрч, дэлбэрэх аюул учирсан тохиолдолд уг чиглэлд /хэсэгт/ хүн хүч, хэрэгслээ төвлөрүүлж ажиллуулах.

55.3. Шатлага нь бие даасан барилга байгууламжийг хамарч зэргэлдээх объектод гал түймэр тархах аюул тохиолдсон нөхцөлд хүч, хэрэгслээ идэвхтэй шатлага явагдаж буй хэсэгт төвлөрүүлж ажиллуулах.

55.4. Гал түймэрт автагдсан барилга, объект нь онцгой үнэт зүйл биш, харин зэргэлдээх объектод гал түймэр тархан дэлгэрэх аюул учирч буй тохиолдолд гал түймэрт шатаагүй барилга, объектыг хамгаалах зорилгоор гал түймэр унтраах хүч, хэрэгслээ зохион байгуулж ажиллуулах.

55.5. Ой, хээрийн түймэр нь хурдацтайгаар тархан ойн баялаг, хот суурин газар, мал, ан амьтанд аюул занал учруулж улмаар аймаг, улсын хил давахаар тархаж байгаа чиглэлд хүч, хэрэгслээ төвлөрүүлж ажиллах.

56. Гарсан гал түймрийг тухайн байгаа гал түймэр унтраах аврах ангийн хүч, хэрэгслээр унтраах бололцоогүй үед ажилчин, албан хаагчид, иргэд, Хилийн цэрэг болон Зэвсэгт хүчин төв орон нутгийн Цагдаагийн байгууллага Төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалах алба, мэргэжлийн албадын бие бүрэлдэхүүн, тэдгээрийн техник зэвсэглэмж бие бүрэлдэхүүнийг оролцуулан барилга байгууламжийн хийц бүтээцийг задлах, гал түймрээс тусгаарлах, зай завсар гаргах зорилгоор шатамхай бодис материалыг зөөж зайлуулах зэрэг яаралтай арга хэмжээ авбал зохино

57. Аврах тусгай анги, гал түймэр унтраах аврах анги, Аврах анги, Эрэн хайх аврах анги, салбар, тасаг, хэсгийн бие бүрэлдэхүүн нь гал түймэр унтраах удирдагч, хэсгийн даргын зөвшөөрөлгүйгээр хариуцсан гал түймэр унтраах хэсгийг орхиж болохгүй.

58. Гал түймрийг унтраахын тулд гал түймэр унтраах бодисыг (ус, хөөс, хий, нунтаг, бусад) үр ашигтай зарцуулахын зэрэгцээ гал унтраах гадна, дотуур усан хангамж бусад гал унтраах байнгын тоног төхөөрөмжийг ажиллуулна.

59. Хорт хий утаа ихээр ялгарсан амьсгалахад хүнд орчинд гал түймэр унтраахад хүчилтөрөгч бүхий хорт хий, утаанаас хамгаалах баг, утаа сорогч, гэрэлтүүлгийг хэрэглэнэ.

60. Бие бүрэлдэхүүнийг шатаж байгаа барилга байгууламжийн дээвэр, давхар дундын хучилт, тэдгээрийн дор болон нуранги, цурманд төвлөрүүлэн ажиллуулахыг хориглоно.

61. Барилгын хийц бүтээцийг задлах ажлыг дараахь зорилгоор гүйцэтгэнэ.

61.1. Хүний амь бие, эд хөрөнгийг аврах боломжийг хангах.

61.2. Шатлагын далд голомтыг илрүүлэх.

61.3. Унтраах бодисыг үр ашигтай зарцуулах.

61.4. Гал түймрийн тархалтыг таслан зогсоох.

61.5. Утаа, хорт хийг гаргах.

61.6. Нуралтын аюулыг бууруулах.

61.7. Барилгын дотор талд нэвтрэн орох болон гал түймрийн голомтод ойртох.

62. Гал түймэр гарсан барилга, байгууламж, гэр орон сууцны цахилгаан хүчдэл бүхий шугамын утас, тоног төхөөрөмжийн гүйдлийг тэжээлийн эх үүсвэрээс салгасаны дараа гал унтраах үйл ажиллагааг явуулна.

63. Гал түймэр унтраах үед их хэмжээний ус зарцуулахгүй байхын тулд дараах зарчмыг баримтална.

63.1. Барилгын доторх гал түймрийг унтраахад хаалттай буюу цацруулагч хушуугаар гал түймэр унтраах бодисыг өгөх.

63.2. Гал түймрийн голомтод ус өгөх шаардлагагүй болсон үед усыг хаах буюу барилгын гадна тал руу хушууг гаргах.

64. Гал түймрийн дөл, дэлгэрэлт нь цаашид хүний амь бие, эд материалд нөлөөлөх аюулгүй, байгаа хүн хүч, хэрэгслээр гал түймрийг бүрэн унтраах бололцоотой болсон, ой, хээрийн түймрийг цурманд бүрэн оруулснаар гал түймрийн тархан дэлгэрэлтийг зогсоосонд тооцож болно. Шатлагыг бүрэн зогсоосноор гал түймрийг унтраасан гэж үзнэ.

#### **Гал түймэр дээр гүйцэтгэх тусгай үйл ажиллагаа**

65. Тусгай үйл ажиллагаанд хүн аврах, амьсгалахад хүнд орчинд ажиллах, утаа зайлуулах, хийц бүтээц задлах, цахилгаан тоног төхөөрөмжийг салгах, гал түймрийн голомт, аврах зам гарцыг гэрэлтүүлэх, илүүдэл уснаас хамгаалах ажлууд орно.

66. Амьсгалахад хүнд орчинд ажиллах:

66.1. Хорт хий, утаанаас хамгаалах хэсгийг (хэсгийн даргыг оролцуулан) нэг төрлийн багтайгаар гурваас таван хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж шаардлагатай тохиолдолд (авралтын ажилд) гал түймэр унтраах удирдагчийн шийдвэрээр хэсгийн бүрэлдэхүүнийг хоёроор нэмэгдүүлэх.

66.2. Хорт хий, утаанаас хамгаалах хэсгийн дарга нь аюулгүйн хэсэгтэй байнгын холбоотой байж түүгээр дамжуулан гал түймрийн нөхцөл байдал болон өөрийн үйл ажиллагааны талаар гал түймэр унтраах удирдагч, хэсгийн дарга, шалган зааварлах хэсгийн дарга нарт илтгэж байх.

66.3. Барилгын газар доорх давхар, их талбайтай хонгилд гарсан гал түймрийн хайгуул хийх, унтраах үед нэгэн зэрэг хоёроос доошгүй хэсгийг ажиллуулна. Энэ тохиолдолд мэргэжлийн өндөр бэлтгэлтэй, амьсгалахад хүнд орчинд ажиллаж байгаа бие бүрэлдэхүүнд богино хугацаанд ямар ч тусламж үзүүлж чадах чадвартай хэсгийг аюулгүйн хэсэгт байрлуулна.

67. Удаан хугацаагаар үргэлжилсэн болон томоохон гал түймрийг унтраах, мөн хорт хий, утаанаас хамгаалах багны хэд хэдэн хэсэг ажиллаж буй үед Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хэмжээнд хорт хий утаанаас хамгаалах талаар дагаж мөрдөх дүрмийн 2 дугаар бүлэгт заасан шалган зааварлах хэсгийг ажиллуулна.

68. Хорт хий, утаанаас хамгаалах багны хэсгийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хэмжээнд хорт хий утаанаас хамгаалах талаар дагаж мөрдөх дүрмийн 2 дугаар бүлэгт заасан албан тушаалтан удирдана

69. Байр, өрөөнүүдийг гэрэлтүүлэхдээ цахилгаан дэнлүү /гэрэлтүүлэг/ хэрэглэнэ. Хэрэв гэрэлтүүлэг хангалтгүй байвал гэрэл холбооны автомашиныг ашиглана. Энэ тохиолдолд байр, өрөөнд орохын өмнө гэрэлтүүлгийг асаасан байна.

69.1. Аврах зам гарцыг гэрэлтүүлэх.

69.2. Тэсэрч дэлбэрэх бодис материалтай өрөөг цонхны гадна талаас гэрэлтүүлнэ. Энэ төрлийн өрөөнд шатлага явагдаж байгаа тохиолдолд зөөврийн хамгаалалттай гэрэлтүүлэг ашиглах.

69.3. Утаажилт ихтэй болон их хэмжээний талбай бүхий өрөө, байранд өндөр хүчин чадалтай зөөврийн гэрэлтүүлэх хэрэгсэл байрлуулна.

69.4. Гэрэлтүүлгийн холболт, шилжүүлэх болон бууруулагч хайрцаг, үүр, шугамын залгалт нь барилгын хийц бүтээцийн уналт, усны тусгалд өртөхөөргүй газар байрлагдсан байвал зохино.

70. Гал түймэр гарсан объектын цахилгаан шугам, тоног төхөөрөмж нь цахилгаан хүчдэлтэй байвал үүсэх хүндрэл:

70.1. Гал түймэр унтраахаар ажиллаж байгаа албан хаагчид цахилгаан гүйдэлд цохиулах.

70.2. Хүчдэлтэй үед нь ус тавихад шатлагын шинэ голомтын аюул үүсэх.

70.3. Хийц бүтээцийг задлах болон гал түймрийг унтраах ажилд саад болох

71. 220 вольт хүртлэх цахилгаан төхөөрөмжийн хүчдэлийг салгахдаа гал түймэр унтраах хэсгийн дарга, гал түймэр унтраах удирдагчийн хяналтын дор бие бүрэлдэхүүн гүйцэтгэнэ.

71.1. Цахилгаан гүйдлийг залгуур, гал хамгаалагч гэх мэт зориулалтын хэрэгслийн тусламжтай салган таслах бололцоогүй нөхцөлд аюулгүй ажиллагааны дүрмийн заалтыг хатуу цахилгаан шугамын утас таслах тусгай зориулалтын хайч хэрэглэнэ.

### ***Дөрөвдүгээр бүлэг***

#### **Гал түймэр унтраах хүн хүч, хэрэгслийг удирдах тухай**

72. Гал түймэр дээр хүн хүч, хэрэгслийг удирдах гал түймэр унтраах удирдагчийн үйл ажиллагаа нь /гал түймэр унтраах шуурхай штаб/ объектын болон ой, хээрийн түймрийн цагийн байдлыг тодруулсны үндсэн дээр гал түймэр унтраах ажиллагааг удирдах зорилготой.

73. Гал түймэр унтраах удирдагч нь:

73.1. Гал түймэр гарсан анхны дуудлагаар гал унтраах нэгжийг удирдан ирсэн албан тушаалтан.

73.2. Улсын онц чухал болон галын аюултай, тэсэрч дэлбэрэх объектод болон 2-оос дээш гал түймэр унтраах анги ажиллаж байгаа гал түймэр дээр төв орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга.

73.3. Хэд хэдэн салаа, тасгийн ажиллагааны үед үйлчлэх хүрээний төв орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга буюу тухайн төв суурин газар, объектод тогтоосон журмын дагуу ахлах дарга нь гүйцэтгэнэ.

74. Гал түймэр унтраах аврах ажиллагаанд оролцож буй төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга, шуурхай удирдлага зохицуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн нар гал түймэр гарсан газар хүрэлцэн ирж, удирдлагыг өөртөө авсныг мэдэгдсэнээр гал түймэр унтраах удирдагчийн үүрэг шилжсэнд тооцно.

75. Гал түймэр гарсан газар хүрэлцэн ирсэн ахлах даргын үүрэг:

75.1. Гал түймэр унтраах үйл ажиллагааны удирдлага зохион байгуулсан байдалд үнэлгээ өгөх.

75.2. Нэмэгдэл хүн хүч, техник хэрэгсэл дайчлан гаргах шаардлага бий эсэхийг тодруулах.

75.3. Гал түймэр унтраах удирдагчийн үүргийг өөртөө авсанаа түрүүчийн гал түймэр унтраах удирдагч болон гал түймэр унтраах шуурхай штаб, арын алба, гал түймэр унтраах хэсгийн дарга нарт мэдэгдэнэ.

76. Гал түймрийн нөхцөл байдалд бодит үнэлгээ өгсөний үндсэн дээр гал түймэр унтраах үйл ажиллагааг удирдахын тулд гал түймэр унтраах удирдагч нь гйл түймэр унтраах шуурхай штаб, гал түймэр унтраах хэсгүүдийг зохион байгуулна.

77. Гал түймэр унтраахаар хоёр буюу түүнээс дээш анги, тасаг, хэсэг ажиллах үед тухайн үйлчлэх хүрээний буюу объектын гал түймэр унтраах аврах ангийн даргалах бүрэлдэхүүнээс арын албаны даргыг томилж ажиллуулна.

#### **Гал түймэр унтраах удирдагч**

78. Гал түймэр унтраахаар хүрэлцэн ирсэн гал түймэр унтраах аврах анги, хэсгийн хүн хүч, техник зэвсэглэмж бусад хүч хэрэгсэл нь зөвхөн гал түймэр унтраах удирдагчид /ГТУУ/ захирагдана. Гал түймэр унтраах удирдагч нь хууль, дүрмийн хүрээнд гал түймэр унтраах үйл ажиллагааг зохион байгуулах, бие бүрэлдэхүүний аюулгүй байдал, техникийн бүрэн байдлыг хариуцна.

79. Гал түймэр унтраах удирдагчийн үүрэг:

79.1. Анхны дуудлагаар хүрэлцэн ирсэн ГТУУ нь салхины чиглэлийг зөв тооцож гал түймрийн нөхцөл байдлыг үнэлэн гал унтраах автомашиныг оновчтой газар байрлуулж хайгуул хийхийн зэрэгцээ хүмүүсийг аврах ажиллагааг байгаа хүн хүч, хэрэгслийг ашиглан нэн даруй зохион байгуулах.

79.2. Гал түймэр унтраах шийдвэрлэх чиглэлийг зөв тодорхойлж шаардагдах хүн хүч, хэрэгслийг тооцоолон гал түймэр унтраах үйл ажиллагааны арга тактикийг тогтоох.

79.3. Аврах, эрэн хайх ажиллагааг зохион байгуулж хайгуул хийх бүрэлдэхүүнийг томилно.

79.4. Гал түймэр унтраах аврах анги, хэсгүүдэд гал түймэр унтраах шийдвэр өгч, тэдгээрийн харилцан ажиллагааг зохион байгуулан, өгсөн үүрэг шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажиллах.

79.5. Гал түймрийн нөхцөл байдлын өөрчлөлтөд байнгын хяналт тавьж, тухай бүр шийдвэр гаргах.

79.6. Гал түймэр дээр хүрэлцэн ирсэн үеэс гал түймрийг унтрааж дуусган ангиудыг байрлалдаа очих хүртэл удирдлагын төв, гал түймэр унтраах аврах анги, хэсэгтэй тасралтгүй холбоо барьж, гал түймрийн дуудлагаар гарах, буцах журмыг баримтална.

79.7. Нэмэгдэл хүн хүч, хэрэгслийг нэгэн зэрэг дуудаж угтах ажлыг зохион байгуулах.

79.8. Удирдах албан тушаалтан хүрэлцэн ирэхэд гал түймрийн цагийн байдал, гаргасан шийдвэр, авсан арга хэмжээ, гал унтраах хүн хүч, хэрэгслийн хүрэлцээ, нэмэгдэл дуудлагаар ирсэн хүн хүч, хэрэгсэл, гал түймэр унтраах бодис, усан хангамжийн талаар танилцуулах.

79.9. Гал түймрийн байдалд үнэлгээ өгсөний үндсэн дээр шуурхай штабыг зохион байгуулж, байрлах газрыг тогтоох.

79.10. Шуурхай штабт өөрийнхөө байрлалыг мэдэгдэж, гаргаж байгаа шийдвэрээ цаг тухайд нь мэдээлэх.

79.11. Гал унтраахад шаардагдах нөөц хүн хүч, техник хэрэгслийг бүрдүүлж удаан хугацаагаар ажилласан бүрэлдэхүүнийг хоол хүнс амрах, дулаацах, хуурай хувцас хэрэгслээр хангах.

79.12. Офицер бүрэлдэхүүнээс аюулгүйн ажиллагааг хариуцсан албан тушаалтанг томилж, шаардлагатай гэж үзвэл эмнэлгийн яаралтай тусламжийг зохион байгуулах.

79.13. Гал түймэр унтраах үйл ажиллагаанд дайчлан оролцуулсан албадын хамтын үйл ажиллагааг удирдлагаар хангаж, төв, орон нутгийн төр захиргааны байгууллага, объектын инженер техникийн ажилтнуудтай байнга холбоотой байж, гал түймэр унтраах шийдвэр гаргахдаа тухайн объектын онцлогыг харгалзсан заавар журмыг мөрдөх.

79.14. Гал түймэр гарсан шалтгаан, гал түймрийн голомтыг илрүүлэн тогтоох, түүнчлэн гал түймэр гарсан болон унтраасан акт тогтооход шаардагдах мэдээ, материалыг бүрдүүлэх нөхцөл бололцоог хангах.

79.15. Гал түймрийг унтрааж дууссаны дараа дахин хайгуул шалгалт хийж, хэргийн газрыг холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэнд хүлээлгэн өгөх хүртэл хамгаалах ажлыг зохион байгуулан, анги, хэсгийн ажиллах хугацаа, буцах дэс дарааллыг тогтоох.

79.16. Ачааны шүхэр ашиглан түймэр унтраахаар бүлгээр буусан шүхэрчдийн шаардлагатай хоол хүнс, багаж хэрэгслийг тооцоолон буулгах.

79.17. Тухайн газар орны байдлаас хамааран түймэр унтраахаар дайчлагдан ирсэн хүмүүсийг сэлгэн байрлуулах ажлыг хариуцах.

79.18. Газар орны байршил, гол мөрөн, нуур, цөөрөм, усан хангамжийн байрлал, салхины хурд, чиглэлийг тооцон түймэр унтраахаар дайчлагдан ажиллаж байгаа хүмүүст мэдээлэн, түймрийн цагийн байдлыг газрын зурагт тэмдэглэл хийх.

79.19. Захиалгаар болон дайчилгаагаар авч ашиглаж байгаа онгоц, нисдэг тэрэг, автомашин техник хэрэгслийн шатахуун, холбоо дохиоллын хэрэгслийн ажиллагааг хянаж нислэгийн үүргийн болон замын хуудсанд тэмдэглэж байх.

80. Гал түймэр унтраах нэмэгдэл хүн хүч, хэрэгслийг тодорхойлохдоо дараах зүйлийг харгалзана.

80.1. Нэмэгдэл хүн хүч, хэрэгсэл хүрэлцэн ирэх хүртэл гал түймрийн тархан дэлгэрэлтийг хязгаарлах хүртэл гал түймэр ямар хэмжээнд тархаж болох.

80.2. Галын хушуугаар ус өгөх, хүмүүсийг аврах, эд хөрөнгийг зөөж гаргах, барилгын хийц бүтээцэд задаргаа хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэхэд шаардагдах тооцоог гаргах.

80.3. Тусгай албаны болон бусад автомашин хэрэглэх шаардлагатай байгаа эсэхийг тодруулах.

80.4. Гал унтраах автомашиныг усаар тасралтгүй хангахад ус зөөвөрлөх, ус дамжуулан шахах шаардлагатай эсэхийг тодруулах.

80.5. Ой, хээрийн түймрийг унтраахад шаардагдах техник тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тооцоог гаргах.



81. Гал түймэр унтрааж байгаа ангиудын анхны байрлалыг өөрчлөх шаардлага гарвал гал түймэр унтраах удирдагч нь байрлал өөрчлөх тухай гаргасан шийдвэрээ анги, салаа, хэсгийн дарга нарт заавал мэдэгдэнэ.

82. Гал түймэр унтраах удирдагчийн өгч байгаа үүрэг нь товч тодорхой байх ёстой. Өгч байгаа үүргийн агуулгаас хамааран гал түймэр унтраах удирдагч нь үүрэг гүйцэтгэгчид биеэр /дохио/ өгөх, шуурхай штаб, холбоо, арын албаны дарга нарт холбоочдоор дамжуулах буюу холбооны техник хэрэгслийг ашиглан өгч болно.

### **Гал түймэр унтраах шуурхай штаб**

83. Гал түймэр унтраах шуурхай штабын бүрэлдэхүүнд штабын дарга, арын албаны дарга болон гал түймэр дээр хамтран ажиллаж байгаа объектын болон орон нутгийн төр захиргааны байгууллага, улсын албадын төлөөлөгч, мэргэжлийн албадын төлөөлөл орно.

Тархан дэлгэрсэн, удаан хугацаагаар үргэлжилсэн гал түймрийн үед шуурхай штабын даргын орлогчийг томилж болно.

84. Гал түймэр унтраах шуурхай штаб байгуулах үндсэн нөхцөл:

84.1. Тархан дэлгэрсэн, удаан хугацаагаар үргэлжилсэн гал түймрийг унтраах үйл ажиллагааны явцад.

84.2. Хоёр буюу түүнээс дээш гал түймэр унтраах аврах анги ажиллаж байгаа, хүч нэмэгдүүлсэн дуудлага буюу дайчилгаагаар хүн хүч, хэрэгслийг байрлуулсан тохиолдолд.

84.3. Объектын захиргаа болон инженер техникийн ажилтнууд, орон нутгийн төр захиргааны байгууллагатай харилцан ажиллах шаардлага бүхий объект, ой, хээрийн түймэртэй тэмцэх ажиллагааны үед.

84.4. Гал түймрийн нөхцөл байдал, онцлогийг харгалзан гал түймэр унтраах удирдагчийн шийдвэрээр.

84.5. Ой, хээрийн түймрийн хил хязгаар тэлж нэмэгдэл хүн хүч, хэрэгсэл шаардагдсан тохиолдолд.

85. Шуурхай штабын үндсэн үүрэг:

85.1. Гал түймэр унтраахаар хүрэлцэн ирсэн анги, хэсэг аврагч, шүхэрчин гал сөнөөгч болон дайчлагдсан хүмүүсийг угтан гал түймэр унтраах хэсгүүдэд хуваарилах.

85.2. Гал түймэр унтраах явцад мэдээллийн ажлыг зохион явуулах.

85.3. Гал түймэр унтрааж байх явцад хайгуулын ажлыг зохион байгуулж, нөхцөл байдал өөрчлөгдсөн тухай бүр гал түймэр унтраах удирдагчид танилцуулж байх.

85.4. Гал түймэр унтраах шуурхай штабын ширээний загвар. /хавсралт 7/

85.5. Гал түймэр унтраах нөөц, хүн хүч, техник хэрэгслийг бэлтгэж бэлэн болгох.

85.6. Гал түймэр гарсан шалтгаан, учруулсан хохирлын талаар мэдээ баримт цуглуулах, байнгын холбоог зохион байгуулах.

85.7. Шаардлага гарвал гал түймэр гарсан газрыг гэрэлтүүлэх.

85.8. Гал түймэр унтраах удирдагчийн тушаал, шийдвэрийг биелүүлэх ажлыг хангах.

85.9. Төв суурин газар, орон нутгийн засаг захиргаа, объектын бусад албадтай харилцан ажиллах ажиллагааг зохион байгуулах.

85.10. Хорт хий, утааны аюулгүйн хэсгийн болон шалган зааварлах байрны ахлагчийг томилох.

85.11. 4 цагаас дээш удаан хугацаагаар үргэлжилсэн томоохон объектын болон ой, хээрийн түймрийн галыг унтраах үед бие бүрэлдэхүүнийг хоолоор, хүйтний улиралд дулаан хувцас, байраар хангах.

85.12. Гал түймэр унтраах шуурхай штаб нь гал түймэр унтраах аврах анги, хэсгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад бололцоотой газрыг сонгон авч байрлах.

85.13. Штабын байрласан газар нь өдрийн цагт “ШТАБ” гэсэн бичигтэй улаан тугтай, шөнийн цагт улаан өнгийн гэрэлтэй байна.

86. Гал түймэр унтраах ажлыг удирдан зохион байгуулж буй гал түймэр унтраах удирдагч, штабын болон арын албаны дарга, холбоочид нь зүүн гарын ханцуй дээр тохойноос дээш газар таних тэмдэгтэй байвал зохино. Тухайлбал:

86.1. Гал түймэр унтраах удирдагч, штабын дарга, арын албаны дарга, гал түймэр унтраах хэсгийн дарга, холбоочны таних тэмдэг / хавсралт №3./

86.2. Бие бүрэлдэхүүний дуулга малгайн дээрх таних тэмдэг / хавсралт №6 /-т зааснаар хийгдсэн байна.

87. Гал түймэр унтраах шуурхай штабын дарга нь гал түймэр унтраах удирдагчид шууд захирагдаж өгсөн үүрэг, тушаалыг хэрэгжүүлэн штабыг удирдаж дараах үүргийг гүйцэтгэнэ.

87.1. Гал түймэр унтраах удирдагчаас гал түймэр унтраах хүн хүч, хэрэгслийг байрлуулах талаар гаргасан шийдвэрийг хүлээн авч хэрэгжүүлэх.

87.2. Гал түймэр гарсан газар хайгуул тасралтгүй хийх, түүнчлэн гал түймэр унтраах хэсгийн дарга нараас авсан мэдээг нэгтгэх замаар гал түймрийн нөхцөл байдалд үнэлгээ өгөх.

87.3. Гал түймэр унтраах удирдагчийн шийдвэрийг анги, гал түймэр унтраах хэсгийн дарга нарт шуурхай мэдээлэх, шаардлагатай үед нэмэгдэл хүн хүч, хэрэгсэл дуудах ажлыг нэн даруй зохион байгуулах.

87.4. Гал түймрийн шуурхай холбоог найдвартай хангах.

87.5. Гал түймрийн нөхцөл байдал, хайгуулын үр дүн, унтрааж байгаа үйл ажиллагааны тухай гал түймэр унтраах удирдагчид илтгэж байх.

87.6. Онцгой тохиолдолд бие даасан шийдвэр гаргаж, гаргасан шийдвэр, биелэлтийн талаар гал түймэр унтраах удирдагчид илтгэх.

87.7. Гал түймэр унтраах удирдагч нь штабын даргын гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавих.

87.8. Гал түймэр дээр хүрэлцэн ирсэн гал түймэр унтраах аврах анги, Аврах тусгай анги, Аврах анги, хүн хүч, хэрэгсэл бэлтгэх.

87.9. Шаардлагатай үед төв орон нутагт ажиллаж байгаа мэргэжлийн албадыг татан оролцуулах харилцан ажиллагааг хангах.

87.10. Гал түймрийн нөхцөл байдлын талаар удирдлагын төвд мэдээлж байх.

87.11. Гал түймрийн шалтгаан, аврах тусгай анги, гал түймэр унтраах аврах анги, аврах анги, эрэн хайх аврах салбарын хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар мэдээ мэдээллийг нэгтгэх.

87.12. Арын алба, холбоочдын хүчээр штабын баримт бичгийг хөтлөх.

87.13. Удаан хугацаагаар үргэлжилсэн объектын болон ой, хээрийн гал түймрийг унтраах үед гал сөнөөгч, шүхэрчдийг сэлгэн солих, хоол хүнс, хувцас хэрэгслээр хангах.

88. Арын албаны дарга нь удирдах албан тушаалын офицер байх бөгөөд гал түймэр унтраах удирдагч, штабын дарга нарт шууд захирагдаж, дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

88.1. Усан хангамжийн хайгуул хийх.

88.2. Гал түймэр унтраах аврах ангиудыг угтан усны эх үүсвэр дээр хуваарилан байрлуулах, гал түймэр унтраах бодис, техник хэрэгслээр хангах.

88.3. Ус дамжуулан шахах, ердийн аргаар ус тээвэрлэх үед хичнээн машин, техник, хоолой шаардагдах тухай тооцоог гарган штабын дарга (гал түймэр унтраах удирдагч)-д илтгэх.

88.4. Гал унтраах автомашин, техник хэрэгслийн хүчин чадлыг бүрэн ашиглах, гал түймэр унтраах бодисоор тасралтгүй хангах арга хэмжээ авах.

88.5. Гал унтраах автомашин, техник хэрэгслийг шатах, тослох материалаар тухай бүр хангаж, шаардлага гарвал гал түймэр унтраах тусгай зориулалтын бодис, материалыг гал түймэр гарсан газарт тээвэрлэн аваачих ажлыг зохион байгуулах.

88.6. Гал түймэр унтраах бодис дамжуулах хоолой шугамыг хамгаалж цагдаагийн байгууллагын алба хаагч нартай хамтран тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах.

88.7. Гал унтраах автомашин, техник, хэрэгсэл гал түймэр унтраах бодис дамжуулах хоолой, хөөс, хорт хий, утаанаас хамгаалах баг, нөөц баллон, бусад бодис материалын тооцоог хөтөлж, төв шугамын хоолойн дэлгэлт, усны эх үүсвэр дээр байрлуулсан техник, хэрэгсэл ой, хээрийн түймрийн хил хязгаар байршлын схемийг тогтоосон таних тэмдгээр үйлдсэн байх (хавсралт №8).

88.8. Усан хангамжийг (төв орон нутаг, объект) холбогдох мэргэжлийн албадтай хамтран зохион байгуулах.

88.9. Ой, хээрийн түймэрт дайчлагдсан машин, техник, хүн хүчийг бүртгэн байрлуулж, ажилд хуваарилах.

88.10. Арын албаны дарга нь гал түймэр унтраах үндсэн албаны автомашинаас гадна илүүдэл уснаас хамгаалах, гал түймэр унтраах бодис дамжуулах хоолой, хорт хий, утаанаас хамгаалах баг тээвэрлэх суудлын буюу ачааны автомашин, шатахуун цэнэглэгч, техникийн засварын болон автобусны нөөцтэй байх ёстой.

88.11. Ар талын ажлыг шуурхай зохион байгуулахын тулд туслагч нарыг томилон ажиллуулна.

89. Гал түймэр унтраах хэсгийн дарга нь гал түймэр унтраах удирдагч, штабын дарга нарт захирагдаж өөрийн хариуцсан хэсэгт гал түймэр унтраах үйл ажиллагааг бүрэн хариуцаж, бие бүрэлдэхүүний аюулгүй байдал, гал унтраах техник хэрэгслийн хэвийн найдвартай ажиллагааг ханган дараах үүргийг гүйцэтгэнэ.

89.1. Гал түймрийн хайгуулыг тасралтгүй хийж, хариуцсан хэсгийн гал түймрийн нөхцөл байдлын талаар гал түймэр унтраах удирдагч, штабын дарга нарт илтгэх.

89.2. Хариуцсан хэсгийн гал түймэр унтраах аврах анги, хэсгийн гал унтраах ажиллагааг удирдах.

89.3. Зэргэлдээх болон хариуцсан хэсэгт ажиллаж буй гал түймэр унтраах аврах анги, хэсгийн харилцан ажиллагааг хангах.

89.4. Гал түймрийн нөхцөл байдлын өөрчлөлтөөс хамааран хүн хүч, хэрэгслийг шилжүүлэн байрлуулах шуурхай арга хэмжээ авахаас гадна ой, хээрийн түймрийн үед дайчлагдсан хүмүүсийн аюулгүй байдлыг хангах.

89.5. Хариуцсан хэсэгтээ гал түймэр унтраах ажлыг богино хугацаанд гүйцэтгэхийн тулд бие даасан шийдвэр гаргаж, энэ тухай гал түймэр унтраах удирдагч буюу штабын даргад илтгэх.

#### **Гал түймэр унтраах үеийн холбооны зохион байгуулалт**

90. Гал түймрийн үеийн холбоог гал түймэр унтраах аврах анги, хэсгийн бүлгийн удирдлагын харилцан ажиллагааг хангах, тэдгээрийг удирдан зохион байгуулах, мэдээлэл дамжуулах зорилгоор ажиллуулна. Гал түймэр унтраах голомтонд ажиллаж байгаа хэсэг бүрийг холбооны хэрэгсэлтэй үүрэг гүйцэтгүүлэх Үүнд:

90.1. Удирдлагын холбоог гал түймэр унтраах удирдагч болон гал түймэр унтраах аврах анги, хэсгийн дарга нарын хооронд мөн гал түймэр унтраах удирдагч болон шуурхай штаб, арын алба, гал түймэр унтраах хэсэг, бусад мэргэжлийн албадын дарга нарын хооронд түүнчлэн төв суурин газар, объектын удирдлага, автомашинуудын хооронд зохион байгуулж ажиллуулах.

90.2. Найдвартай холбоогоор хангахын тулд үүргийн радиостанц, сансрын холбооны болон үүрэн телефоны утас, телефон аппарат, чанга яригч, өсгөгч, гал унтраах автомашины болон гал түймэр гарсан объект, аймаг, сумдын холбоо зэргийг ашиглах.

90.3. Удирдлагын холбоо нь гал түймэр унтраах хэсгийн үйл ажиллагааг удирдах, гал түймрийн нөхцөл байдлын талаар мэдээ, мэдээллийг хүлээн авах

90.4. Мэдээллийн холбоог гал түймэр унтраах удирдагч болон удирдлагын төв нь хээрийн холбооны хэрэгслийг ашиглах.

90.5. Мэдээллийн хэрэгслийг гал түймэр унтраах удирдагч, удирдлагын төв гал түймэр унтраах аврах ангиудын радио, телефон, галын дохиоллын систем ашиглан зохион байгуулах.

90.6. Энэ холбоог удирдлагын төв, аврах, гал түймэр унтраах аврах ангиудын холбооны хэрэгслийг ашиглан гал унтраахаар ажиллаж байгаа, дуудлагаар замд яваа гал түймэр унтраах аврах анги, хэсэгтэй холбоо барих, гал түймрийн нөхцөл байдал, гал түймэр унтрааж буй явцын талаар мэдээлэх, нэмэгдэл хүн хүч, хэрэгсэл дуудах, төв суурин газрын ус суваг, эмнэлэг, цахилгаан шугам сүлжээний газар, цагдаагийн болон бусад мэргэжлийн албадтай харилцах ажлыг хангах.

90.7. Шаардлагатай үед хот, хоорондын болон байгууллага, аж ахуйн нэгжийн харилцах телефон утсыг шууд ашиглах.

#### **Тавдугаар бүлэг**

#### **Объектын болон ой, хээрийн түймрийг унтраах үед бие бүрэлдэхүүний гүйцэтгэх үүрэг**

91. Объектын болон ой, хээрийн гал түймрийг унтраах үеийн бие бүрэлдэхүүний гүйцэтгэх үүрэг:

91.1. Гал түймэр унтраах үед өөрөө болон тасаг, хэсгийн гүйцэтгэх үүргийг сайтар ойлгон хэрэгжүүлж байнга холбоотой ажиллах.

91.2. Гал түймэр унтраахаар ажиллаж байгаа ажлын байраа даргын зөвшөөрөлгүй орхихгүй байх.

91.3. Өгсөн үүрэг тушаалыг биелүүлэхийн тулд идэвх санаачлага, мэргэжлийн ур чадвар гаргаж ажиллах.

91.4. Гал түймэр унтраах үйл ажиллагаанд оролцож байгаа байгаа техник, хэрэгслийг хүчин чадлынх нь дагуу бүрэн ашиглах нөхөртөө туслах.

91.5. Гал түймэр унтрааж буй бусад албан хаагчдад аюул учруулахаар байвал энэ тухай цаг алдалгүй даргадаа гал түймэр унтраах удирдагчид илтгэх, шаардлагатай үед аврах арга хэмжээ авах.

91.6. Гэмтсэн, түлэгдсэн, хордлого авсан хүмүүст эмнэлгийн анхны тусламж үзүүлэх.

91.7. Гал түймэр унтраах үедээ Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг чанд сахиж ажиллах.

91.8. Гал түймэр унтрааж дуусаад өөрийн хариуцсан багаж хэрэгсэл бүрэн байгаа эсэхийг шалгаж энэ тухай шадар даргадаа илтгэх. Ой хээрийн түймрийн дуудлагаар гарсан бүлэг түймрийн голомтод очсон даруйдаа, цаашид 2 цаг тутамд, нөхцөл байдал өөрчлөгдсөн тухай бүрт харьяа газар, хэлтсийн жижүүртэй холбоонд орж, цагийн байдлыг мэдээлж дараагийн үүрэг чиглэл авна.

91.9. Удаан хугацаагаар гамшигийн голомтонд ажилласан албан хаагчдыг нөхөн сэргээх эмчилгээ хийлгэх, амралт сувилалд хамруулах.

91.10. Бүлгийн дарга тухайн орон нутгийн цаг агаар, орон нутгийн нөхцөл байдлыг үнэлэн унтраах ажиллагааг удирдаж ажиллана.

91.11. Тухайн орон нутагт нөхцөл байдал хүндэрсэн үед эрсдэж болзошгүй төв суурин газар, хот айл, ард иргэдийг нэн түрүүнд хамгаална

92. Гал түймрийн хайгуулын бүрэлдэхүүнд орсон шүхэрчин болон аврагч, гал сөнөөгчийн үүрэг:

92.1. Шаардлагатай гал унтраах багаж, зэвсэглэмжийг авч явах.

92.2. Хайгуулын ажлыг удирдаж яваа удирдагчийн үүрэг даалгаврыг чанд биелүүлэх.

92.3. Гал түймрийн хайгуулаар явахдаа орчны байдлыг сайтар ажиглаж, галын голомт, шаталгын явц, зам гарц газардах талбайн онцлог, салхины хурд, чиглэлийг нарийн тогтоох.

93. Гамшиг осолд нэрвэгдэгсдийг аварч байгаа аврагч, гал сөнөөгч, шүхэрчний үүрэг:

93.1. Дарга захирагчийн өгсөн үүргийн дагуу уг хүнийг аврахад зайлшгүй шаардлагатай багаж зэвсэглэмжтэй байх.

93.2. Аврах зам, гарцыг ахлах дарга зааж өгөөгүй бол хамгийн аюулгүй дөт замыг өөрөө сонгохын зэрэгцээ аврагдаж буй хүний аюулгүй байдлыг бүрэн хангах.

93.3. Аврах ажиллагааг явуулахдаа Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг чанд сахих.

93.4. Дулааны өндөр температур, утаажилт ихтэй нөхцөлд авралтын ажиллагааг зайлшгүй хийх бол аварч байгаа хүнээ найдвартай хамгаалж хурдан гаргах.

94. Галын хоолой дэлгэх үеийн гал сөнөөгчийн үүрэг:

94.1. Хушуучны байрлалд нь аль болох тохиромжтой ойр замыг сонгож галын хоолойг дэлгэх.

94.2. Гал унтраах хоолойг шатаж байгаа болон хурц үзүүртэй зүйл, хүчил зэрэг цоорох, түлэгдэх бодис материал бүхий газраар дэлгэхийг хориглох, хэрэв хоолой дэлгэх өөр газар байхгүй бол нимгэн төмөр, банз зэрэг гарын доорх бусад материалыг тавьж дээгүүр нь дэлгэх.

94.3. Гал унтраах хоолойг шат, замыг хааж таглахгүйгээр дэлгэх, шатны хонгилд мөн шатны нугалбарын хоорондуур тотгоноос хоолойн бэхэлгээгээр шатны хийц бүтээцээс бэхэлж дэлгэх.

94.4. Гал унтраах хоолойг аль болохоор гудамж, зам, хашаа, хаалганы дагуу зам гарцыг хөндлөн огтлохгүйгээр, төмөр замтай бол замын рейлсийн доогуур, дэр модны хоорондуур дэлгэх.

94.5. Гудамж, замыг хөндлөн гаргаж дэлгэсэн галын хоолойг гүүрээр хамгаалах, хоолойн гүүргүй үед хөдөлгөөнийг түр хязгаарлах

94.6. Салаа билчирийг гудамж, замын дунд тавих, галын хоолойг мушгиатай гогцооруулан дэлгэх, холбох тотгоор хатуу газар цохих, хашаа, цонх зэрэг бусад саад дээгүүр зөөлөвчгүйгээр шууд тохож хоолой дэлгэхийг хориглоно.

94.7. Хоолойн шугамыг өндөрт буюу босоогоор дэлгэж байгаа үед зориулалтын бэхэлгээгээр заавал бэхлэх.

94.8. Хушуучны хөдөлгөөн, усны цацрагийн тусгалыг хангахын тулд шаардагдах тооны хоолойн нөөцтэй байх.

94.9. Шаардлага гарвал хушуучны дэргэд хоолойн давхар шугам дэлгэсэн байх.

94.10. Барилгын дотор дотортой хоолой хэрэглэх.

94.11. Гал унтраах хоолойн төв шугаманд хяналт тавьж, гэмтэл тохиолдвол тэмдэглэн нөхөөс, хавчаар хэрэглэж хэвийн ажиллагааг хангах.

95. Хушуугаар ажиллаж байгаа гал сөнөөгчийн үүрэг:

95.1. Шатлага эрчимтэй явагдаж байгаа хэсэг, ил дөллөн шатаж байгаа барилгын хийц бүтээцийн гал түймрийг унтрааж, зохих хоолойн нөөцтэйгээр гал түймрийн голомт руу боломжтой зайд ойртох.

95.2. Усны цацрагийг гал түймрийн тархан дэлгэрэлтийг угтуулан өгч юуны өмнө шатлага буюу халалтын улмаас барилга, байгууламжийн хийц бүтээцийн бөх бат чанар алдагдан хэсэгчлэн буюу бүхэлдээ нурж унахаас сэргийлж хөргөлт хийх.

95.3. Босоо гадаргууд гарсан гал түймрийг унтраахдаа усны цацрагийг дээрээс нь доош чиглэлд өгөх.

95.4. Огцом оройтой дээвэр, өндөрт ажиллах, мөн гурав сунадаг буюу эвхдэг шат хэрэглэхдээ өөрийгөө болон хоолой шугамыг найдвартай бэхлэх.

95.5. Цахилгаан хүчдэл бүхий тоног төхөөрөмж, шугамын утсанд ойртох, усыг шууд чиглүүлж тавихгүй байх.

95.6. Шилэн сав буюу хагарах савтай бодист гарсан гал түймрийг унтраахдаа усны нарийн цацраг эсвэл агаар механикийн хөөс хэрэглэх.

95.7. Хялбар авалцан асах шингэлэгтэй резервуар, шахсан хий бүхий баллон, даралттай төхөөрөмж аппарат зэргийг шатлагаас хамгаалахдаа халж буй гадаргууг жигд хөргөх.

95.8. Хөөсний генератороор ажиллахдаа хөөс үүсгэгч сайн нягтарсаны дараа хөөс өгч эхлэх хэрэгтэй бөгөөд харин хатуу, нийлэг, тарж бутрах материалын гал түймрийг хөөсөөр унтраахдаа шатаж байгаа бүх гадаргууг бүрхэхээр генераторыг сэлгэн ажиллах.

96. Барилгын хийц бүтээцэд задаргаа хийж буй гал сөнөөгчийн үүрэг:

96.1. Барилгын хийц бүтээцийн задаргааг ахлах даргын тушаалын дагуу заасан хэмжээнд нь хийх.

96.2. Барилгын хийц бүтээцийг автомат болон механик ажиллагаатай хэрэгслээр задлах

96.3. Гал түймрийн голомтыг унтраахаар барилгын хийц бүтээцэд задаргаа хийхийн өмнө гар хушууг бэлтгэсэн байх.

96.4. Барилгын хийц бүтээцийн задаргааг барилга, тоног төхөөрөмж, эд материалд хамгийн бага хохирол учруулахаар хийнэ.

96.5. Задаргааг төмөр хоолой, арматур, цахилгаан гүйдэл, холбооны шугамыг гэмтээхгүйгээр хийх.

96.6. Хаалга, цонх зэргийг эвдэхгүйгээр онгойлгох, шаардлагатай нөхцөлд бага хэмжээгээр эвдэж задаргааг хийх.

96.7. Онгойдоггүй цонхоор утаа гаргах бол цонхны дээд хэсгийн шилийг хагалах буюу авах.

97. Гал унтраах гадна усны даралтат цэг буюу усны эх үүсвэр дээр ажиллаж байгаа гал сөнөөгчийн үүрэг:

97.1. Усны эх үүсвэрийн байрлалыг судалж, гал түймэр гарсан үед ашиглаж чаддаг байх.

97.2. Гал унтраах хоолой дээгүүр тээврийн хэрэгсэл явахаас хамгаалж хоолойн гүүр тавих, гүүр байхгүй тохиолдолд машин явуулахгүй байх.

97.3. Даргын шийдвэр, хушуучны шаардсанаар хоолойн аль нэг шугамын усыг онгойлгох буюу хааж тохируулах.

97.4. Гал унтраах автомашины жолооч, хушуучин нартай тогтмол холбоо барьж байх.

97.5. Нэмэгдэл дуудлагаар ирж буй гал түймэр унтраах аврах ангийг угтах үүрэг авсан үед тэдгээрийг угтаж, байрлах газрыг зааж өгч, гал түймэр унтраах удирдагчийн өгсөн үүрэг, шийдвэрийг дамжуулах.

98. Холбоочингоор ажиллаж байгаа гал сөнөөгчийн үүрэг:

98.1. Гал түймэр унтраах удирдагчаас өгсөн үүрэг, шийдвэрийг анхааралтай сонсож, лавлах зүйлийг асууж тодруулан бодит мэдээлэл дамжуулах.

98.2. Даргын амаар өгсөн тушаалыг богино хугацаанд зохих хүмүүст үнэн зөв дамжуулан эргэж мэдэгдэх.

98.3. Даргын шийдвэрийн дагуу удирдлагын төв, гал түймэр унтраах аврах анги, хэсгийн дуудлага хүлээн авагчтай телефон утас, дохиоллын хэрэгсэл буюу суурин болон машины радио станцаар байнга холбоо барьж байх.

98.4. Өөртөө телефон утасны жагсаалт, тэмдэглэлийн дэвтэр, харандаа (үзэг), энгэрийн гэрэлтэй байна.

99. Гал түймрийг унтрааж дууссаны дараа хяналтын үүрэг гүйцэтгүүлэхээр харуулаар томилсон үед аврагч, гал сөнөөгч, шүхэрчин дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

99.1. Гал түймэр унтраасан бүх дэвсгэр талбайг хянан үзэж, гал түймрийн голомтыг илрүүлбэл унтраах арга хэмжээ авах, гал түймэр унтраах аврах анги, хэсгийг дуудах.

99.2. Даргын шийдвэргүйгээр хамгаалж буй байр, талбайг орхиж болохгүй бөгөөд явах шийдвэр авсан бол энэ тухай объектын болон орон нутгийн захиргаанд мэдэгдэж гал түймэр гарсан газрыг шалгаж, хяналт тавих талаар албан ёсоор мэдэгдэх.

100. Шүхэрчин гал сөнөөгчийн үүрэг:

100.1. Нисэн ажиглагчийн тооцоо, дохиогоор салбар, хэсгийн зааварлагчийн тушаалаар онгоц, нисдэг тэрэгнээс заагдсан газарт буух.

100.2. Газардах талбайн онцлог, газрын салхины хурд, чиглэлийг нарийн тооцон аюулгүй ажиллагааны дүрэм заавруудыг нягт баримтлан өөрийн аюулгүй байдлыг ханган газардсанаар шүхэр, шүхрийн хэрэгслийг өөрийн биенээс салгаж, аюулгүй газарт хураах.

100.3. Онгоц, нисдэг тэрэгнээс хоол, хүнс, түймрийн багаж зэвсгийг ачааны шүхрээр буулгаж байгаа тохиолдолд зааварлагчийн зөвшөөрлөөр өөрийн хуваарьт багаж, зэвсгийг авч түймрийн хэсэгт хүргэх.

100.4. Түймэр унтраах, цурав тавих явцад зааварлагчийн зөвшөөрөлгүй үйлдэл хийх, дадлага туршлагагүй шүхэрчин гал сөнөөгчөөр цуравдагч, үлээгч аппарат болон моторт хөрөөг ажиллуулахыг хориглох.

101. Гал унтраах автомашины жолоочийн гүйцэтгэх үүрэг:

101.1. Автомашинд бие бүрэлдэхүүн суух журам, гал унтраах техник зэвсэглэмжийн байрлалыг мэддэг, мөрдөн ажилладаг байх.

101.2. Гал унтраах автомашины ашиглалтын заавар, замын хөдөлгөөний дүрмийг чанд мөрдөх.

101.3. Гал унтраах автомашиныг гал түймэр гарсан газарт тээврийн хэрэгсэлд саад болохооргүйгээр сэлгэх боломжтой, аюул учирсан үед хөдөлгөөн хийж болохуйц газар байрлуулах.

101.4. Автомашины бүх механизм, агрегатын найдвартай ажиллагааг хангаж салаа, тасгийн даргын шийдвэр, өгсөн үүргийг хугацаа алдалгүй биелүүлж, автомашинаа орхихгүй байх.

101.5. Автомашиныг усны эх үүсвэр дээр зөв байрлуулж ус, агаар механикийн хөөсийг тасралтгүй өгөх.

101.6. Автомашины радиостанцыг ашиглаж сурсан байх.

101.7. Хөөрөгний усыг даралтын хоолойд шахаж, ажлын даралтыг даргын өгсөн шийдвэрийн дагуу зохих хэмжээнд тохируулж байх.

101.8. Хүйтний улиралд хөөргийг хөлдөхөөс болгоомжилж тасралтгүй ажиллуулах.



101.9. Автомашины шатахуун, ус, агаар механикийн хөөсний нөөцөд тогтмол хяналт тавьж даргад илтгэж байх.

101.10. Автомашины хэвийн ажиллагаа алдагдах, зарим механизм ажиллахгүй болох тохиолдолд даргад илтгэхийн хамт гэмтлийн шалтгааныг нэн даруй тогтоож, засах арга хэмжээ авах.

102. Автомеханик шат, өргөгч механизм ажиллуулж буй жолоочийн үүрэг:

102.1. Автомеханик шат, өргөгч механизм жолоодож явахдаа ялангуяа тойрог замаар явах, гүүр доогуур гарахдаа тэдгээрийн хэмжээ загварыг харгалзах.

102.2. Автомеханик шат, өргөгч механизмыг сунгахдаа дугуйг хатуу хөрс, асфальт зам дээр байрлуулж, сууриудыг сунгаж эдгээр автомашинуудыг сэлгэх боломжтойгоор байрлуулж ажиллуулах.

103. Тасаг, хэсгийн дарга нь томилгоот ээлжийн бие бүрэлдэхүүний шадар дарга бөгөөд гал түймэр унтраах үйл ажиллагааг шууд удирдан дараах үүргийг гүйцэтгэнэ.

103.1. Гал түймрийн дуудлагаар хүрэлцэн ирээд ахлах даргыг ирэх хүртэл биечлэн гал түймэр унтраах ажиллагааг удирдана. Бусад тохиолдолд ахлах даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу ажиллах.

103.2. Гал түймэр унтраах үед тасаг, хэсэгт өгсөн үүргийг зохион байгуулж биелүүлэх.

103.3. Тасаг, хэсгийн өмнө тавигдсан гал түймэр унтраах үүргийг хүн нэг бүрт хүргэх гал түймэр унтраах оноолт номеруудын харилцан ажиллагааг хангах.

103.4. Гал түймэр унтраахтай холбогдуулан өгч байгаа тушаал, шийдвэрийг гал сөнөөгч нэг бүрт хүргэж хэрэгжүүлэн биелүүлэх.

103.5. Гал түймэр унтраах үеийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг хэрхэн сахин биелүүлж байгаад хяналт тавих.

103.6. Захирагч даргатайгаа байнгын холбоо барьж хариуцсан хэсэгт болсон нөхцөл байдлыг тухай бүр илтгэж байх.

103.7. Хариуцсан тасгийн гал унтраах багаж зэвсэглэмжийн найдвартай, үр ашигтай ажиллагааг хангах.

103.8. Радиостанцаар зохих журмын дагуу харилцаж сурсан байх.

104. Гал түймэр унтраах тархалт хийх үед тасаг, хэсгийн даргын гүйцэтгэх үүрэг:

104.1. Гал түймэр унтраах тархалтыг удирдан хамгийн богино хугацаанд багтаан дуусгах.

104.2. Тасаг, хэсгийн бие бүрэлдэхүүнд гал унтраах хоолой дэлгэх арга, чиглэл, ашиглах усны эх үүсвэр, ажлын шугаманд аль болох нөөц хоолой орохоор бодолцож салаа билчир байрлуулах газар, гал унтраах хушууны тоо, хушуучдын байрлал, шат тавих газар, барилгын хийц бүтээцэд хаана ямар хэмжээний задаргаа хийх зэргийг тодорхой зааж өгөх.

104.3. Галын шатыг зөв байрлуулсан эсэхийг биечлэн шалгаж үзсэний дараа гал сөнөөгчдийг зохих хамгаалалттайгаар дээш нь гаргах.

104.4. Гал түймэр унтраах тархалтыг хийж дуусгасан тухай ахлах даргад илтгэх.

105. Ой, хээрийн түймрийг унтраах хэсгийн зааварлагч нь нисэн ажиглагчийн санал болгосноор газардах талбайг агаараас сонгон авахад нь

тусалж, өндөрийн болон газрын салхины хурд чиглэлийг турших шүхрийн тусламжтай тогтоон шүхэрчдийг аюулгүй газардах нөхцлийг хангах үүрэгтэй.

105.1. Нисдэг тэрэг газардах талбай хүрэлцээтэй тохиолдолд нисдэг тэрэг буух, тасрах үед шүхэрчид болон хоол, хүнс, багаж, хэрэгслийг буулгах, нисдэг тэрэгний сэнснээс болгоомжлох бүхий л арга ажиллагааг гардан хариуцна.

105.2. Нисэн ажиглагчтай онгоцны холбоо, үүргэвчийн радиостанцыг ашиглан байнгын холбоотой ажиллана.

105.3. Түймэр унтраахаар дайчлагдан ажиллаж байгаа орон нутгийн иргэд, машин техникийг сэлгэн байрлуулах, амрах, хоноглох байр сонгон авна.

105.4. Гал түймэр унтраах удирдагчтай байнгын холбоотой ажиллаж түймрийн шатлагын явц, унтраах ажиллагаанд хяналт тавин ажиллана.

106. Барилгын хийц бүтээцэд задаргаа хийх:

106.1. Шаардагдах автомат болон гар багаж хэрэгсэл бүхий гал сөнөөгчдийг томилж, задаргаа хийх газар, ажиллах байрыг зааж

106.2. Хэрэв задаргааны ажлыг зөвхөн нэг тасгийн хүчээр хийж байгаа бол задаргаа хийж гаргасан материалыг хураах газрыг зааж өгөх, хэрэв барилгын дээвэр, өндөрт задаргаа хийн, илүүдэл материалыг доош нь буулгах тохиолдол гарвал тусгай хэсэг томилон аюулгүй байдлыг хангах.

106.3. Задаргааны ажлыг зохих зааврын дагуу анхаарал болгоомжтой гүйцэтгэх, тоног төхөөрөмж, материалыг хамгаалах.

106.4. Цахилгаан шугамын утас, тоног төхөөрөмжийн гүйдлийг таслах, химийн бодис, нефть бүтээгдэхүүн дамжуулах шугам хоолойн ажиллагааг зогсоох арга хэмжээ авч, задаргааны ажлын аюулгүй байдлыг хангах.

106.5. Барилгын даацын хийц бүтээцийг эвдэж гэмтээхгүй байхад анхаарах.

107. Эд хөрөнгийг аврах ажлыг явуулах үед тасаг, хэсгийн даргын гүйцэтгэх үүрэг:

107.1. Гал сөнөөгчдөд эд хөрөнгийг аврах дэс дараалал, зам гарц, хураах газрыг зааж өгөх.

107.2. Аварч байгаа эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцан хамгаалах.

108. Гал унтрааж дуусаад багаж, зэвсэглэмжийг хураах команд буюу дохиогоор тасаг, хэсгийн дарга дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

108.1. Тасаг, хэсгийн бие бүрэлдэхүүний ашиглаж байсан гал унтраах багаж зэвсэглэмж бүрэн байгаа эсэхийг шалгах.

108.2. Гал түймэр унтраах удирдагчид гал түймэр унтраах аврах анги, хэсэгт буцахад бэлэн болсоныг илтгэн буцахдаа цувааны дэг журмыг хатуу баримтлах.

109. Гал унтрааж дуусаад гал түймэр унтраах аврах анги, хэсэг буцаж ирсэн тасаг, хэсгийн даргын үүрэг:

109.1. Гал унтрааж дуусаад гал түймэр унтраах аврах анги буцаж ирсэн тасаг, хэсгийг богино хугацаанд бэлэн байдлыг хангуулж энэ тухай удирдах даргадаа илтгэх.

109.2. Гал сөнөөгчид, шүхэрчдийн хөдөлмөр хамгааллын хувцас, хоолойг хатаах, солих зэрэг арга хэмжээг яаралтай авах.

#### **Салааны захирагчийн гүйцэтгэх үүрэг**

110. Томилгоот ээлжийн үүрэг гүйцэтгэж байгаа салааны захирагч гал түймэр унтраах үйл ажиллагааг удирдаж, бие бүрэлдэхүүний хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, техникийн найдвартай үйл ажиллагааг бүрэн хариуцаж, ахлах

дарга хүрэлцэн ирж, удирдлагыг өөртөө авах хүртэл гал түймэр унтраах үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

111. Галын анхны дуудлагаар хүрэлцэн ирсэн томилгоот ээлжийн салааны захирагч нь энэ дүрэмд заасан гал түймэр унтраах удирдагчийн үүргийг гүйцэтгэнэ.

112. Гал түймрийн дуудлагаар яваа салааны захирагчийн үүрэг:

112.1. Автомашины хөдөлгөөн багатай дөт замыг сонгон явах бөгөөд жолооч замын хөдөлгөөний дүрмийг хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих. Автомашин хөдөлгөөний нягтрал багатай баталгаат аюулгүй хүрэлцэн очих замаар сонгон явах

112.2. Гал унтраах шуурхай төлөвлөгөө, карт бусад бичиг баримттай танилцах.

112.3. Удирдлагын төв, гал түймэр унтраах аврах ангийн дуудлага хүлээн авагч, гал гарсан газраас өгч байгаа мэдээллийг анхааралтай сонсож удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангаж байх.

112.4. Гал түймрийн дуудлагаар явж байгаад саатаж зогсвол энэ дүрэмд заасныг удирдлага болгон ажиллах.

113. Гал түймэр унтраах тархалт хийх үед салааны захирагчийн үүрэг:

113.1. Шаардлагатай хүн хүч, хэрэгслийг бодисыг гал түймэр унтраах үйл ажиллагаанд богино хугацаанд бэлэн болгох зорилгоор тасаг тус бүрийн гүйцэтгэх үүргийг тодорхойлж өгөх.

113.2. Анхны дуудлагаар ирсэн автоцистернийг гал гарсан газарт аль болох ойр байрлуулж, юуны өмнө "Б" маркийн буюу агаар механикийн хөөсний генератороор ажиллуулах.

113.3. Гал нэгэнт тархсан нөхцөлд автоцистернийг усны эх үүсвэр дээр шууд байрлуулж "РСК-70 РС-А" "А" хушуу гаргаж ажиллуулах.

113.4. Гал түймэр унтраах бодисыг дамжуулан шахах шаардлага гарвал хүчин чадал сайтай автоцистернийг усны эх үүсвэр дээр байрлуулж түүнээс гал унтраах хоолой дэлгэх бөгөөд хүчин чадал багатай автоцистернийг гал гарсан газарт ойр байрлуулж, гал унтраах хоолойг усны эх үүсвэр тийш, мөн галын голомт руу хоёр чиглэлд дэлгэх.

114. Бүлгийн даргын үүрэг:

114.1. Албан хаагчдын хувийн хэрэгсэл болон үлээгч аппаратын сэлбэг түлхүүр багаж шалгаж үүрэгжүүлэх

114.2. Түймэрт явахын өмнө шуурхай бүлгийн албан хаагчдад аюулгүй байдлын зааварчилгааг өгч, гарын үсэг зурж баталгаажуулах.

114.3. Бүлгийн дарга хээрийн түймэр дээр хүрэлцэн очиж тухайн газар орны байдал, цаг агаарын нөхцөл байдлыг харгалзан үзэж тактикийн зөв хувилбарыг сонгон ажиллах

114.4. Бүлгийн албан хаагчдын аюулгүй байдлыг хангаж хяналт тавих

115. Жолоочийн үүрэг:

115.1. Бүлгийн даргын удирдлаган дор тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж ажиллах

115.2. Түймэрт явах замд болон түймэр дээр ажиллахдаа хөдөлгөөний хурдыг тохируулж бартаа саадыг тойрч гарах, голчлон түймрийн цурман дотор хөдөлгөөнд оролцох

115.3. Аврагч нар түймэр дээр ажиллах хугацаанд ойроос дагаж, аюулгүй байдлыг хангах

116. Аврагчийн үүрэг:

116.1. Бүлгийн даргын удирдлаган дор гал түймэр унтраах болон аврах ажиллагааг явуулна.

116.2. Түймрийн цагийн байдлаас хамаарч айл, хүн, амьтан өртөх аюултай тохиолдолд эхлээд аврах, хамгаалах ажиллагааг явуулна.

116.3. Түймэр унтраах явцад эвдэрч, саатсан техник хэрэгслийг бүлгийн даргад яаралтай мэдэгдэж шийдвэрлүүлэх.

116.4. Түймэр унтраах явцад аюулгүй байдлыг хангаж салхины дээд талаас болон салхины хүч бага үед галыг тасдаж унтраах арга хэмжээ авах

116.5. Албан хаагч бэртэж гэмтэх аюул нүүрлэсэн нөхцөл байдлыг түрүүлж мэдсэн тохиолдолд бүлгийн даргад яаралтай мэдэгдэх.

117. Эд материал, үнэт зүйлсийг аварч гаргахдаа:

117.1. Аврах ажлын дэс дараалал, зам гарц, хураах газар зэргийг заан өгч, энэ ажлыг хариуцсан тасгийн даргыг томилох.

117.2. Эд материал, үнэт зүйлсийг аврах ажлыг гал түймэр унтраах ажиллагаатай нэгэн зэрэг явуулах.

117.3. Мал аврахаар болбол аль болох богино хугацаанд малчид, ажилчдыг татан оролцуулж аврах үндсэн болон бэлтгэл замыг ашиглаж бөөнөөр нь тууж, хөтөлж гаргах ажлыг зохион байгуулах.

118. Гал түймэр унтраах аврах анги, хэсэгтээ буцаж ирээд томилгоот ээлжийн захирагч нь бие бүрэлдэхүүн болон гал унтраах автомашин, багаж зэвсэглэмжийг гал унтраах бэлэн байдалд богино хугацаанд оруулж, удирдлагын төв, гал түймэр унтраах аврах анги, хэсгийн дуудлага хүлээн авагчид гал унтраах бэлэн байдалд орсныг мэдэгдэнэ.

### **ХОЁРДУГААР ХЭСЭГ**

## **ТӨРӨЛ БҮРИЙН ХҮНД НӨХЦӨЛД ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ**

### **Нэгдүгээр бүлэг**

#### **Цаг агаарын хүндрэлтэй үед гал түймэр унтраах**

119. Ус дутагдалтай нөхцөлд гал түймэр унтраах:

119.1. Усны хушууг зөвхөн шийдвэрлэх чиглэлд өгч бусад чиглэлд барилгын хийц бүтээцэд задаргаа хийх, шаардагдах хэмжээний зай завсар гаргах замаар гал түймэр унтраах ажлыг зохион байгуулах.

119.2. Гал түймэр унтраахад ашиглаж болох худаг, усан сан зэрэг усны нэмэгдэл нөөцийн судалгаа гаргах ажлыг зохион байгуулах

119.3. Тархан дэлгэрсэн гал түймрийг унтраахад галын галт тэрэг, насосны станц, гал түймэр унтраах гадна усны даралтат цэгийг ашиглан ус тээвэрлэх, дамжуулан шахах зэргээр усаар тасралтгүй хангах.

119.4. Гал унтраах хоолойн төв шугмаар ус дамжуулан шахах бололцоогүй /гал унтраах хоолой, авто машин, ус дутагдалтай/ ус тээвэрлэгч, ус тээвэрлэх зориулалт бүхий тусгайлан тоноглогдсон автомашин, трактор ашиглан усаар хангах ажлыг зохион байгуулах.

119.5. Бэлэн байгаа усны савыг ашиглаж, түүнийг усаар тасралтгүй дүүргэх арга хэмжээ авах.

119.6. Усны түвшин доор байгаа буюу гал унтраах автомашин ойртож очих боломжгүй усан сан, гол цөөрмөөс гидроэлеватор, мотопомп зэргийг ашиглаж ус соруулах.

119.7. Ус түгээгүүрийн шугамын даралт багаас ус дутагдалтай байвал ус түгээгүүрийн станцын болон объектын хүч нэмэгдүүлэгч насосыг ажиллуулж даралтыг нэмэгдүүлэх, ус түгээгүүрийн зарим шугамыг хааж, гал түймэр гарсан газрын чиглэлд усны өгөлтийг нэмэгдүүлэх.

119.8. Бага диаметртэй цацруулагчтай, хаалттай болон усны нарийн цацраг гаргах хушуу хэрэглэх, норгогч бодис, агаар механикийн хөөс зэргийг ашиглаж усыг аль болох хэмнэлттэй зарцуулах.

119.9. Гал түймэр унтраах бодисийг гал унтраах автомашинаар зөөвөрлөн хангаж буй нөхцөлд усаар тасалдуулахгүйн тулд ирж байгаа усныхаа хэмжээнд тохируулан хушууны тоог зөв тогтоох.

119.10. Гал түймэр гарсан газар ус огт байхгүй, эсвэл ус авах газаргүй буюу ус зөөх техникгүй тохиолдолд гал түймэр унтраах удирдагч нь барилгын хийц бүтээцэд задаргаа хийж таслах, шатаж байгаа бодис материал, барилгын зарим хийц бүтээцийг зайлуулах, барилга байгууламжийг эвдэж буулгах. Өвлийн улиралд шатаж буй хийц бүтээц, материалыг цасаар хучиж унтраах.

120. Их хүйтэн нөхцөлд гал түймрийг унтраах:

120.1. Ил задгай орчинд гарсан гал түймрийг унтраах ус хангалттай байвал суурьтай "А" маркийн ус их гаргах хүчин чадалтай хушууг хэрэглэх бөгөөд хаалттай болон цацруулагч хушууг аль болох хэрэглэхгүй байх. Объектын онцлог, галын тархан дэлгэрэлтээс хамаарч гал түймэр унтраах удирдагчийн шийдвэрээр хушууг сонгох

120.2. Том диаметрийн дотортой хоолойг ашиглаж, салаа билчирийг боллоцотой бол барилгын дотор байрлуулах, харин гадна байрлуулах тохиолдолд дулаалах.

120.3. Шийдвэрлэх чиглэлд ажиллаж байгаа галын хушуунуудад зориулан нөөц төв шугам дэлгэж, норгохоос хамгаалах.

120.4. Гал унтраах хоолойн залгааснуудыг цасаар хучих.

120.5. Гал унтраах автомашины хөөрөгний ажиллагааг зогсоох, хушуу, салаа билчирийг бүрэн хаахыг хориглоно.

120.6. Гал унтраах гэмтсэн хоолойг солих, нэмж дэлгэхдээ усны даралтыг бага зэрэг бууруулж байж гүйцэтгэх.

120.7. Хөлдсөн хоолойн нугарсан хэсэг, залгаасыг халуун ус, уур, хийгээр гэсгээх, хушууны залгаас салаа билчир, хушууг гэсгээхэд паяльник, бамбар ашиглах.

120.8. Галын шатнаас буюу ойролцоо газар хоолойн шугам бэхлэхгүй байх, шатыг усаар норгохгүй байх.

120.9. Хушууны байрлалыг өөрчлөх үед усаар тасалдуулахгүй байх.

120.10. Барилгын шатны хонгилд ус асгаж гоожуулахгүй байх.

120.11. Гал түймэр унтраасны дараа хоолойн шугамыг эвхэхдээ усны даралтыг багасгаж, усаар тасалдуулахгүй байхын хамт хоолойн шугамыг юуны урьд хушууны талаас эхлэн олон хүний хүчээр богино хугацаанд хурааж дуусгах.

120.12. Их хүйтэн нөхцөлд удаан хугацаагаар гал түймэр унтраах үед бие бүрэлдэхүүний хөдөлгөөн удаашрах, даарах, машин техникийн болон зөөвөрлөсөн

ус хөлдөх ч тохиолдол гарч болохыг анхаарах. Энэ үед гал сөнөөгчдийг солих бэлтгэл нөөцийн хүн хүч, техникийг дуудахаас гадна бие бүрэлдэхүүнийг эмчийн хяналтанд авах, дулаан байр, хуурай хувцсаар хангах, битүү автомашин, автобусаар гал сөнөөгчдийг гал түймэр унтраах аврах анги, хэсэгт нь хүргэх арга хэмжээ авах.

121. Хүчтэй салхитай үед задгай шатаж буй гал түймрийг унтраах:

121.1. Гал түймрийн үндсэн голомтоос гадна салхинд хийссэн галын оч, дөлөөс гал түймрийн шинэ голомтууд үүсэх.

121.2. Хүчтэй салхины улмаас барилгын шатсан хийц бүтээц нурж унах.

121.3. Гал түймрийн эрчимтэй тархалтын улмаас гал түймэр унтрааж буй алба хаагчид галын дөлд бүслэгдэх, буцах зам гарц хаагдах.

121.4. Дээрх нөхцлийг харгалзан гал түймэр унтраах удирдагч нь шатаж буй галын дөлийг хоёр талаас нь хүчтэй хушууны усны цохилтоор богино хугацаанд гал түймэр гарсан объектыг бүслэх шуурхай ажиллагааг хангах.

121.5. Хүчтэй хушууг ашиглаж унтраах аргыг голчлон сонгож, гал түймрийн шинэ голомтыг илрүүлж унтраах нөөц хүн хүч, хэрэгслийг төвлөрүүлж ажиллуулах.

121.6. Гал түймэр унтраахад нэн хүнд бэрхшээлтэй болсон үед барилгын хийц бүтээцэд задаргаа хийж, зайлуулахаас эхлэн гал түймрийн тархалтын гол чиглэлд зай завсар гаргах ажлыг хийх. Хүчтэй салхитай үед хээрийн түймрийг унтраахдаа бүлэг нь түймрийн хоёр захын ар тал буюу салхин дээд талаас хөөж унтраах аргыг хэрэглэх ба аврагч нар нь түймрийн толгой буюу уулган доор орохыг хатуу хориглоно. Түймрийн салхины чиглэлийн дагуу буюу уулган доор айл, өрх байгаа зайлшгүй шаардлагатай тохиолдолд тэдгээрийг хамгаалах зорилгоор аврах ажлыг зохион байгуулж болно.

122. Шатлагын бүтээгдэхүүн ихтэй нөхцөлд гал түймэр унтраах:

122.1. Шатлагын бүтээгдэхүүн бүхий байр тасалгаа бүрд галын хайгуул хийж, авралтын ажиллагааг зохион байгуулах

122.2. Барилгын шатны хонгил, коридор, авралтын бусад замд тархсан Шатлагын бүтээгдэхүүнийг зайлуулах арга хэмжээ авах.

122.3. Гал түймрийн дөл Шатлагын бүтээгдэхүүн тархах зам, чиглэлийг тогтоох, үүний тулд дөл, Шатлагын бүтээгдэхүүн тархаж болох даацын хана, таазны хөндий, агааржуулалтын болон салхивны суваг бусад нүх, цоорхойг онцгой анхаарах.

122.4. Шатлагын бүтээгдэхүүн ихтэй байранд гал түймэр унтраах ажлыг гүйцэтгэхдээ аврагч, гал сөнөөгчийг хорт хий, утаанаас хамгаалах багтай ажиллуулах.

122.5. Шатлагын бүтээгдэхүүнд гэмтэж болох бодис, материалын хэмжээ, байрлалыг тодруулах, ийм бодис материал бүхий байр, тасалгааг аль болох хурдан агааржуулах, аврах ажлыг зохион байгуулах.

122.6. Шатлагын бүтээгдэхүүн ихтэй нөхцөлд утаа сорогч, агааржуулагч зэрэг техник, хэрэгслийг өргөн ашиглах.

119.7. Цацруулагч хушуу хэрэглэн усыг бороожуулан өгөх.

119.8. Гал түймэр гарсан байр, тасалгаа болон барилгын хийц бүтээцийн хөндий зайг агаар механикийн хөөсөөр дүүргэх.

122.9. Хөөсөөр дүүргэх байр, тасалгааны эзэлхүүнийг тогтоох.

122.10. Хөөс гадагш урсаж гарах газарт хаалт хийж өгөх.

122.11. Шаардагдах хөөсний хэмжээ, генераторын тоог тогтоож, тэдгээрийг байрлуулах газрыг зааж өгөх.

122.12. Хөөсийг тодорхойлсон чиглэлд урсгах.

122.13. Утаа сорогчийг байрлуулах газрыг тодорхойлох.

122.14. Хөөсний генераторыг шатлагын түвшингээс өндөрт байрлуулах.

122.15. Утаа сорогч хэрэгслийг хөөсний генераторын эсрэг чиглэлд байрлуулж ажиллуулах.

122.16. Гал түймэр гарсан байр, тасалгааг хөөсөөр дүүргэсний дараа хорт хий, утаанаас хамгаалах багтай хэсгийг оруулж, гал түймрийн нөхцөл байдлыг мэдэх, шатлагын голомтыг илрүүлж, унтраах арга хэмжээг авах. Утаа ихтэй харагдах орчин хязгаарлагдмал үед хээрийн түймэр унтраах ажиллагааг зогсоож автомашин болон аврагч нарыг түймрийн галын захаас холдуулах эсхүл машинтайгаа шатсан газар орж зогсон, өөрсдийн аюулгүй байдлаа хангаж галын дөл харагдаж түймрийг унтраах боломжтой болсон үед унтраах ажиллагааг явуулна.

### **Тэсэрч дэлбэрэх бодис бүхий объектод гарсан гал түймрийг унтраах**

123. Тэсэрч, дэлбэрэх бодис бүхий объект, байранд гал түймрийг унтраах:

123.1. Гал түймэр маш хурдан тархах.

123.2. Гал түймэр унтраах байнгын болон технологийн тоног төхөөрөмж, гадна, доторх усны шугам гэмтэх, шатаж байгаа объектын зарим хэсэг нурах, зам гарц хаагдах.

123.3. Тэсрэлт, шатлагын улмаас хорт хий, утаа ялгарах, гал түймэр унтраахаар ажиллаж байгаа албан хаагчид тэсрэлтийн цохих долгионд өртөх, хийц бүтээцийн бутарч унасан хэсэгт цохигдон бэртэж гэмтэх, хордож түлэгдэх.

123.4. Тэсэрч, дэлбэрэх бодисын тоо хэмжээ, байрлал, учруулж болзошгүй аюул, гал түймэр унтраах төхөөрөмж, технологийн горимын аюулгүй байдлыг тогтоож тэдгээрийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлыг хангах.

123.5. Аюултай бүсэд ажиллагсдад мэдээлэх, нэгдсэн дохиог тохирч энэ тухай бүх бүрэлдэхүүнд мэдэгдэх.

123.6. Тэсэрч, дэлбэрэх бодисын мэдрэх чанарыг харгалзан "А" буюу лафетны хушууг ашиглах, хэрэв шатлага нь зугуухан болон тэрхүү бодис нь хайлмал байдалд шатаж байвал хөөс буюу усны цацруулсан тусгалыг хэрэглэх.

123.7. Гал түймэр унтраах үйл ажиллагаатай зэрэгцүүлэн дулаан өндөр хэмийн болон механик үйлчлэлийн улмаас тэсрэх аюулд хүргэхээс сэргэмжлэн технологийн аппаратыг хөргөх боломжтой гэж үзвэл тэсэрч, дэлбэрэх бодисыг аврах, зөөх ажлыг зохион байгуулах.

123.8. Аюултай бүсэд шаардлагагүй байхад хүмүүс, гал унтраах автомашин, техник бөөгнөрүүлэхгүй байх.

123.9. Хайгуулын ажлыг тасралтгүй явуулж, зэргэлдээх барилга, байгууламжийг хяналтанд авах.

123.10. Гал түймэр унтраах явцад тэсрэлтийн улмаас шатаж буй барилгын хэсэг, эд материал хол зайд шидэгдэж галын шинэ голомт үүсгэхээс болгоомжлон гал унтраах багаж, зэвсэглэмжтэй хэсгийг ажиллуулах.

123.11. Гал түймэр унтраах бэлтгэл нөөц, хүн хүч, хэрэгслийг аюулгүй газар байнга бэлэн байлгах урьдчилсан арга хэмжээг авах.

## **Цацраг идэвхт бодис бүхий объектод гарсан гал түймрийг унтраах**

124. Цацраг идэвхт бодис бүхий объект гарсан гал түймрийн аюулын үед дараах хүндрэл гардаг. Үүнд:

124.1. Цацраг идэвхт бодис, радиацийн түвшин ихэсч бодис, Шатлагын бүтээгдэхүүн нь радиантай холилдон салхивчийн систем, технологийн болон барилгын хийц бүтээцээр дамжин тархах.

124.2. Шатлагын явцад хорт болон цацраг идэвхт бодис ялгарч хүчтэй утаажин цацраг идэвхт бодисоор барилга, технологийн төхөөрөмж, гал унтраах техник, багаж зэвсэглэмж, хөдөлмөр хамгааллын хувцас бохирдож бие бүрэлдэхүүн хордлого авах.

124.3. Цацраг идэвхт бодис бүхий объектод гарсан гал түймрийг унтраахдаа объектын мэргэжлийн албадтай хамтран хордлогын хэмжээнд хяналт тавьж бие бүрэлдэхүүний ажиллах хугацаа, цацраг идэвхт бодисын хордлогын хязгаар, тархах замыг тодорхойлох.

124.4. Объектын удирдлага, мэргэжлийн албадаас зөвшөөрөл авсны дараа гал түймэр унтраах үйл ажиллагаанд бие бүрэлдэхүүнийг оруулах.

124.5. Гал түймэр унтраах аврах ангийн тоо, гарсан гал түймрийн хэмжээг харгалзахгүйгээр гал түймэр унтраах шуурхай штаб байгуулж хордлого хэмжих албаны болон объектын мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах.

124.6. Гал түймэр унтраах бодисыг объектын инженер техникийн албатай хамтран сонгож, цацрагийн аюулгүйн норм болон ариун цэврийн шаардлагыг хангах.

124.7. Цацраг идэвхт бодис түүний эх булаг нь эрчимтэй цацраг хий ялгаруулах, ил технологийн төхөөрөмжтэй бол гарсан гал түймрийг салхины дээд талаас нь унтраах.

124.8. Цацраг идэвхт бодисын тархалтын бүсийг багасгах үүднээс бороожуулсан ус өгөх.

124.9. Аваар, осол, гал түймэр унтраах үйл ажиллагаанд оролцогчдын амьсгалын эрхтэнг хамгаалах баг, хамгаалалтын тусгай хувцас болон нэг бүрчилсэн буюу хэсэг бүлгээр хордлогыг хэмжих хэрэгсэлтэйгээр ажил үүрэг гүйцэтгэх.

124.10. Цацраг идэвхт бодисын хордлогын бүсийн гадна хордлого хэмжих хэрэгсэлтэй, хамгаалалтын хувцас, хорт хий, утаанаас хамгаалах хэсэг, бэлтгэл хүн хүч, хэрэгслийн нөөцийг бэлтгэх.

124.11. Цацраг идэвхт бодисын хордлоготой бүсийн орох гарц дээр даргалах бүрэлдэхүүнээр ахлуулсан аюулгүйн ажлын хэсгийг томилж ажиллуулах.

124.12. Гал түймэр унтрааж дууссаны дараа гал түймэр унтраах удирдагч аюултай бүсэд ажилласан бие бүрэлдэхүүнийг эмнэлгийн үзлэгт оруулж, ариутгал хийх.

124.13. Гал унтраах техник, зэвсэглэл, гутал хувцас, хорт хий, утаанаас хамгаалах багийг ариутгах.

### **Хоёрдугаар бүлэг**

#### **Барилга байгууламжид гарсан гал түймрийг унтраах**

125. Барилгын давхаруудад гарсан гал түймрийг унтраах:



125.1. Барилгын давхаруудад гарсан гал түймрийг унтраахад юуны өмнө хаалттай РСК-50, РС-Б "Б" хушуу, хөөсний генераторыг хэрэглэх.

125.2. Хүчтэй хушууг гагцхүү гал түймрийг эрчимтэй тархаж байгаа үед хэрэглэх.

125.3. Барилгын дээд давхар, дээвэрт гарсан гал түймрийг унтраахад барилгын дотуур усан хангамж, байнгын зориулалттай хуурай хоолойг ашиглах, үүний тулд даралт нэмэгдүүлэх хөөргийг ажиллуулах.

125.4. Хэрэв шатлага нь нэг давхар буюу хэд хэдэн давхарт тархсан бол гал унтраах анхны хушууг шатаж байгаа давхарт, дээд, доод давхаруудад хамгаалалтын хушууг гаргаж ажиллуулах.

125.5. Давхаруудын салхивч, агааржуулалт, хогийн суваг, нэвт үлээх хонгил зэрэг барилгын хийц бүтээцийн нүх сүвээр шатлага, утаа тархахаас сэргийлж гал унтраах хушууг дээд, доод давхар, дээврийн хөндийд өгөхийн хамт хамар хана, давхар дундын хучилтад задаргаа хийх.

125.6. Барилгын аль нэг давхарын олон өрөө тасалгаанд гал түймэр нэгэн зэрэг тархсан тохиолдолд хүч хэрэгсэл хүрэлцээтэй бол нэгэн зэрэг, хүрэлцэхгүй бол дарааллын журмаар усны хушууг гаргаж унтраах.

125.7. Ингэхдээ гал түймрийг нэг буюу хоёр талаас нь хөөж унтраах арга тактикийг хэрэглэх.

125.8. Шатах болон тэсвэрлэн шатах материалаар баригдсан секц, тусгаарлах хана буюу хамар хананд гал түймэр тархсан тохиолдолд үл шатах материал бүхий хийц бүтээцтэй шатны хонгил талаас унтраах аргыг хэрэглэх.

125.9. Шатаж байгаа болон зэргэлдээх өрөөнүүдийн барилгын хийц бүтээцийг сайтар шалгаж, задаргаа хийх, ялангуяа босоо байрлал бүхий хийц бүтээцийн дээд, доод хэсгийг нарийвчлан шалгаж үзэх.

125.10. Барилгын давхар дундын хучилт, шатаж нурах аюул гарч байгаа бол хучилт дээр болон доод давхарт ажиллаж байгаа хүмүүсийг гаргах, эд материалыг аврах ажлыг зохион байгуулах.

125.11. Барилгын давхаруудад гарсан гал түймрийг унтраах усны хушууг шатны хонгил, зарим тохиолдолд цонх, тагт, галын шат, аврах олс ашиглан ажиллуулах.

125.12. Барилгын хийц бүтээцийг дээд, доод давхарт нэгэн зэрэг задлан давхар дундын хучилтын гал түймрийг хөөсөөр унтраах.

126. Барилгын доорх зоорийн давхарт гарсан гал түймрийг унтраах:

126.1. Барилгын доорх зоорийн давхарын байршил, хадгалж буй бодис, материал, тэдгээрийн шинж чанар, шатлагын байдал, барилгын хийц бүтээц болон тэдгээрээр галын шатлага тархан дэлгэрч болох чиглэл, аюулын зэргийг тогтоох.

126.2. Гал унтраах ажлыг зохион байгуулахын хамт зоорийн давхарын тааз, багана зэрэг хийц бүтээцийг эрчимтэй хөргөх, утааг гаргаж шатлагын дулааныг бууруулах.

126.3. Цахилгаан хүчний болон гэрэлтүүлгийн гүйдлийн сүлжээг яаралтай салгах арга хэмжээ авах.

126.4. Барилгын доорх зоорийн давхарт утаа ихтэй бол агаар механикийн хөөс өгч, утаа сорогч ашиглах.

126.5. Галын голомтыг илрүүлэх, унтраахын тулд барилгын хучилт, ханыг цоолох, байгаа нүх, цоорхойг ашиглаж галын голомтод хүрч унтраах.

126.6. Агааржуулалтын систем бусад нүх цоорхойгоор, мөн төмөр бетон болон төмөр хийц бүтээц, цонх, хаалгаар дамжин галын дөл шатлага, утаа нь дээд давхаруудад тархсан эсэхэд байнга хяналт тавих.

126.7. Барилгын дээд давхаруудад байгаа хүмүүст аюул учруулахаар бол аврах ажиллагааг шуурхай зохион байгуулж айлуудыг нүүлгэх асуудлыг шийдвэрлэх.

126.8. Дулааны шугам сүлжээний хоолойн шугамын дулаалга тусгаарлагч материалын шатлагын хэмжээг тодорхойлох.

126.9. Объектын техникийн албаны хүмүүсийг оролцуулан дулаалгын шатлагын дулааны үйлчлэлийг багасгах арга хэмжээ авах.

126.10. Дулаалгын материалд задаргаа хийж галын тархалтыг зогсоох.

126.11. Галыг унтраахдаа "Б" маркийн хушуу хэрэглэх, эсвэл туннелийг уур буюу агаар мөханикийн хөөсөөр дүүргэх.

127. Дээврийн хөндий, мансардын давхарт гарсан галыг унтраах:

127.1. Дээврийн хөндийд гарсан галыг унтраахдаа анхны хушууг барилгын дотор талын шатыг ашиглан гал түймэр унтраах бодисыг өгөх.

127.2. Утаа, их хэмжээний дулааны үйлчлэлийг гаргах, хушуучин гал сөнөөгчийг ажиллуулах зорилгоор дээврийн зарим хэсэгт задаргаа хийх.

127.3. Дээврийн хөндийд гарсан галыг унтраахдаа хаалттай болон цацруулагч хушуугаар гал түймэр унтраах бодисыг өгөх.

127.4. Дээврийн болон сонсох цонх, гадна талын авралтын шат, автомеханик шат ашиглан гал түймэр унтраах бодисыг өгөх.

127.5. Агааржуулалтын болон хогны суваг, шатны хонгил, цонх, дээврийн хучилт, барилгын дулаан хангамж, цахилгаан шугам сүлжээний систем, мансардны давхарын гал тархаж болох хана, хөмсгийг сайтар шалган гал тархахаас хамгаалах.

127.6. Дээврийн хучилтын шатаж буй хэсэгт дээд болон доод талаас нь задаргаа хийх.

127.7. Дээврийн хөндий, доод талын давхарыг илүүдэл уснаас хамгаалах.

127.8. Дээврийн хучилтыг шатаж байгаа хэсгийн дээд болон доод хэсэгт олон хүн ажиллуулахгүй байх, аюулгүй байдлыг хангах урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах.

128. Өндөр барилгад гарсан галыг унтраах.

128.1. Хүмүүс олноор цугларсан, тусламж үзүүлвэл зохих олон тооны хүмүүс байж болох.

128.2. Авралтын ажил явуулахад саад бэрхшээлтэй байх.

128.3. Гал хөндлөн болон босоо чиглэлд тархан дэлгэрэх.

128.4. Барилгын хэсгийн бүх давхар, шатны хонгил, цахилгаан шат, хогийн болон агааржуулалтын сувгаар гал түймэр богино хугацаанд тархан дэлгэрч, хорт хий утаагаар дүүрэх.

128.5. Гал гарсан давхарын хонгил, шатны хонгилын хэсэг болон авралтын зам, гарц хорт хий, дулааны үйлчлэлээр дүүрсэн байх.

128.6. Барилгын дээд давхарт гал унтраах хүч, хэрэгсэл ажиллуулах боломжгүй байх.

128.7. Гарсан галыг унтраахад зайлшгүй хэд хэдэн хайгуулын хэсгийг зохион байгуулах шаардлага гарах.

128.8. Хайгуулын үед үндсэн үүргээс гадна дараах нөхцөл байдлыг тодотгох. Үүнд:

128.8.1. Хүмүүсийг аврах зам, галын голомтод аль болох ойртон очих боломжтой эсэх.

128.8.2. Бие бүрэлдэхүүн, гал унтраах техник зэвсэглэмжийг дээш нь гаргахад цахилгаан шат ашиглах боломжтой эсэх.

128.8.3. Гал түймэр унтраах болон дулааны үйлчлэлийг бууруулах, утаа соруулах тоног төхөөрөмжийг ашиглаж болох эсэх.

128.8.4. Утаанд үл автах шат, тагт, гал унтраах тусгай зориулалтын автомеханик шат, авто өргөгч, бусад аврах хэрэгслийг ашиглаж болох эсэх.

128.9. Хүмүүст учирч буй аюулын зэргийг тодорхойлж, ялангуяа дээд давхарт байгаа хүмүүсийг аврах арга хэрэгсэл, зам гарцыг тогтоох.

125.10. Өндөр барилгын утаа зайлуулах тоног төхөөрөмжийг ажиллуулж, аврах замд буй утааг гадагш соруулах, барилгыг утаанд автагдуулахгүй байх ажлыг зохион байгуулах.

128.11. Аврах, эрэл хайгуулын ажилд аврах, тусгай ангийн эрэн хайх бүлгийг ажиллуулах.

128.12. Гал гарсан газар хамгийн богино хугацаанд шаардагдах хорт хий, утаанаас хамгаалах хэсэг, автомеханик шат, авто өргөгчийг татан төвлөрүүлэх.

128.13. Авралтын хэвийн бөгөөд шуурхай ажиллагааг хангах үүднээс дотоодын мэдээллийн систем, чанга яригчийг ашиглах.

128.14. Гал түймэр унтраах бодис өгөхдөө юуны өмнө галын дотуур усан хангамж бусад зөөврийн хэрэгсэл, хуурай хоолойг ашиглаж хүч нэмэгдүүлэх насосыг ажиллуулах.

128.15. Ачааны болон хүн зөөвөрлөх цахилгаан шат, автомеханик шат, авто өргөгч, шаардлагатай үед нисдэг тэрэг зэргийг ашиглан гал унтраах хүч хэрэгслийг дээд давхаруудад гаргах.

128.16. Аравдугаар давхараас эхлэн галын даралтын хоолойн шугамыг аврах олс, эвхээстэй хоолойг ашиглан дэлгэж, хоолойн шугамыг 20 метр тутамд барилгын даац бүхий хийц бүтээцээс сайтар бэхлэх.

128.17. Бие бүрэлдэхүүн, машин техникийг барилгын хийц бүтээцийн нуралт, доош унаж буй эд материалд өртөн, гэмтэж бэртэхээс хамгаалах.

129. Эмнэлэг, сургууль, хүүхдийн байгууллагад гарсан галыг унтраах:

129.1. Эмнэлэг, сургууль, хүүхдийн байгууллагын доторх зохион байгуулалт нь онцлог байршилтайгаас гадна рентген хальс, эмийн агуулах, эмийн сан, химийн төрөл бүрийн бодис материал, хийн баллон, цахилгаан тоног төхөөрөмжийн байр зэрэг олон өрөө тасалгаатай байдаг. Эдгээр байгууллагад олон тооны өвчтөн, хүүхэд, сурагчид нэг дор байрлаж байдаг учраас гал гарсан үед аврах ажлыг маш нарийн дэг журамтай зохион байгуулахыг шаардана.

129.2. Галын хайгуулын ажлын үед үндсэн үүргээс гадна дараах байдлыг тодруулна. Үүнд:

129.2.1. Гал түймрийн аюулд автагдаж болох өрөө тасалгааны өвчтөн, сурагчдыг аврах талаар эмнэлэг, сургуулийн ажилтнууд ямар арга хэмжээ авсан болохыг тогтоох.

129.2.2. Аварвал зохих өвчтөн, сурагчдын тоо тэдгээрийг аврах зам, гарцыг тодорхойлох.

126.2.3. Эмнэлэг, сургуулийн ажилтнуудаас авралтын ажилд ямар хүмүүсийг татаж оролцуулах болон аврагдсан хүмүүсийг хаана байрлуулах тухай асуудлыг шийдвэрлэх.

129.2.4. Аврах зам, гарцыг хамгаалах шаардлага, хорт хий, шатлагын бүтээгдэхүүнийг багасгах бололцоо байгаа эсэх.

129.3. Үйлчлэгч, ажилтан нарын туслалцаатайгаар айж сандралд орохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, ялангуяа амаржих газар, сэтгэл мэдрэлийн болон халдварт өвчнийг анагаах эмнэлэг, цэцэрлэг, бага сургуульд энэ ажлыг онцгой анхаарч зохион байгуулах.

129.4. Рентген хальс, изотоп, химийн бодис бүхий лабораторийн байрлалыг тогтоож, изотоп, хальс, химийн бодисыг хамгаалалтанд авах буюу гаргах арга хэмжээ авах.

129.5. Эм, эмийн төрлийн зүйл, эмийн сан, эмчилгээний тоног төхөөрөмж зэргийг уснаас хамгаалах ажлыг зохион байгуулах.

129.6. Халдварт өвчтөн бүхий байранд гарсан галыг унтраасны дараа эмнэлгийн ажилтны өгсөн заавраар гал түймэр унтраах аврах ангийн бие бүрэлдэхүүнийг ариутгах арга хэмжээ авах.

129.7. Сургуулийн барилгад гарсан галыг унтраахдаа байранд байгаа сурагчдын тоо, насны ялгаврыг тодруулах.

129.8. Хамгийн түрүүнд бага насны, хүүхдээс эхлэн дэс дараалалтай богино хугацаанд аварч гаргахад багш нарт туслалцаа үзүүлэх.

129.9. Сургалтын кабинетуудын тоног төхөөрөмжийг хамгаалж, авралтыг зохион байгуулах.

129.10. Авралтын ажлыг зохион байгуулж дууссаны дараа сургуулийн удирдлагад хүүхдүүдийг бүртгэх үүрэг өгөхийн зэрэгцээ сургуулийн бүх өрөө тасалгаа, утаажсан байруудад үзлэг, шалгалт хийх.

129.11. Цэцэрлэг, яслид гарсан гал түймрийг унтраах үед тоглоом, унтлагын болон туслах чанарын байр, тасалгаа, мөн ханын шкаф, ор, хөшиг, бусад газруудад хүүхэд үлдсэн эсэхийг сайтар шалгаж эрхлэгч, хүмүүжүүлэгч багш нараар хүүхдийг бүртгүүлэх ажлыг гүйцэтгүүлэх.

130. Үзвэрийн газруудад гарсан гал түймрийг унтраах:

130.1. Үзвэрийн газруудад тухайлбал тэдгээрийн үйлчилгээ явагдаж байгаа үед гарсан галыг унтраахдаа үзэгчдийг аврах, хамгаалах нарийн төвөгтэй ажил шаардагддаг. Иймд гал түймэр унтраах удирдагч дараах зүйлд анхаарах хэрэгтэй. Үүнд:

130.1.1. Үзэгчдийн болон тайзны хэсэгт олон тооны хүмүүс цугларсан байх.

130.1.2. Тайзны хэсэгт гал хурдан тархаж үзэгчдийн танхим, салхивчны систем, дээврийн хөндийд дэлгэрэх.

130.1.3. Үзэгчдийн танхимын дээд талын дүүжин хучилт нурж унах, байр тасалгаанд шатлагын бүтээгдэхүүн тархан, дулааны үйлчлэл нэмэгдэх.

130.1.4. Үзвэрийн газруудад гал гарсан үед хамгийн богино хугацаанд үзэгчдийн танхимд байгаа хүмүүсийг айж сандарч тэвдэхгүй байлгаж, аврах.

130.1.5. Юуны өмнө галерей, тагт, бельэтаж зэрэг утаа, гал тархах бүх байрнаас үзэгчдийг авран гаргах.

130.2. Тайзны хэсэгт гарсан галыг унтраахдаа хушууг үзэгчдийн танхим талаас гаргаж ажиллахын хамт тайзны хоёр тал, дээд хэсэг, бусад өрөө тасалгаанд хамгаалалтын хушуу ажиллуулна. Хэрэв гал эсэргүүцэх хөшиг нээлттэй үед гал гарвал түүнийг буулгаж, үзэгчдийн танхим талаас хөргөлт хийж мөн нэгэн адил хамгаалах.

130.3. Галын тархалтыг зогсоохын тулд дренчер, бусад төхөөрөмж, суурьтай хушуу зэрэг байнгын хэрэгслийг ашиглах.

130.4. Галд шатаж буй декорац, чимэглэлийг тайзан дээр буулгаж унтраах.

130.5. Гал түймэр унтраах хүн хүч, хэрэгсэл дутагдалтай буюу гал түймэр үзэгчдийн танхим руу тархан дэлгэрч, утаажиж байгаа тохиолдолд үзэгчдийн танхимд хүмүүс байвал утаа гаргах нээлхийг зөвхөн гал түймэр унтраах удирдагчийн зөвшөөрлөөр онгойлгох.

130.6. Үзэгчдийн танхимын дээрх дээврийн хөндийг шалгах.

130.7. Театрын барилгын газар доорх давхар, хөгжимчдийн байранд гал гарсан үед агаар механикийн хөөс хэрэглэж галын, голомтыг унтраахын зэрэгцээ тайзны эргэх хүрээ, хөгжимчдийн байр, бусад өрөөнд гал тархахгүй байх хамгаалалтыг хийж, агаар механикийн хөөсний хушуу гарган ажиллуулах

130.8. Үзэгчдийн танхимд гал гарсан үед анхны хушууг галын голомт болон тайз талаас өгч дээвэр бусад өрөө тасалгааг хамгаалалтад авч ажиллах.

130.9. Гал эсэргүүцэх хөшигийг буулгаж, гал тархан дэлгэрсэн нөхцөлд тасралтгүй хөргөлт хийх.

130.10. Дээвэрт галын дөл, утаа ихэсгэхгүй, шатлагын ачааллыг нэмэгдүүлэхгүй байхад анхаарч дүүжин таазыг хамгаалах арга хэмжээ авах.

130.11. Агааржуулалтын системийг шалгаж, шаардлагатай бол задаргаа хийж, хушуугаар ус өгөх.

130.12. Үзвэрийн газарт гал гарсан үед тархалтыг хүмүүс, өмч хөрөнгийг аврах ажиллагаанд саад болохгүйгээр зохион байгуулах.

130.13. Галын голомтыг илрүүлэх, хоолойн шугамыг дэлгэхдээ байнгын шат, орох, гарах хаалгыг ашиглах.

130.14. Барилгын хийц бүтээц нурах, баримал чимэглэлийн зүйлс унах, татуурга, дэгээ тасарч дор нь ажиллаж байгаа албан хаагч гэмтэж, бэртэхээс болгоомжлох.

131. Музей, архив, номын сан, үзэсгэлэн, банкны салбар зэрэгт гарсан галыг унтраахдаа:

131.1. Эдгээр газруудын барилгын төлөвлөлт, байршил нь нарийн төвөгтэй их хэмжээний талбай, эзлэхүүн бүхий өрөө, тасалгаатай цонх, орцын тоо цөөн, шатамхай материалаар дүүрэн, ховор үнэт зүйлс их байдаг зэрэг онцлогтой болохыг анхаарах хэрэгтэй. Үүнд:

131.1.1. Шинжлэх ухаан уран сайхны үнэт зүйл гал, ус, утаанд гэмтэх.

131.1.2. Тавиурууд нурж орц, гарцыг таглах зэрэг байдал буй болох.

131.1.3. Дурьдсан газруудын дарга, албан тушаалтнуудаас ховор үнэт зүйл байгаа газар болон галын дөл, утаа нөлөөлж байгаа эсэхийг тодруулах.

131.1.4. Галыг ямар хүч, хэрэгсэл, бодисоор унтрааж болохыг тодотгох.

131.2. Байгууллагын захиргаатай хамтран үнэт ховор эд зүйлсийг аврах дэс дарааллыг тогтооно. Үүнд:

131.2.1. Гал түймрийг унтраах явцад үнэт материал, зүйлсийг усанд автагдахаас хамгаалах, аварч гаргах арга хэмжээг нэгэн зэрэг зохион байгуулах.

131.2.2. Объектод байгаа гал түймэр унтраах байнгын болон тусгай төхөөрөмж хэрэгслийг ашиглах нөхцөл, боломжтой эсэх

131.2.3. Галыг унтраах, барилгын хийц бүтээцэд задаргаа хийхдээ өрөө тасалгааны урлал, чимэглэл, үзвэрийн зүйлийг хамгаалах

131.2.4. Барилгын давхарын хучилт, хамар хана, барилгын хийц бүтээцийн хөндий зай, агааржуулахын болон халаалтын шугамыг сайтар шалгаж, гал түймрийн тархалтыг зогсоох арга хэмжээ авах.

131.2.5. Объектын ажилчин, албан хаагчдын бүх хүчээр үнэт эд материалыг хамгаалах ажлыг зохион байгуулах.

131.2.6. Музей, архив, номын сан, үзэсгэлэн, банкны салбар зэрэг объектод гарсан гал түймрийг унтраахдаа галын дотортой хоолой, хаалттай "Б" хушуу, агаар механикийн хөөс, гал түймэр унтраах нунтаг бодис, инертийн хий зэргийг ашиглах.

132. Эрчим хүчний үйлдвэрлэл, өндөр хүчдэл, цахилгаан тоног төхөөрөмж бүхий байранд гарсан гал түймрийг унтраахдаа дараах аюулгүй байдлыг хангана. Үүнд:

132.1. Дээрх объектод гарсан гал түймрийг унтраах үед цахилгаан төхөөрөмжийн гүйдэл дамжуулах хамгаалалтгүй хэсэгт хүрэх ойртох, ус, хөөсний цацраг цахилгаан гүйдэл таслаагүй тоног төхөөрөмжид хүрсэнээс түүгээр дамжин бие бүрэлдэхүүн цахилгаан гүйдэлд цохиулахаас урьдчилан сэргийлэх.

132.2. Генератор, трансформатор, цахилгаан гүйдэл дамжуулах шугам сүлжээ, ил ба далд хуваарилах байгууламж тэнд тавигдсан таслах, залгах тоног төхөөрөмж гэмтсэнээс гал хурдан тархах, хуваарилах байгууламж, трансформатороос масло асгарч кабелин суваг, хагас давхар, нарийн хэмжүүрийн тэжээлийн шугам, аккумуляторын байгууламж, барилгын хийц бүтээц, дулаалганд гал дэлгэрч, дэлбэрэхээс урьдчилан сэргийлэх.

132.3. Радиацийн түвшин нэмэгдэж аюул үүсэхээс урьдчилан сэргийлэх. /радиацийн сав шугам хоолой, устөрөгчийн хөргөлт бүхий системийн гэмтлээс тэсрэх аюултай хий үүсэх/

132.4. Хамгаалалт дохиоллын болон холбооны найдвартай ажиллагааг алдагдуулахгүй байх.

132.5. Нягт утаажиж, хорт хий ялгаруулахаас хамгаалах.

132.6. Хайгуулыг хорт хий, утаанаас хамгаалах багтайгаар туршлагатай даргалах бүрэлдэхүүнээр ахлуулан гал түймэр тархан дэлгэрэх бүх чиглэлд хийх.

132.7. Хайгуулын үед үндсэн үүргээс гадна дараах нөхцөл байдлыг тодруулна. Үүнд:

132.7.1. Эрчим хүчний объектын ээлжийн ахлагчтай холбоо тогтоож галын нөхцөл байдалд үнэлгээ өгч гал унтраах албан ёсны зөвшөөрлийг бичгээр авах.

132.7.2. Аврагч, гал сөнөөгч нар ямар цех, хэсгийн өрөө, тасалгаанд орж ажиллаж болохыг тодотгох.

132.7.3. Гал унтраах явцад цахилгаан тоног төхөөрөмж аюултай байж болох, ямар систем, агергатаар гал дамжин тархаж дэлгэрэхийг тодруулах.

132.8. Эрчим хүчний объектод гарсан гал түймрийг унтраахдаа объектын болон Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийн заалтыг мөрдөх.

132.9. Цахилгаан тоног төхөөрөмжид гарсан галыг юуны өмнө байнгын гал унтраах хэрэгслийг ашиглан унтраах.

132.10. Цахилгаан тоног төхөөрөмжийн гал унтраах ажиллагааг объектын инженер техникийн ажилтан нарыг оролцуулан, гал түймэр унтраах шуурхай штаб байгуулж, тэд нартай харилцан тохиролцсон үндсэн дээр цахилгаан гүйдлийг салгасны дараа гүйцэтгэх.

132.11. Гал түймэр унтраах аврах ангийн бүрэлдэхүүнээс цахилгаан тоног төхөөрөмжийн хүчдэлийг салгаж, унтраах үйл ажиллагааг бие дааж дур мэдэн үйлдэхийг хатуу хориглох.

132.12. Резинэн болон хуванцар хийцийн тусгаарлагч бүхий кабель шугамын утас их байгаа байранд гарсан гал түймрийг унтраахдаа бие бүрэлдэхүүнийг хордлогоос хамгаалж, хорт хий утаанаас хамгаалах багтай ажиллуулах.

132.13. Барилгын хийц бүтээцэд задаргаа хийхдээ цахилгаан шугам сүлжээ, агергат, тоног төхөөрөмжийг гэмтээхгүй байх

132.14. Кабелийн туннельд гарсан гал түймрийг агаар механикийн бага буюу дунд өсөлтийн хөөс, инертийн хийгээр унтраахын хамт кабелийн хагас давхар, туннелээс татсан кабелийн байранд гал тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах.

132.15. Цахилгаан тоног төхөөрөмж бүхий байранд нэг дор олон тооны хүмүүс байлгахгүй байхаар урьдчилсан арга хэмжээ авах.

133. Их хэмжээний талбай бүхий шатамхай хучилттай барилгын гал түймрийг унтраах:

133.1. Их хэмжээний утаа ялгаруулан хучилтын хөндий болон доод талын гадаргуугаар түргэн хугацаанд гал тархан дэлгэрэх.

133.2. Хучилт нь нурах, түүнд задаргаа хийхэд бэрхшээлтэй байх.

133.3. Гарсан галыг унтраахдаа галын хушууг нэгэн зэрэг хоёр чиглэлд ажиллуулах.

133.4. Гадна орцноос галын голомт хүртэл ихээхэн хол зайтай байх.

133.5. Хучилтын доод хэсгийн галыг суурьтай болон "А", дээд хэсгийн галыг "А" буюу "Б" хушуугаар унтраах.

133.6. Хучилтын ферм, зангилгаа хэсэг, тулгуур багана зэрэг даацын үндсэн хийц бүтээцийг галын дөлнөөс хамгаалахаар хушуу ажиллуулах.

133.7. Хучилт нь гал эсэргүүцэх, гал тэсвэршилттэй бүстэй байлаа ч уг бүсийн доод талаар нөгөө хэсэгт гал тархахаас хамгаалан зохих тооны хүн хүч, хэрэгсэл ажиллуулах.

133.8. Гал унтрааж дуусах хүртэл хайгуулыг үргэлжлүүлэн хучилтын хийц бүтээцэд байнгын ажиглалт хийж байх.

133.9. Хучилтын гал нь илт тархан дэлгэрсэн тохиолдолд завсар зай гаргаж, шатаагүй хэсгийг хамгаалах, түүний тулд гал эсэргүүцэх ханыг ашиглан шаардагдах тооны хүч хэрэгслийг ажиллуулах.

134. Нэхмэл, сүлжмэлийн үйлдвэрт гарсан гал түймрийг унтраах:

134.1. Хялбар шатах хөвсгөр материалаар дамжин гал түймэр хурдан тархахаас гадна технологийн болон бусад зориулалтаар хана хучилтад гаргасан нүх, цоорхой, агааржуулалт, хийн даралтаар ажилладаг дамжуулагчаар дамжин хэд хэдэн чиглэлээр гал түймэр тархах.

134.2. Байр, тасалгаанууд шатлагын хорт бодисоор дүүрч, утаа их болсон байх.

134.3. Барилгын давхар хоорондын болон дээврийн шатамхай материалаар хийсэн хучилтын хөндий зайгаар галын дөл тархах.

134.4. Төмөр багана даацаа алдах, давхар хоорондын хучилт нурж унах.

134.5. Гал түймрийн үед хушуугаар ажиллахын зэрэгцээ утаа сорогч, зөөврийн хэрэгсэл, цонх, хаалга зэргийг ашиглан утааг зайлуулах ажлыг гүйцэтгэх.

134.6. Агааржуулалтын систем, технологийн дотоод тээврийн хэрэгслийг цахилгаан гүйдлээс салгаж зогсоох, эдгээрт тархсан галыг агаар механикийн хөөсөөр унтраах.

134.7. Хөвөн болон нийллэг материалд гарсан галыг нэвчлэгч, усаар унтраах.

134.8. Барилгын хучилт, баганын хийц бүтээц, агааржуулалтын болон даралтат дамжуурга, тээврийн төхөөрөмжийн байдлыг шалгах ажлыг зохион байгуулах.

134.9. Шатах материалаар хийгдсэн давхар хоорондын хучилтын шатлагыг агаар механикийн хөөсөөр унтрааж, хучилтын дээд доод хэсэгт задаргааг нэгэн зэрэг хийх.

135. Гурил тэжээлийн үйлдвэр, үр тарианы агуулахад гарсан гал түймэр унтраах:

135.1. Гурил, тэжээлийн үйлдвэр, үр тарианы агуулахад гал түймэр гарсан үед галын дөл нь өрөө тасалгаа, барилгын хучилтын болон тоосны систем, тариа тээвэрлэх технологийн шугам бусад тоног төхөөрөмж, галерей, барилгын хийц бүтээцээр дамжин тархах.

135.2. Гурилын болон үр тариа хадгалах байрны тоосжилт тэсэрч барилгын хийц бүтээц нурах.

135.3. Галын хайгуулыг хийхдээ үйлдвэр, хадгаламжийн барилгын хийц бүтээц, агааржуулалт, тоосны систем, үр тариа, гурил дамжуулах дотоод тээврийн систем зэргийн онцлог тэдгээрээр дамжин гал түймэр тархах боломжийг нарийвчлан тогтоох.

135.4. Үйлдвэр, хадгаламжийн технологийн ажиллагаа агааржуулалтын болон тоосны системийн ажиллагааг хаах буюу зогсоох хэрэв хаалтын төхөөрөмж гэмтсэн бол агаар, дамжуулах хоолойг задалж, түүнийг агаар механикийн хөөсөөр дүүргэх.

135.5. Үр тариа хадгалах барилгад гарсан гал нь богино хугацаанд доод давхар, тээврийн шугамаар тархан дэлгэрэхээс урьдчилан сэргийлж, хүн хүч, хэрэгсэл хүрэлцээгүй бол дарш хадгалах хэсгээс их хэмжээний тариа асгаж галын тархалтыг зогсоох.

135.6. Үр тариа хадгалах цамхагийн хэсэгт гал түймэр гарсан бол барилгын байнгын шат, автомеханик шат зэргийн тусламжтайгаар даршлах байрны дээд давхарын байрыг ашиглан цамхагийн дээрээс мөн барилгын дотор



талын шатыг ашиглан доод талаас нь бусад өрөө тасалгаатай холбосон нарийн хонгил, галерейн галыг унтраахад ашиглах.

135.7. Үйлдвэрт гарсан гал түймэр унтраах үед эхний хушууг галын голомт болон дээд давхаруудын галыг унтраахаар гаргаж ажиллуулах.

135.8. Гурилын болон үр тарианы тоос, гурилыг урьдчилан норгож дараа нь бөөн тусгалаар ус өгөх.

135.9. Шатлага явагдаагүй зэргэлдээх байрны барилгын хийц бүтээц, тоног төхөөрөмжийг усны цацрагаар норгох.

135.10. Галерей болон дотоод тээврээр дамжин гал түймэр тархан дэлгэрэх явдлыг хязгаарлахын тулд усан хөшгөөр хамгаалах, бас тээврийн туузыг тасалж зайлуулах арга хэмжээ авах.

135.11. Шатлага явагдаагүй байранд байгаа тариа, гурилыг уснаас хамгаалах ажлыг зохион байгуулах.

135.12. Үр тариа хатаах байранд гал түймэр гарсан үед гал түймэр унтраах удирдагч нь хатаагч камерт дулаан өгөхийг зогсоох, салхивчуудын ажиллагааг хаах, хатаагч байрнаас агуулах руу тариа өгөхгүй байх, шатаж буй тариаг хатаагч руу их хэмжээгээр буулгах зэрэг арга хэмжээг авах.

136. Мод боловсруулах үйлдвэр, модон материалын агуулахад гарсан гал түймэр унтраах:

136.1. Галерей, тээврийн шугам, агааржуулалт, тоосны систем, их хэмжээний шатах материал, үйлдвэрийн хаягдал дамжиж гал түймэр хурдан тархах.

136.2. Кардон, цаасны үйлдвэрийн машин. хатаалгаар гал эрчимтэй тархах.

136.3. Шатаж байгаа модон материалын оч, дөл хийсч гал түймрийн шинэ голомтууд бий болох.

136.4. Хураалттай модон материал нурж унах.

136.5. Туузан дамжуулагч тасрах, хөрөөдсөн болон хөрөөдөөгүй модон материалын агуулахад гарсан гал түймэр их хэмжээний дулааны илч ялгаруулах.

136.6. Хлор болон бусад хорт хий, утаа ялгаруулах.

136.7. Гал түймрийн тархалт, хорт хий ялгаруулахыг зогсоох хязгаар заагийг тодорхойлж, ажиллаж буй хушуу нь гал түймэр унтраахад хүрэлцээтэй эсэхийг тогтооно. Үүнд:

136.7.1. Шатлагын бүсэд хүчтэй хушуу гарган унтраахын зэрэгцээ зэргэлдээх барилга байгууламж, хураалттай модон материалыг нэмэгдэл хушуугаар хамгаалах.

136.7.2. Хоорондын завсарыг агаар механикийн хөөсөөр дүүргэх тусгай хэсэг тавих, эцэст нь барилга байгууламж хураалттай модон материалд задаргаа хийх, өөр газар зөөвөрлөх зэргээр зай гаргах.

136.7.3. Ойрхон байгаа гол мөрөн, нуур цөөрөм зэрэг усны эх үүсвэрийг ашиглах, ус дутагдалтай үед гал түймэр унтраах усаар тасралтгүй хангах ар талын албыг зохион байгуулах.

136.7.4. Гал түймрийн тархалт, унтраах үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж хайгуулыг тасралтгүй хийх.

136.7.5. Шатаж байгаа газраас хөнгөн материал салхинд хийсч шатлагын шинэ голомтыг бий болгохоос хамгаалж харуул, хэсэг томилох.

136.8. Бие бүрэлдэхүүнийг /жолоочийг оролцуулан/ хорт хий утаа, дулааны үйлчлэлээс хамгаалах хэрэгсэлээр хангаж, бэлтгэл хүн хүч, хэрэгсэлийг байнгын бэлэн байдалд байлгах.

136.9. Мод боловсруулах үйлдвэр, модон материалын агуулахад гарсан гал түймрийг унтраах үед усны нөөц хангалттай болсон үед суурьтай болон "А" хушуу хэрэглэх.

136.10. Хураалттай гуалин болон хөрөөдсөн модон материалд гарсан гал түймрийг дээд хэсгээс нь эхлэн банз, гуалингийн үзүүр талаас нь хураалтын байдлыг харгалзан унтраах.

136.11. Гарсан гал түймрийг унтраахын зэрэгцээ шатлагад автагдаагүй модон материалыг механизм ашиглан зайлуулах арга хэмжээ авах

136.12. Модон материалын агуулахад гарсан гал түймрийг унтраахаар ажиллаж буй албан хаагчдыг дулаан тэсвэрлэх хувцастай ажиллуулах.

136.13. Барилга, хураалттай модон материал, усан санд дөхөж ойртох зам гарц нь модон материал, үйлдвэрийн хаягдлаар дүүрч хаагдсан байх.

136.14. Хөрөөдсөн болон хөрөөдөөгүй модон материалын агуулахад гарсан гал түймэр нь их хэмжээний дулаан ялгаруулах.

137. Төмөрлөгийн үйлдвэрт гарсан гал түймрийг унтраах:

137.1. Өндөр даралтын шингэний систем, их хэмжээний тээврийн систем, кабелийн давхар суваг, масло дамжуулагчаар гал түймэр эрчимтэй тархах.

137.2. Гал түймэр нь газрын түвшингийн доороос гарч өндөр дөлтэйгөөр тархан дэлгэрэх.

137.3. Гал түймрийн голомтоос алсад дэлгэрч ихээхэн эзэлхүүнтэйгээр нягт утаажих.

137.4. Металлын хайлш, хаягдал урсах.

137.5. Даралттай дамжуулах хоолой, аппаратаас хий, шингэн бамбарлаж асах.

137.6. Үйлдвэрийн нутаг дэвсгэр кокс, аммиак, хайлуулах зуухны болон бусад хийнээс хордлогын бүс үүсч хий дэлбэрэх.

137.7. Галын хайгуул өөрийн үндсэн үүргээс гадна технологийн тоног төхөөрөмжийг зогсоох, цахилгаан хүчдэлийг салгасан эсэхийг тогтоох.

137.8. Шингэний системд масло өгөх, хялбар авалцан асах болон шатах шингэлгийг нүүрс дамжуулах зам, уурхайд нэмэгдлээр өгөх шаардлагатай эсэхийг судлах.

137.9. Туузан дамжуулагч, шилжүүлэн ачих зангилгаа, кабелийн суваг, газар доорхи давхар, машин зааланд гал түймэр тархах боломжтой эсэхийг тогтоох.

137.10. Гал түймэр гарсан үед гал түймэр унтраах шуурхай штаб зохион байгуулах.

137.11. Ажиллах орчны агаарт шинжилгээ хийлгэх зорилгоор мэргэжлийн албыг татан оруулж, хорт хий, утанаас хамгаалах багтай ажиллах.

137.12. Туузан дамжуулагчид гарсан гал түймрийг унтраахдаа хүчтэй хушуугаар ус өгөх ажлыг зохион байгуулахын зэрэгцээ даацын хийц бүтээц, ачих зангилгаа, багануудад хамгаалалтын хушуу гарган хушуучдын байрлалыг тодотгох.

137.13. Маслын хүчтэй шаталтын үед төмөр нуруу, дээврийн галыг унтраах, хөргөхөд хүчтэй хушуунуудыг ашиглах.

137.14. Цахилгаан машины танхимын зүгээс масло дамжуулах сувгийн хамгаалалтад хөөсний хушуу өгөх.

137.15. Шингэний системээс масло асгарсан үед объектын захиргаанд мэдэгдэж масло өгөх ажиллагааг зогсоох арга хэмжээ авах.

137.16. Маслотой хонгилд гарсан галыг хөөсний хушуугаар унтраах, аваар ослын үед масло асгарсан байвал зэргэлдээх даацын хийц бүтээцийг хөргөж ажиллах.

138. Хөргөгч бүхий байранд гарсан галыг унтраах:

138.1. Тавиурууд болон түүн дээр хураасан эд материал бүхий байранд гал богино хугацаанд тархах.

138.2. Гарсан гал нь гадна талдаа амархан халдаггүй дулаан тусгаарлагчаар дамжин шатах учраас галын голомт нь олдохгүй байх.

138.3. Байр нь гэрэлтүүлэг багатай, утаа ихтэй байх.

138.4. Даацын хана болон төмөр хоолойгоор сүвлэн тавьсан дулаан тусгаарлагч, давхар хоорондын хучилт, өргөгч шат, шатны хонгилоор дамжин дээд давхар болон агааржуулалтын сувгаар гал тархан дэлгэрэх.

138.5. Хөргөгч бодис дамжуулах шугам, аммиак бусад хөргөгч бодис бүхий шугам сүлжээ, төхөөрөмж байдаг учир гал гарсан үед тэсрэлт үүсч болзошгүй байдаг. Иймд:

138.5.1. Хөргөгч бодис бүхий шугам сүлжээнд аваар гарсан үед бие бүрэлдэхүүн түлэгдэх, хордох аюулаас сэргийлэх.

138.5.2. Шатлага явагдаж буй газар, тархалтын хэмжээ, утаажилтын байдал, хүмүүст аюул тулгарч байгааг харгалзан аврах ажлыг зохион байгуулах, гал эсэргүүцэх бүс /тусгаарлагч/ бий эсэх, барилгын хийц бүтээцэд болон хадгалж буй бодис, бүтээгдэхүүний талаар мэдээ авах, тодруулан тогтоох.

138.5.3. Утаа ихтэй болон аммиак бусад бодис ялгарсан орчинд гал түймрийг унтраахдаа хорт хий, утаанаас хамгаалах баг, утаа сорогч, гэрэлтүүлэг зэргийг хэрэглэж ажиллах.

138.5.4. Шатлага явагдаж байгаа байранд хөргөгч бодис өгөх, агааржуулалтын системийн ажиллагааг зогсоох, хөргөгч төхөөрөмжүүд болон хөргөлтийн системийн гэмтсэн хэсгийг гал түймрийг унтраахаар ажиллаж байгаа албан хаагчдад аммиак үйлчлэхгүй байхаар салгах.

138.5.5. Галын тархалтын хязгаарыг тогтоохын тулд дулаан тусгаарлагчид шалгалтын бүрэн задаргаа хийх.

138.5.6. Аюул бүхий бүсээс эд материал, бүтээгдэхүүнийг аварч гаргах арга хэмжээ авах.

138.5.7. Гал гарсан хэсэгт буй өндөр хүчдэлийн цахилгаан төхөөрөмжийг цахилгаан гүйдлээс салгах.

138.5.8. Галын голомтод ус өгөх, дулааны үйлчлэл, утаажилтыг багасгахын тулд шаардлагатай тохиолдолд хана буюу хучилтыг цоолох.

138.5.9. Хөргөгч сав, халуун тусгаарлагч бүхий байранд гарсан галыг нэвчлэгч бүхий нарийн цацраг усаар буюу агаар механикийн хөөсөөр унтраах.

139. Дэлгүүр, барааны агуулахад гарсан галыг унтраах:

139.1. Худалдааны байгууллага, агуулах нь их хэмжээний багтаамжтай өндөр үнэ бүхий бараа материал байдаг онцлогтой тул гарсан галыг унтраах арга хэмжээ, хэрэгслийг сонгож авахдаа хадгалагдаж буй материалыг харгалзах.

139.2. Эдгээр газруудад гарсан гал түймрийг унтраах гал түймэр унтраах удирдагч нь галын хайгуулаар тогтоовол зохих нийтлэг үүргээс гадна дараах зүйлийг тодруулна. Үүнд:

139.2.1. Бараа материалын байршил хураалт, хайрцаг, савны тоо хэмжээ

139.2.2. Гал түймрийг унтраах ямар хэрэгслээр, яаж унтраах аргыг тогтоох

139.2.3. Үнэт бараа материалыг зөөж гаргах, ачих, буулгах хэрэгсэл, харуул хамгаалалт тавих шаардлагатай эсэхийг тодруулах.

139.3. Эгшин зуур авалцан асах, тэсрэх, дөллөн шатах аюултай бодис хадгалсан агуулахад гарсан галыг унтраахдаа бие бүрэлдэхүүний хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах асуудлыг урьдчилан боловсруулж тэсрэлт үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

139.4. Гал гарсан дэлгүүр, агуулахад ус өгсөнөөс шатлага нь эрчимжих бодис материал байвал юуны түрүүнд зөөж гаргах.

139.5. Дэлгүүр, агуулахын байранд гарсан гал нь өндөр температур, их утаатай байдаг учраас гал түймрийг унтраахдаа хорт хий, утаанаас хамгаалах баг, утаа сорогч хэрэглэхээс гадна цацруулагч хушуугаар ус өгөх, агаар механикийн хөөсийг ашиглах.

139.6. Дэлгүүр, агуулахад гарсан галыг унтраахдаа үр ашиггүй их ус зарцуулахаас болгоомжилж, хадгалж буй бараа материал юуны түрүүнд үнэтэй бараа материалыг зөөж гаргах.

139.7. Хураалттай хөвөн материалд гарсан гал нь гадна талаараа хурдан тархах бөгөөд ийм галыг унтраахдаа брезент, бүтээлгээр хучих, норгох, шатаагүй боодолтой хөвөнг зөөж гаргах, нэвчлэгч бүхий усыг суурьтай "А" хушуугаар өгөх.

### **Гуравдугаар бүлэг**

#### **Ил задгай орчинд гарсан гал түймрийг унтраах**

140. Нефть хангамжийн баазын резерварт хадгалагдаж байгаа хялбар авалцан асах болон шатах шингэлэг, шингэрүүлсэн хийнд гарсан галыг унтраах:

140.1. Резервуар задрах, доторх шингэн хий нь дэвэрч асгарах, гадагш цацагдах.

140.2. Технологийн шугам хоолой болон бохир усны суваг бусад системд гал дамжин түгэн тархах.

140.3. Шатаж байгаа шингэлэг болон шатаагүй зэргэлдээх резервуар дах шингэний нэр, төрөл, хэмжээ, түвшин, доод усны түвшин, резервуарын тагны эвдрэлтийн шинж байдлыг нягтлан нарийн тогтоох.

140.4. Резервуарын далангийн байдал, резервуар задрах үед шингэн асгарах, цацагдах, тэсэрч дэлбэрэх, зэргэлдээх резерварт аюул учруулах эсэх, шингэний асгарч урсах чиглэл, замыг тодруулах.

140.5. Үйлдвэрийн бохирын болон үерийн усны сувгууд, хяналтын худаг, усан хаалт байгаа эсэх, тэдгээрийн ажиллагааны байдлыг тогтоох.

140.6. Резервуар дах шингэнийг юүлэх, гадагш гоожуулах, эсвэл резервуарыг ус буюу уураар дүүргэх бололцоо байгаа эсэхийг мэдэх.

140.7. Гал түймэр унтраах байнгын төхөөрөмж, усан хангамжийн хүрэлцээ, зэргэлдээх объектоос хөөс үүсгэгчийг богино хугацаанд татаж авах бололцоо байгаа эсэхийг тогтоох.

140.8. Агаар механикийн хөөсний атакэд бэлтгэх үед гал түймэр унтраах удирдагч дараах шаардлагыг хангавал зохино. Үүнд:

140.8.1. Гал гарсан газар тооцоо ёсоор хүрэлцэх тоо хэмжээний агаар механикийн хөөс үүсгэгч, хөөсний генератор, өргөгч механизм зэргийг бэлтгэх.

140.8.2. Шаардагдах тооны хөөсний генератор, өргөгч механизм, гал сөнөөгчдийг бэлтгэх асуудлыг чадвартай офицерт хариуцуулан өгөх.

140.8.3. Агаар механикийн хөөсний атак эхлэх, дуусах болон шатах шингэлэг асгарах, цацагдах зэрэг аюултай үед бие бүрэлдэхүүнийг холдуулах тусгай дохионуудыг тогтоож зарлах.

140.8.4. Резерварт гарсан галыг унтраахад тооцоо ёсоор шаардагдах хүн хүч, хэрэгслийг бэлэн болгосон байх.

140.8.5. Объектын захиргаа, инженер техникийн ажилтнууд оролцсон гал түймэр унтраах шуурхай штабыг зохион байгуулж, резервуар, түүнийг холбосон шугам сүлжээг хаах, агаар механикийн хөөсний атакэд бэлтгэх, шатаж байгаа болон зэргэлдээх резервуарыг хөргөх, аюулгүйн ажиллагааны дүрмийг сахиулах зэрэг үйл ажиллагааг хариуцсан ажилтнуудыг тус тус томилох.

140.8.6. Гал түймэр унтраах байнгын төхөөрөмжийг ашиглах.

140.8.7. Шатлага явагдаж буй бүс рүү шатахуун, хий орох шугамын хаалтыг хааж байгаа үйлчлэгч хүмүүсийг шаардлагатай үед усаар хамгаалах хушуу гаргаж ажиллуулах.

140.8.8. Шатахуун юүлэх эстакадад гал гарсан үед вагон цистернуудийг яаралтай холдуулах.

140.8.9. Гал гарсан газар хүрэлцэн ирмэгц юуны өмнө шатаж байгаа болон зэргэлдээх резервуаруудыг "А" буюу зөөврийн лафетны хушуугаар хөргөж, энэ ажиллагааг хөөсний атак хийж байгаа үед мөн галыг бүрэн унтрааж дууссанаас хойш ч гэсэн үргэлжлүүлэх.

140.8.10. Резервуарын паркийн далан дотор шатлага явагдаж буй үед агаар механикийн дунд өсөлтийн генератор гаргаж унтраах.

140.8.11. Хэрэв олон резерварт нэгэн зэрэг шатлага явагдаж, унтраах хүч хэрэгсэл дутагдалтай байвал юуны өмнө шатлага явагдаагүй зэргэлдээх резерварт аюул учруулж болох резервуарын галыг урьдаар унтрааж, дараа нь бусад резерварт гарсан галыг унтраах ажлыг зохион байгуулна.

140.8.12. Резервуарын галыг салхины дээд талаас авто өргөгч, автомеханик шат болон хөөс өгөгч төхөөрөмжийг ашиглан унтраах.

140.8.13. Резерварт гарсан галыг унтраасны дараа дахин шатлага үүсэхээс сэргийлж агаар механикийн хөөсийг тасралтгүй өгч, шатлагын гадаргууг хөөсөөр бүрэн бүрхэх.

140.8.14. Хөргөлтийн ажиллагааг галыг бүрэн унтраах, резервуарыг гүйцэд хөргөх хүртэлх хугацаанд үргэлжлүүлэн явуулах.

140.8.15. Резервуарын галыг унтраах хүн хүч, хэрэгсэл хүрэлцэхгүй байгаа тохиолдолд шингэнийг гадагш юүлэх арга хэмжээг хөргөлттэй нэгэн зэрэг явуулах.

140.8.16. Резервуар дах шатаж байгаа нефть бүтээгдэхүүн дэвэрч цацагдахаас сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй авахын тулд түүний халалтын байдалд тасралтгүй хяналт тавьж ёроолын усыг гадагш үе үе юүлж байх.

140.8.17. Ус, цахилгаан, тээвэр, цагдаа бусад албадтай холбоо тогтоож, галыг амжилттай унтраахад дэмжлэг авах

140.8.18. Аюулгүй байдлыг хангахын тулд гал унтраахаас бусад ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилчин, албан хаагчид, бие бүрэлдэхүүнийг далангийн дотор талаас холдуулж, далангийн дотор ажиллаж буй албан хаагчдын тоог цөөн байлгах үүднээс хушуучдыг ээлжлэн нэг нэгээр солих.

141. Ой, хээрийн түймрийг унтраах:

141.1. Ойн хээрийн түймэр нь их хэмжээний талбайг эзлэн богино хугацаанд хурдан тархдаг учир, гал түймэр гарсан газар орчныг сайн мэдэх хүнээр газарчлуулан нөхцөл байдлыг үнэлнэ. Үүнд:

141.1.1 Нөхцөл байдлыг үнэлэхдээ шатлагын байдал, тархсан талбай, газар орчны байдал, түймрийн тархалтын чиглэл, хурд, унтраах явцад гал түймэр нь төв суурин газар тархан шатаж болох эсэхийг тогтоох

141.1.2. Байгалийн усны хүрэлцээ, ойртож очих замыг ашиглах бололцоо байгаа эсэх.

141.1.3. Гал түймрийн тархалтад нөлөөлж болох хүчин зүйл /тухайлбал: залуу шилмүүст ой, унаж өгөршсөн мод, галд амархан шатах өвс ургамал, модон материалын түр агуулах гэх мэт/ байгаа эсэх.

141.1.4. Ойн зах, гал түймрийн хилд түймэр унтраах механикжсан хэрэгсэл хүргэх, шатлагыг зогсоож унтраах зам, гарц байгаа эсэх, тэдгээрийг ашиглаж болох эсэх.

141.1.5. Угтвар цурав тавих тулгуур газар, шугамыг хаана сонгож авах зэргийг тодруулан тогтооно. Түймэр нь ихээхэн тархаж, өргөн талбай эзэлсэн бол гал түймрийн тархалт, унтрааж буй явц, байдлыг нисэх онгоц, нисдэг тэрэг, газар зүйн байрлал болон өндөрлөг газрыг ашиглах, түймрийн захаар эргүүл хийх зэргээр тодруулах.

141.2. Ой, хээрийн түймрийг унтраах үед гол хүч, хэрэгслийг тухайн байдалд зохицуулан дараах чиглэлд төвлөрүүлнэ. Үүнд:

141.2.1. Төв суурин газар талаас

141.2.2. Ой, мод бэлтгэх үйлдвэр, агуулах талаас

141.2.3. Үлэмж их хэмжээний ой мод бүхий талыг хамгаалахад чиглүүлэх.

141.3. Хөрсний түймрийн үед гал дөлийг цохиураар цохих, шороо цацах, цурав тавих, далан гаргах.

141.4. Оройн мөчрийг тайрах, эсрэг /гал/ цурав тавих.

141.5. Ойн хөрсний түймрийн шатлагын бүх фронтын дагуу унтраах ажлыг нэгэн зэрэг явуулах буюу эхлээд фронт буюу шатлага явагдсан хэсэгт шатаж байгаа, цаашид түймрийн шинэ голомт үүсгэж болох аюултай голомтуудыг хэсэгчлэн жижиг голомт болгон унтраах.

141.6. Ой, хээрийн түймрийг юуны түрүүнд ар талаас нь унтрааж дараа нь хоёр жигүүрээр хаан шахаж шатлагын фронтын галыг унтраах.

141.7. Ой, хээрийн түймрийн шатлагын эрч нь орой, ялангуяа шөнийн цагт буурдаг учраас гал түймэр унтраах удирдагч нь энэ үеийг идэвхтэй ашиглаж унтраах арга хэмжээг яаралтай зохион байгуулах.

141.8. Ойн түймрийн цурам доторх түймрийг унтраахдаа захаас нь дотогш чиглэлээр цэвэрлэгээ хийх маягаар унтраана. Үүнд:

141.8.1. Цурамнаас гал алдагдуулахгүйн тулд голоороо шатаж буй модыг хөрөөдөж дотогш унагах.

141.8.2. Түймрийг цурам дотор зөвхөн дотогш чиглэлээр унтраах ба гол нь шатаж байгаа модыг хөрөөдөн унагах, унтраах.

141.8.3. Цурам дотор шатаагүй үлдсэн хэсгийг зурвас татан хамгаалах.

141.8.4. Үүрээр гал түймрийн эрч буурч багассан үед алв болох их хүчээр унтраах ажлыг зохион байгуулах.

141.9. Ой, хээрийн түймрийн тархалт ихэссэн үед нөхцөл байдлыг тогтоох, унтраах аргачлалыг сонгохын тулд агаарын хяналтыг зохион байгуулна.

141.10. Ой, хээрийн түймэр дээр ажиллахдаа аранз, галаас хамгаалах нөмрөг, эмч, холбоочинтой байх.

141.11. Ой, хээрийн түймрийг унтраах үед үлээгч аппарат, моторт хөрөө гэх мэт дуу чимээ ихтэй багажаар ажиллаж байгаа үед гал түймэр унтраах хэсгийг 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй томилно. Ой, хээрийн түймэрт 3 хоногоос дээш хугацаагаар ажилласан тохиолдолд тухайн сум суурин газраас хоол, хүнс шатах тослох материалын нөхөн хангалт хийлгэх.

### ***Дөрөвдүгээр бүлэг***

#### **Тээврийн хэрэгсэлд гарсан гал түймрийг унтраах**

142. Төмөр замын тээврийн хэрэгсэлд гарсан гал түймрийг унтраахад:

142.1. Төмөр замаар суудлын болон тээврийн хөдөлгөөнт хэсгүүд нь их хэмжээний ачаа тээвэрлэдгийг харгалзан дараах онцлогийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

142.1.1. Суудлын галт тэрэгний вагоны дотор тал, ачаа тээврийн вагонуудад гал түймэр эрчимтэй тархаж шатах.

142.1.2. Нефть бүтээгдэхүүн юүлэх вагон цистернүүдэд байгаа шатах шингэн талбайгаар асгарч гоожих.

142.1.3. Шатаж байгаа болон зэргэлдээх вагонуудад ойртох боломж хязгаарлагдмал учраас галын хоолой дэлгэхэд хүндрэл учрах.

142.1.4. Шатаж байгаа болон зэргэлдээх вагонуудын зорчигч нарт аюул учруулж, сандралд орох.

142.1.5. Усан хангамжийн хүрэлцээ муу буюу алслагдсан байх.

142.2. Төмөр замын галт тэрэгний диспетчертэй байнгын холбоотой байж гал түймрийн нөхцөл байдал, галт тэрэгний байршил, зам гарцын талаар болон гал түймэр унтраах үйл ажиллагаатай холбогдсон мэдээ, зөвлөгөө тогтмол авч ажиллах.

142.3. Галын даралтын хоолойг замын рельс доогуур буюу зам дагуулан галт тэрэгний хөдөлгөөн, сэлгэх байдалд саад болохгүйгээр дэлгэх.

142.4. Гарсан гал түймэр нь зэргэлдээх галт тэрэг, вагон ялангуяа зорчигчид байгаа вагонд тархах аюул, шатаж байгаа вагоны гал түймрийг цаашид дэлгэрүүлэхгүйгээр чөлөөтэй замд гаргаж болох эсэх, түүнчлэн шатаагүй вагонуудыг шатаж буй вагоноос холдуулж аюулгүй зайд гаргах боломжийг тогтоох.

142.5. Шаардлага гарвал шатаагүй вагонууд болон хажуу талын зам дээр байгаа галт тэрэг юуны түрүүнд зорчигчидтой вагон, тэсрэх, хордуулах, хялбар авалцан асах, шатах шингэлэг бүхий цистернуудийг сэлгэн холдуулах ажлыг зохион байгуулах

142.6. Тээвэрлэж яваа ачааны шинж байдлыг харгалзан ус, агаар механикийн хөөс бусад унтраах хэрэгслийг сонгон авч хэрэглэх.

142.7. Зорчигч тээврийн вагоны бүх өрөө тасалгаанд хайгуулын ажлыг нарийн явуулах.

142.8. Хялбар авалцан асах, шатах шингэн бүхий цистернд гарсан гал түймрийг унтраахдаа шингэнд гарсан гал түймрийг унтраах аргыг хэрэглэх.

142.9. Шатамхай шингэн асгарсан үед далан байгуулах буюу урсгаж холдуулах суваг татах ажлыг зохион байгуулах.

142.10. Төмөр замын станцад байгаа гал түймэр унтраах бүх хэрэгсэл тухайлбал усан хангамж, гал түймэр унтраах галт тэрэг зэргийг ашиглах.

143. Нисэх онгоц, нисдэг тэргэнд гарсан гал түймэр унтраахад:

143.1. Нисэх онгоц, нисдэг тэргэний түлшний систем гэмтсэнээс болон суудлын бүхээг дотор талын шатамхай материалаар дамжин гал түймэр хурдан тархах.

143.2. Авралтын хаалга, нээлхий нь гацсанаас доторхи зорчигч нарт аюул учруулах, авралтын ажлыг хүндрүүлэх.

143.3. Электрон, магний болон бусад хайлшуудаар хийгдсэн эд анги, хэсгүүд шатах.

143.4. Онгоцны буудалгүй газар нисэх онгоц, нисдэг тэргэнд гарсан галыг унтраахад ойртон очих газаргүй, усны хүрэлцээ хангалтгүй байх зэрэг тохиолдол гарах.

143.5. Нисэх онгоц, нисдэг тэргэнээс үйлчлэгч, багийн бүрэлдэхүүн зорчигчдыг аль болох богино хугацаанд аварч гаргах ажлыг зохион байгуулах.

143.6. Юуны түрүүнд онгоцны их биеийн доод хэсгийн шатахууны галыг тухайлбал авралтын хаалга, нээлхийд гарсан гал түймрийг агаар механикийн хөөсөөр бусад их биеийг усаар хөргөн, галын дөлийг усны хүчтэй хушуугаар унтраах арга хэмжээ авах.

143.7. Авралтын үндсэн болон аваарийн хаалга, нээлхий, шаардлагатай үед их биеийн бүрээсний зарим хэсэгт тусгай хөрөө, металл тасдагч ашиглаж задаргаа хийх.

143.8. Нисэх аппаратын их биеэр гал түймэр дамжин хурдан тархахаас урьдчилан сэргийлэх, агаар механикийн хөөсний хушууг онгоцны хөдөлгүүр, нисэгчдийн бүхээг, их биеийн хэсэг, түүнчлэн баллон тэсэрч болох хэсгүүдэд чиглүүлж ажиллуулах.

143.9. Гал түймэр унтраах явцад нисэх онгоц, нисдэг тэргийг салхины дагуу галын дөл тархах явдлыг хязгаарлах зорилгоор татагч механизм ашиглаж эргүүлэх, сэлгэх 143.10. Салхитай үед нисэх аппаратын дээд хэсэгт хялбар авалцан шатах шингэлэг шатах буюу газраар урссан шингэнийг бетон хэсгээс шороон



гадаргуу руу эсвэл усны суваг руу урсгах харин салхигүй бол агаар механикийн хөөс, ферон, нүүрсхүчлийн хий зэргээр бүрхэж, унтраах.

143.11. Нисэх онгоц, нисдэг тэрэг нь зогсоол дээрээ шатаж байгаа үед хажуугийн онгоц аппаратуудыг усаар хөргөж, нэн даруй аюулгүй бүсэд зайлуулах.

143.12. Нисэх онгоц, нисдэг тэрэгний хөөргөх, буулгах төхөөрөмжид гарсан галыг унтраахдаа магни хайлшийн хэсгийг шатлагаас тусгаарлахын тулд хушууны үзүүрт 5-7 атмосфер даралттай байхаар хүчтэй бөөн усан цацраг гаргаж ажиллах.

143.13. Хушуучдын аюулгүй байдлыг хангахын тулд тэдгээрийг шатлага явагдаж буй газраас 8-10 метр хол зайд байрлуулах.

143.14. Аваарийн байдалтай нисэх онгоцыг авран хамгаалах алба, нислэгийн удирдагчтай хамтран бие бүрэлдэхүүнийг галд тэсвэртэй хувцас, хорт хий, утаанаас хамгаалах баг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хувцасаар иж бүрэн хувцаслаж онгоц хөөрөх, буух зурвасны дэргэд шаардлагатай хүн хүч, техник хэрэгслийг төвлөрүүлсний эцэст буулгах.

143.15. Нисэх онгоц, нисдэг тэрэгний битүү болон задгай зогсоол, засвар үйлчилгээний газар гал гарсан үед дараах зүйлийг анхаарах шаардлагатай. Үүнд:

143.15.1. Битүү зогсоол, засварын газрын барилгын хийц бүтээцийг усны бөөн тусгалтай хүчтэй хушуугаар хөргөж хамгаалах

143.15.2. Нисэх онгоц, нисдэг тэргийг чиргүүлт техник ашиглан аврах, аюулгүй бүсэд гаргах.

144. Гарааш, троллейбусны паркт гарсан гал түймрийг унтраахад;

144.1. Автомашины гарааш, троллейбуст хүчдэлийн цахилгаан сүлжээ нь богино холбоо, шилжилтийн эсэргүүцэл, хэт ачаалал болж гал түймэр гарах.

144.2. Шөнийн цагт гарааш, паркийн дотор болон гадна дэвсгэр талбайд автомашин троллейбусыг ихээр байрлуулах.

144.3. Тээврийн хэрэгсэл, шатамхай материалаар баригдсан хучилтаар гал түймэр хурдан тархах.

144.4. Гал түймэр унтраах тархалтыг хийхдээ авран хамгаалах ажиллагаанд саад болохгүйгээр зохион байгуулах.

144.5. Анхны "А" хушууг гарааш, паркийн дотор талд гарсан гал түймрийг унтраахаар ажиллуулах.

144.6. Барилгын хийц бүтээцэд гарсан гал түймрийг унтраахын хамт тээврийн хэрэгслийг хамгаалах, бензиний сав дэлбэрэхээс болгоомжлон шаардлагатай үед агаар механикийн хөөс өгөх.

144.7. Гарааш, парк, талбайд байгаа машин, техникийг үйлчлэгч, техникчдийг дайчлан трактор, тээврийн бусад хэрэгсэл ашиглан түрэх, жолооны хүрдийг залах зэрэг арга хэрэглэн аварч гаргах.

144.8. Гарааш, парк дотор өндөр хүчдэлийн цахилгаан гүйдлийг салгаж, таслах арга хэмжээ авах.

144.9. Барилгын хийц бүтээц, ялангуяа дээвэр багануудыг эрчимтэй хөргөж утааг зайлуулах

### ***Тавдугаар бүлэг***

#### **Хөдөөгийн суурин газар гарсан гал болон хээрийн түймрийн унтраах онцлог**

145. Хөдөөгийн суурин газар гарсан гал болон хээрийн түймрийн унтраахад

145.1. Хөдөөгийн суурин газар, хээрийн түймэрт голчлон гал даах дөрөв, тавдугаар зэрэгт хамаарагдах хялбар шатах барилга, гэр, амбаар, өвс, бутлаг ургамлаар гал хурдан дамжин тархаж дараах нөхцөл байдлыг үүсгэдэг. Үүнд:

145.1.1. Галд шатсан зүйл хол хийсч галын шинэ голомт бий болгох.

145.1.2. Усан хангамж дутагдалтай байх.

145.1.3. Зам гарц муу байх.

145.1.4. Гал түймэр унтраах аврах анги, хэсэг, мэргэжлийн байгууллага байхгүй байх.

145.2. Хөдөөгийн суурин газарт гарсан гал, хээрийн түймрийг унтраахдаа галын үндсэн тусгай албаны автомашин гал унтраахад зориулан төхөөрөмжилсөн хөдөө аж ахуйн болон бусад техник /ус, сүү, бензин тээвэрлэгч, ус шүршигч анжистай трактор, бороожуулагч насос бүхий автомашин, трактор/ зэргийг ашиглах,

145.3. Хөдөө суурин газар /сум, баг, аж ахуйн нэгж/, хээрийн түймрийг унтраах төлөвлөгөөг орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, гал түймэр унтраах аврах анги, сум, баг, аж ахуйн нэгж хэсэг урьдчилан боловсруулсан байх.

145.4. Анги, хэсгийн жижүүр, орон нутгийн холбооны салбар зэргийг ашиглан гал түймрийн дуудлагын хуваарь ёсоор ирэх хүн хүч, хэрэгслийг цаг алдалгүй дуудах ажлыг зохион байгуулах.

145.5. Галын шатлагын талбай, тархан дэлгэрэх, чиглэл, хүмүүс болон мал, амьтан зэргэлдээх барилга, байр сууц, гэр, үнэт материал, агуулахад учруулах аюулын зэргийг тодотгон тодорхойлох.

145.6. Шийдвэрлэх чиглэлд байгаа хүн хүч, хэрэгслийг ашиглан гал түймэр унтраах ажлыг зохион байгуулахын хамт галын тархалтыг зогсоох, хязгаарлах, хүмүүсийг аврах, мал, эд хөрөнгийг зөөж холдуулах арга хэмжээ авах.

145.7. Гал түймэр тархан дэлгэрэхээс хамгаалах зурвас далан гаргахдаа трактор, бульдозер зэрэг техникийг өргөн ашиглах.

145.8. Гал түймэр унтраахад ашиглах байгалийн усан санд дөхөж ойртох боломжгүй бол мотопомп, гидроэлеватор ашиглах арга хэмжээ авах.

145.9. Улсын нөөцийн болон орон нутгийн нөөцийн салбар, сүрэл, багсармал тэжээлд гарсан гал түймрийн ил дөлийг унтраахын тулд бололцоотой бол нэвчлэгч бүхий усан хушуу гаргаж ажиллуулах.

145.10. Хөдөө аж ахуйн техник, малчин, ажилчдын хүчээр шатаж буй өвс, сүрэл, багсармал тэжээлийг тараах, зөөж зайлуулан галыг унтраах.

145.11. Зэргэлдээ байгаа шатаагүй өвс, сүрэл зэргийг хамгаалахын тулд цацруулагч хушуугаар ус тавих, устай хувин бүхий хүмүүс ажиллуулах, брезинт, эсгийгээр хучиж, норгож чийглэх арга хэмжээ авах.

145.12. Бордоо химийн хордуулагч бодис, гербицидийн агуулахад гарсан гал нь хүмүүсийг хордуулах аюултай тул тэдгээрийн шинж чанарыг сайн мэдэх мэргэжилтнийг унтраах ажилд татан оролцуулж зөвлөгөө авах, аюулгүй ажиллагааны асуудлыг хариуцсан хүн томилж, анхны тусламж үзүүлэх хэсгийг зохион байгуулж ажиллуулах.

145.13. Хадгалж буй бодис материалын онцлог шинж байдалд тохируулан гал түймэр унтраах хэрэгслийг сонгон авч хэрэглэх.

145.14. Химийн хордуулагч бодис материалд гарсан гал түймэр унтраасан усыг хүн, малд аюулгүй газар тунахаар урьдчилсан арга хэмжээ авах.

145.15. Гал түймэр унтрааж буй хушуучдыг салхины дээд талд байрлуулах, агуулахын дотор ажиллаж байгаа албан хаагчид хорт хий утаанаас хамгаалах багтай ажиллах.

145.16. Салхины доод талд байрласан орон сууц, малын байрлуу хордуулагч хий, уурын манан бөөгнөрч нүүх тохиолдолд тэнд байгаа хүн, малыг яаралтай нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авах.

145.17. Тарианы талбайд тархсан галын талбайн хэмжээ, салхины хурдаас хамааран хүн хүч, хэрэгслийн байдлаас шалтгаалж автоцистерн, ус тээвэрлэгч, ус шүршигч зэргийг ашиглан шатлагын фронт дагуух хөрсийг норгох, шүүр, цохиураар цохих, анжистай трактор ашиглан хөрсийг эргүүлэн хязгаарлах хаалт зурвас гаргах зэргээр галын тархалтыг зогсоож унтраах арга хэмжээ авах.

145.18. Улс орны хэмжээнд хавар, намрын хуурайшилт, гал түймрийн тархан дэлгэрэлтийн хурд болон хүмүүст аюул учруулж байгаа байдлыг харгалзан гал түймрийн тархалтыг дэлгэрүүлэхгүй байх, шатлагыг байгаа хэмжээнд нь зогсооход бүх хүн хүч, хэрэгслийг богино хугацаанд цаг алдалгүй төвлөрүүлэн зохион байгуулах арга хэмжээг авах.

## **ГУРАВДУГААР ХЭСЭГ ТОМИЛГООТ ЭЭЛЖИЙН АЖИЛЛАГААНЫ ҮНДЭС**

### ***Нэгдүгээр бүлэг***

#### **Нийтлэг үндэслэл**

146. Аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтэс нь гал түймэр унтраах аврах анги, хэсэг, эрэн хайх аврах анги, салбараас бүрдэнэ. Онцгой байдлын газар, хэлтэс нь Онцгой байдлын ерөнхий газрын эрхлэх асуудлын хүрээнд багтан түүний удирдлагын доор Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт мэргэжлийн нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах, аюул осол болон гал түймэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэхтэй холбогдсон ажлыг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж чиглүүлэх, гамшиг болон гал түймрийн үүсэлт, шалтгаан нөхцөлийг судлах, арилгах гамшиг, гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмж, мэргэжлийн боловсон хүчний хангалтыг зохион байгуулах, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

147. Томилгоот ээлжийн бие бүрэлдэхүүн нь өөрсдийн үүргийг биелүүлэхийн тулд

147.1. Өргөсөн тангарагтаа үнэнч байж төр, аж ахуйн нэгж, хүний амь бие, өмч хөрөнгийг гал түймрийн болзошгүй аюулаас авран хамгаалахад чин шударгаар зүтгэх.

147.2. Албаны нууцыг нарийн чандлан сахих, хувийн болон албаны бэлтгэл бэлэн байдлыг өндөржүүлэх.

147.3. Гал түймэр унтраах оноолт үүргийг гүйцэтгэхдээ мэргэжлийн ур чадвар, авхаалж самбаа гарган ажиллаж дарга, захирагчийнхаа үүрэг даалгаврыг ёсчлон гүйцэтгэж сурах.

147.4. Газар, хэлтэс, салбар, анги, хэсэг хариуцсан албан тушаалтнууд өөрсдийн бие бүрэлдэхүүнд дээрх хүмүүжлийг төлөвшүүлэхэд үлгэрлэн манлайлах.

### **Хоёрдугаар бүлэг**

#### **Албаны нууцыг хадгалах**

148. Онцгой байдлын байгууллагын нийт офицер, ахлагч нар албаны нууцыг чандлан сахих нь нэн тэргүүний чухал зорилт мөн.

148.1. Албаны нууцыг алдах, задруулахад хүргэвэл зохих хууль тогтоомжийн дагуу ноцтой гэмт хэрэг өдүүлсэнд тооцогдоно.

149. Албаны нууцыг задруулсанд тооцогдох хүчин зүйлүүд:

149.1. Хамгаалж байгаа объект газрын тухай холбогдох ямар нэгэн мэдээг бусдад задруулах

149.2. Анги, хэсгийн өөрчлөлт, хүний тоо, байлдааны бүх төрлийн зэвсэг техник мөн түүнчлэн хариуцсан газрын нийт хамгаалалтын журам, зарчмын тухай.

149.3. Ямар нэгэн зөрчил гарсан тухай бусдад задруулах.

149.4. Албаны яриаг олон нийтийн газар болон бусад хүмүүсийн дэргэд ярих.

149.5. Албан баримт бичгийг хөтлөх, хадгалах талаар тогтоосон журмыг зөрчих зэрэг явдлууд нь албаны нууцыг задруулсанд шууд тооцно.

### **Гуравдугаар бүлэг**

#### **Томилгоот ээлжийн зохион байгуулалт**

150. Гал түймэр унтраах аврах анги, хэсгийн томилгоот ээлжийн үндсэн зорилго нь:

Объектын болон ой, хээрийн түймэр гарсан үед нэгдсэн зохион байгуулалтад орж богино хугацаанд хүрэлцэн очиж, гал түймрийг байгаа хэмжээнд нь хохирол багатай унтраах үүргийг гүйцэтгэх, түүнчлэн бие бүрэлдэхүүнийг сургаж дадлагажуулахад чиглэгдэнэ.

151. Нийслэл, аймгийн Онцгой байдлын газар, хэлтсийн харьяа гал түймэр унтраах аврах анги, хэсгүүд нь ажил үүргээ тасралтгүй гүйцэтгэхийн тулд томилгоот ээлжээр ажиллана.

152. Томилгоот ээлж гэдэг нь гал түймэр унтраах тусгай зориулалтын автомашин, техник зэвсэглэмжтэйгээр үүрэг гүйцэтгэх гал түймэр унтраах аврах ангийн салаа, тасгийг хэлнэ.

153. Томилгоот ээлжийг 24 цагийн хугацаагаар томилох бөгөөд 4 ээлжээр ажиллахаар зохион байгуулна. Томилгоот ээлжийг баяр ёслолын болон өдөр шөнийн ямар ч цагт тасралтгүй ажиллуулна.

154. Томилгоот ээлжийг дотор нь тасаг болгон хувааж болох бөгөөд тасгийн бүрэлдэхүүнийг гал түймэр унтраах аврах анги, хэсгийн эзэмшиж байгаа техник, зэвсэглэмжийн тоо, мөн хамгаалж буй объектын онцлогийг харгалзан зохион байгуулна.

155. Аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн харьяа гал түймэр унтраах аврах анги, хэсэг нь өөрсдийн хариуцсан нутаг дэвсгэр, үйлчлэх хүрээнд байгаа объект аж ахуйн нэгж, гэр хороололд гал түймэр гарахаас урьдчилан сэргийлж гарсан гал түймрийг богино хугацаанд унтраах бэлтгэл бэлэн байдлыг хангасан байна.

156. Томилгоот ээлж нь батлагдсан цагийн хуваарь, гал түймэр унтраах оноолт үүргийн дагуу ажиллах бөгөөд бие бүрэлдэхүүнээс үндсэн үүргээ үнэнч шударгаар гүйцэтгэж, чанд хатуу сахилга бат, өндөр сонор сэрэмжтэй байхыг шаардана.

#### **Томилгоот ээлжийн техник зэвсэглэмж**

157. Гал түймэр унтраах аврах анги, хэсгийн томилгоот ээлжийн хуваарьт гал унтраах, аврах хэрэгсэл бүхий тусгай зориулалтын автомашин техник, зэвсэглэмж байна.

158. Гал түймэр унтраах, аврах техник зэвсэглэмж, тоног төхөөрөмжийг үйл ажиллагаанд бэлэн байлгах нь томилгоот ээлжийн бие бүрэлдэхүүний үндсэн үүрэг мөн.

159. Эвдрэл гэмтлээр буюу эсвэл өөр ямар нэгэн шалтгаанаас гал түймэр унтраах томилгоот хуваариас гарсан автомашин, зэвсэглэмжүүдийг нэн даруй засварлан ажилд оруулна. Үүнд:

159.1. Хэрэв бэлтгэл автомашинтай бол гал түймэр унтраах аврах ангийн захирагч, хэсгийн даргын тушаалаар нэмэгдлээр, бэлтгэл машингүй бол тухайн хэлтэс, албаны даргын шийдвэрээр нөөц гал унтраах автомашиныг томилгоот хуваарьт оруулах ажлыг гүйцэтгэнэ.

159.2. Гал унтраах, аврах зэвсэглэмж, аврагч, гал сөнөөгчийн хувийн багаж хэрэгслийг томилгоот ээлжийн даргын шийдвэрээр сольж энэ тухай гал түймэр унтраах аврах ангийн захирагч, хэсгийн даргад илтгэнэ.

160. Гал түймэр унтраах аврах анги, хэсгийн зэрэглэл, орон тооны нормативыг Улсын стандартаар батлах бөгөөд гал түймэр унтраах аврах анги, хэсгийн цагийн хуваарь, томилгоот хуваарьт байгаа автомашин техник, зэвсэглэмжийг солихдоо зөвхөн Онцгой байдлын ерөнхий газрын даргын шийдвэрээр гүйцэтгэнэ.

161. Гал түймэр унтраах аврах анги, хэсэгт аврах болон галын техник зэвсэглэмжээс гадна байлдааны буу зэвсэг байж болно.

161.1. Байлдааны бууг ашиглах, эзэмших, хадгалах журмыг дагаж мөрдөж буй хууль тогтоомж, эрх зүйн актад нийцүүлэн аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга тогтоох бөгөөд тусгай бүртгэлийг хөтлөнө.

161.2. Сумнуудыг лац, ломбо, цоожтой хайрцагт хадгална

161.3. Лацны тэмдгийг гал түймэр унтраах аврах анги, хэсгийн болон салааны захирагчийн аль нэг нь хадгалах бөгөөд бууны бүрэн бүтэн байдалд хийх шалгалт, сумны хайрцагийг лацдахад дээрх дарга нар байлцаж хүлээлцэнэ.

#### **Томилгоот ээлжийг захирах**

162. Гал түймэр унтраах аврах анги, хэсгийн томилгоот ээлж нь гал түймэр унтраах аврах ангийн захирагч, Онцгой байдлын ерөнхий газар, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга, орлогч, хариуцлагатай жижүүр нарт шууд захирагдана.

#### **Томилгоот ээлжийг шалгах**

163. Онцгой байдлын ерөнхий газар, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсийн дарга, орлогч, хариуцлагатай жижүүр, ерөнхий эргүүл, гал түймэр унтраах аврах ангийн захирагч нар харьяа гал түймэр унтраах аврах анги, хэсгийн томилгоот ээлжийн бэлэн байдлыг түгшүүрийн дохиогоор

шалгана. Томилгоот ээлжийн салааны захирагч нь өөрийн хариуцсан салааны албан хаагч, автомашин техникийн бэлтгэл бэлэн байдлыг шалгана. Шалгалтаар:

163.1. Бие бүрэлдэхүүний өдөр тутмын баримт бичгийн хөтлөлт

163.2. Мэргэжлийн дасгал сургуулийн нормчлол

163.3. Гал унтраах автомашин, багаж хэрэгслийн бэлтгэл бэлэн байдал

Ой хээрийн түймэр болон ногоон бүсийн эргүүлийн үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай багаж хэрэгсэлийг байнгын бэлэн байдалд байлган өглөө бүр хүлээлцэж байх

#### **Томилгоот ээлжийг халалцах**

164. Томилгоот ээлжийг халалцахын өмнө хуваарын дагуу бие бүрэлдэхүүний ирцийг шалган, хүндэтгэн үзэх шалтгаантай буюу ирээгүй бие бүрэлдэхүүнийг бүртгэн авсаны дараа тогтоосон халалцах цагт томилгоот ээлжийн бие бүрэлдэхүүнийг хөдөлмөр хамгаалалын хувцас, хэрэгсэлтэйгээр жагсааж, хувийн бэлтгэлийг шалган томилгоот ээлжийн хуваарийг хийж тус бүрд нь зохих үүрэг тушаал өгнө.

165. Томилгоот ээлжийг халалцахад бэлэн болсон тухай бууж байгаа ээлжийн даргаас гарч байгаа томилгоот ээлжийн даргад мэдэгдэнэ.

166. Бууж байгаа томилгоот ээлжийн дарга нь томилгоот ээлж бэлэн болсон тухай мэдээг хүлээн авч "ээлж халалцаад" гэдэг командыг өгөх ба үүгээр гал түймэр унтраах аврах ангийн дуудлага хүлээн авагч хонхыг 3 удаа богиноор дуугаргана. Энэ дохиогоор бууж байгаа томилгоот ээлжийн бие бүрэлдэхүүн, гарч байгаа томилгоот ээлж бие бие рүүгээ харж жагсана.

166.1. Томилгоот ээлжийн салааны захирагч нар тус тусын салааг номхон команд өгч, бууж байгаа томилгоот ээлжийн даргаас ээлжийн хугацаанд хийсэн ажил, гаргасан шийдвэр, зарлалыг танилцуулсны дараа бууж байгаа томилгоот ээлжийн салааны захирагчаас ээлжүүд халалцахад бэлэн болсон тухай гал түймэр унтраах аврах ангийн захирагчид илтгэнэ.

166.2. Гал түймэр унтраах аврах ангийн захирагч илтгэлийг авч бүх бие бүрэлдэхүүнтэй мэндчилээд, томилгоот ээлжийн ажилд үнэлгээ дүгнэлт өгөн, үүрэг тавьж цаашид гүйцэтгэх ажлын чиглэлийг зааж өгнө.

167. Томилгоот ээлжийн нийт бие бүрэлдэхүүн, гал унтраах, аврах машин техник, зэвсэглэмж, анги, хэсгийн дотоод цэвэрлэгээ, холбооны хэрэгслийг биечлэн шалгаж хүлээлцэнэ.

168. Томилгоот ээлжинд гарч байгаа салаа ээлжийн захирагч ээлж халалцах үед дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

168.1. Автомашин, холбоо, дохионы хэрэгсэл, зэвсэглэмж, гал түймэр унтраах аврах анги, аврах отряд, хэсгийн эд хогшил, томилгоот ээлжийн орон байрыг шалган үзэх.

168.2. Бууж байгаа томилгоот ээлжийн салаа ээлжийн захирагчаас албан бичиг хэргүүдийг зохих жагсаалтын ёсоор биечлэн хүлээн авах.

168.3. Томилгоот ээлжийн салааны захирагч нар харуул ээлж хүлээлцэж байгаа байдалд биечлэн хяналт тавьж илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулах

169. Томилгоот салаа ээлжийн захирагч нар гал унтраах, аврах албаны техник, зэвсэглэмж, эд хогшлыг хүлээлцсэн тухай бие бүрэлдэхүүнээс асууж

танилцан илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах ба ноцтой зөрчлийн талаар томилолтод тэмдэглээд доорх арга хэмжээг зохион байгуулна. Үүнд:

169.1. Томилгоот ээлжийг хүлээж авсан захирагчийн тушаалаар дуудлага хүлээн авагч хонхыг 2 удаа богиноор дуугаргана.

169.2. Харуул ээлж хүлээлгэн өгсөн, хүлээн авсан салааны захирагч нар халалцсан тухай гал түймэр унтраах аврах ангийн захирагчид илтгэнэ.

170. Томилгоот ээлжийг халалцаж байгаа үед дохио өгөхөөс өмнө гал түймрийн дуудлага ирвэл бууж байгаа томилгоот ээлж гарч явах бөгөөд гарах томилгоот ээлж нь гал гарсан газар дээр юмуу эсвэл явсан томилгоот ээлжийг буцаж ирсэн үед халалцана.

171. Буух ээлж нь гал түймэр дээр ажиллаж байгаа бол ээлжийг гал түймэр гарсан газар дээр халалцуулж болно.

172. Ой, хээрийн түймрийн дуудлага ирвэл бэлтгэл ээлж болон, аврах бүлгийг гаргах бөгөөд хүн хүч дутагдсан үед аврах тусгай анги, гал түймэр унтраах аврах анги, хэсгээс нэмэгдэл хүн, хүч авна. Ой, хээрийн түймрийн дуудлагаар замд явж байгаа үед гал түймэр гараагүй буюу унтарсан гэсэн мэдээ хүлээн авсан тохиолдолд томилгоот бүлгийн бүрэлдэхүүн нь газар, хэлтсийн даргаас буцах шийдвэр өгөөгүй бол дуудлага өгсөн газар заавал хүрэлцэн очих ёстой.

#### **Томилгоот ээлжийн дотоод журам**

173. Гал түймэр унтраах аврах анги, хэсгийн байрны байрлал, багтаамжаас хамааран дараах журмаар жижүүрийг томилон ажиллуулна. Үүнд:

173.1. Гал түймэр унтраах аврах анги, хэсгийн гарааш, нүүрэн тал, хашааны үүдэнд.

173.2. Хянах өндөрлөгт.

173.3. Гал түймэр унтраах аврах анги, хэсгийн эргэн тойрон болон төв хаалга, ээлжийн байранд.

173.4. Гал түймэр унтраах аврах анги, хэсгийн дотоод дэг журмыг сахиулах.

174. Гэрээгээр хамгаалж байгаа объектоос гал түймэр унтраах аврах анги тусдаа байвал тавиуланд жижүүр томилон ажиллуулна.

175. Гал түймэр унтраах аврах анги, хэсгийн тавиулангийн жижүүрт зөвхөн жолооч нарыг томилон ажиллуулна. Гал түймэр унтраах аврах анги, хэсгийн тавиулангийн жижүүр дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

175.1. Гал түймэр гарсан мэдээллийг бие хүн ирж өгсөн тохиолдолд салааны захирагчид хэлж мэдээ өгсөн хүнийг захирагчтайгаа уулзуулах.

175.2. Гараашийн гарах хаалганы өмнө талбайд томилгоот ээлж гарч явахад саад учруулж болохуйцаар автомашин, бусад тээврийн хэрэгслийг түр боловч зогсоохгүй байх.

175.3. Гал түймэр унтраах аврах анги, хэсгийн байрнаас дарга нарын зөвшөөрөлгүйгээр эд аж ахуйн зүйл гадагш гаргахыг хориглох.

175.4. Гал түймэр унтраах аврах ангийн байранд гадны хүн оруулахгүй байх ба тэднийг оруулах тухай салааны захирагчид илтгэж шийдвэрлүүлэх.

176. Томилгоот ээлжийн гадна жижүүрийг салааны захирагч томилон ажиллуулна.

177. Гадна жижүүр дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

177.1. Томилгоот ээлжийг галд гарч явсны дараа Онцгой байдлын газар, хэлтэс, гал түймэр унтраах аврах ангийн захирагч болон шалгалтын хүмүүсээс бусад хэнийг ч албаны байранд оруулахгүй байх.

177.2. Томилгоот ээлжийг гал түймрээс буцаж ирэх хүртэл сонор сэрэмж, харуул хамгаалалтыг чанд сахих.

177.3. Томилгоот ээлжийг галд гарч явсан цагаас эхлэн машин техник, албаны байрны бүрэн бүтэн байдлыг хариуцах

178. Гал түймэр унтраах аврах анги, хэсгийн жижүүр нь дүрэмт хувцастай байх бөгөөд, гадна харуул өвлийн улиралд дах дэгтийтэй байж болно.

179. Томилгоот ээлжийн жижүүрийн томилолтыг 2 цагаас доошгүй хугацаагаар гүйцэтгүүлнэ. Өвлийн улиралд салааны захирагчийн шийдвэрээр жижүүрийн цагийг тогтооно.

### **Гал түймэр унтраах аврах анги, хэсгийн томилгоот хуваарь**

180. Гал унтраах тусгай болон туслах албаны автомашин бүрт томилгоот хуваарийг хийж танилцуулна.

181. Томилгоот хуваарьт зохих мэргэжлийн шатны сургалтад хамрагдаагүй, гал унтраах, аврах багаж зэвсэглэмж, хорт утаанаас хамгаалах баг, техникийн үйл ажиллагааны онцлог, аюулгүй ажиллагааны дүрмийг судлаагүй, жолооч, гал сөнөөгч нарыг оруулж үл болно.

182. Жолооч, гал сөнөөгчдийг томилгоот хуваарийн дагуу онолт номеруудад томилохыг салааны захирагч хариуцах бөгөөд бүрэлдэхүүний албаны мэдлэг, ур чадвар, дадлага туршлагын байдлыг харгалзан томилолтын хуваарийг хийнэ.

183. Томилолтын хуваарьт орсон бие бүрэлдэхүүн онолт номерын хувийн зэвсэглэмжийг иж бүрэн хүлээн авсан байх ёстой.

### **Албаны байрны дотоод дэг журам**

184. Томилгоот ээлжинд томилогдсон бие бүрэлдэхүүн нь гал түймэр унтраах аврах анги, хэсгийн дарга, салааны захирагчийн зөвшөөрөлгүйгээр үүрэг гүйцэтгэж байгаа байрыг дур мэдэн орхин явахыг хориглоно.

185. Томилгоот ээлжийн бие бүрэлдэхүүнийг гал түймэр унтраах аврах анги, хэсгийн цагийн хуваарийн дагуу шөнийн цагт /унтаж/ амрахыг зөвшөөрнө.

186. Салааны захирагч нь шөнийн цагт дуудлага хүлээн авагчтай ээлжлэн 3 цагаас илүүгүй хугацаагаар амарч /унтаж/ болно.

187. Томилгоот ээлжийн байр буюу сургалт хүмүүжлийн ажил зохион явуулдаг байранд цагийн хуваарийг баримтлан ном, сонин унших, шатар, даам, шагай тоглохыг зөвшөөрнө.

188. Анги, хэсгийн байранд, гадна орчинд зөвшөөрөгдсөн цэгээс бусад газар тамхи татахыг хориглоно.

189. Томилгоот ээлжинд байгаа нийт бие бүрэлдэхүүн дүрэмт хувцастай байх бөгөөд байрандаа малгай, гадуур хувцасаа тайлсан байна. Харин салааны захирагч, дотоод томилолттой жижүүрүүд бүгд малгайтай байна.

190. Томилгоот ээлжийн байрыг цэвэр байлган, ангийн нүүр талын буюу харуулын хаалганаас бусад хаалгыг түгжээтэй байлгана.

### **Албаны байранд хүмүүсийг нэвтрүүлэх**



191. Томилгоот ээлжийн байранд ээлжийн ажиллагааг шалгахар, бие бүрэлдэхүүн болон удирдах дарга нартай албан хэргээр уулзахаар ирэгсдийг тус тус нэвтэрүүлнэ.

192. Томилгоот ээлжийг шалгахар ирсэн албан хаагчийг харуул болон салааны захирагч нүүр царайгаар танихгүй бол үнэмлэх бичиг баримтыг шалгасны дараа оруулна. Хэрэв шалгагч хүн цэргийн цолтой бол түүний цолоор, цолгүй бол түүний албан тушаалыг дурьдаж илтгэнэ.

### **Дөрөвдүгээр бүлэг**

#### **Томилгоот ээлжинд гарч байгаа албан хаагчдын нийтлэг үүрэг**

193. Томилгоот ээлжийн үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдын нийтлэг үүрэг:

193.1. Томилгоот хуваарийн дагуу оноолт номерын үүргийг бүрэн ойлгож, ноогдсон үүргийн дагуу ажиллаж чаддаг байхын зэрэгцээ ээлжинд гарахдаа тухайн үед гүйцэтгэх өөрийн үүргийг сайн мэдэх.

193.2. Өөрийн хүлээж авсан оноолт техник хэрэгсэл, хувийн зэвсэглэмжийг ямагт бэлэн байдалд байлгах.

193.3. Томилгоот ээлжинд гарах үедээ хүлээн авсан гал түймэр унтраах ажиллагааны техник, хэрэгслүүдийг ашиглаж чаддаг байх.

193.4. Холбооны болон телефон хэрэгслүүдээр ажиллах журмыг мэдэх.

193.5. Гал түймэр унтраах ажиллагаанд хэрэглэж болохуйц нуур, гол, горхи, худаг, гидрантууд, хамгаалж байгаа объект газрынхаа орох, гарах зам гарц, гүүр, орчны байдлыг судалж мэдсэн байх.

193.6. Гал түймрийн дуудлагаар гарахдаа сандарч тэвдэн хугацаа алдахгүйгээр богино хугацаанд /хөдөлмөр хамгаалалын хувцас, хэрэгслийг өмсөн/ автомашинд тогтоосон дарааллын дагуу байрлалаа эзэлсэн байх.

194. Өмнөх 193 дугаар зүйлд заасан үүрэгнээс гадна гэрээгээр хамгаалж байгаа гал түймэр унтраах аврах анги, хэсэг нь дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

194.1. Хамгаалж байгаа объектыг гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч галын аюулгүй байдлыг хангах.

194.2. Гал түймэр гарсан тохиолдолд мэдээ, дохио өгөх, холбооны хэрэгслүүдийг ашиглаж чаддаг байх.

194.3. Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн байрлалыг мэддэг байхын зэрэгцээ түүнийг ашиглаж ажиллуулж чаддаг байх.

#### **Гал унтраах автомашины жолоочийн үүрэг**

195. Гал унтраах автомашины жолооч нар нь томилгоот ээлжийн бүрэлдэхүүнд орж өөрийн салаа болон гал түймэр унтраах аврах ангийн захирагчид шууд захирагдан дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

195.1. Гал түймрийн дуудлагаар гарахдаа хариуцсан нутаг дэвсгэр дээр байгаа объект, барилга байгууламж, үйлдвэр, аж ахуйн нэгж, гэр хороололд богино хугацаанд хүрэлцэн очих, буцах зам гарц, гал унтраах усан хангамжийн байрлалыг судалж мэдсэн байх.

195.2. Гал унтраах зориулалтын автомашины бүтэц зохион байгуулалт, түүнд тоноглогдсон бүх механизм, агрегат /хөөрөг, мотопомп/ багаж зэвсэглэмжийг ажиллуулж чаддаг байх.

195.3. Замын хөдөлгөөний дүрмийг сайтар судалж хэрэгжүүлэн ажиллаж чаддаг байх.

195.4. Худаг, усан сан дээр гал унтраах зориулалтын автомашиныг байрлуулах зарчмыг мэддэг байх.

195.5. Томилгоот хуваарийн дагуу өөрт оногдсон үүргийг бүрэн биелүүлж чаддаг байх.

195.6. Автомашин, мотопомпыг ажилд байнга бэлэн байлгаж илэрсэн гэмтлүүдийг нэн даруй даргадаа илтгэн засч чаддаг байх.

195.7. Түгшүүрийн дохиогоор автомашиныг үүрэг гүйцэтгэхэд бэлэн болгож, өгөгдсөн тушаалыг биелүүлэх.

195.8. Объект, ой, хээрийн гал түймэр болон дадлага сургуулилтаас цуваагаар буцах бөгөөд автомашины ус, хөөсийг шалгаж, бэлэн байдалд оруулан шадар даргадаа илтгэх.

195.9. Объектын болон ой, хээрийн гал түймрийн дадлага сургуулилын үед өөрийн хариуцсан автомашинаас холдохгүй байж түүний механизм, агрегатуудын найдвартай ажиллагааг хангасан байх.

195.10. Шатах тослох материалыг арвилан хэмнэх зорилгоор сургууль бусад ажиллагааны дундах чөлөөт цагуудаар автомашины хөдөлгүүрийг унтрааж болох эсэхийг тасгийн буюу томилгоот ээлжийн даргад илтгэсний дараа гүйцэтгэх.

196. Томилгоот ээлжийн жолооч нар ээлжинд гарахдаа дараах зүйлийг нэг бүрчлэн шалгаж үзэх үүрэгтэй. Үүнд:

196.1. Хөдөлгүүрийн ажиллагаа.

196.2. Түлшний савны шатахуун, тэжээлийн системийн ажиллагаа, шатахуун болон усны хоолойнуудын холболт

196.3. Хөдөлгүүрийн тосны хэмжээ.

196.4. Зай хураагуурын шингэний хэмжээ.

196.5. Радиатор, анхны тусламжийн бак, цистернууд дэх усны хэмжээ.

196.6. Вентиляторын рамны чанга сул.

196.7. Шалгах, хэмжих хэрэгслийн ажиллагаа.

196.8. Цахилгаан хэрэгслийн байдал.

196.9. Автомашины бүх анги, хэсгүүдийг гадна талаас нь шалган үзэх ба илэрсэн дутагдуудыг арилгуулах.

196.10. Резин дугуйнуудын байдлыг гадна талаас нь шалгах.

196.11. Рулийн ажиллагаа, тормоз ба арааг залгаж салган шалгах.

196.12. Автомашины марк, агрегатад үйлдвэрлэлээс тохируулж гаргасан түлхүүр багаж хэрэгсэл бүртгэлийн дагуу байгаа эсэх.

196.13. Хуваарьт багаж хэрэгслээс гадна очлуур, комплектор 1-2 ширхэг, конденсатор, гэрлийн шил, 1 кг товуд, нэмэлт багаж хэрэгсэл, запас дугуй байгаа эсэхийг шалгаж авах.

### **Дуудлага хүлээн авагчийн үүрэг**

197. Дуудлага хүлээн авагч нь салааны захирагчид шууд захирагдаж дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

197.1. Томилгоот ээлжинд гарахдаа хүлээн авсан бүх холбоо харилцаа, дохио мэдээллийн хэрэгслүүдийг ажиллуулж чаддаг байх.

197.2. Төв суурин газар байгаа бүх гал түймэр унтраах аврах анги, хэсэгтэй харилцах холбооны ерөнхий журам, түүнчлэн өөрийн анги, хэсгийн хамгаалж байгаа объект болон ой хээрт гарсан гал түймэрт очих нэмэгдэл дуудлагаар дуудагдах бусад анги, хэсгийн телефон утасны дугаарыг цээжээр мэддэг байх.

197.3. Өөрийн анги, хэсгийн үйлчлэх хүрээний объект, хороололд нэмэгдэл дуудлагаар гарч ажиллах журмыг мэддэг байх.

197.4. Үүрэг гүйцэтгэж байгаа үед жижүүрийн байрнаас зөвшөөрөлгүй гарч явахгүй байхын зэрэгцээ гал түймрийн дуудлагын мэдээг түргэн шуурхай хүлээн авч бие бүрэлдэхүүнд нэн даруй мэдэгдэж шаардлагатай хүч хэрэгслийг гаргах.

197.5. Дуудлага хүлээн авагч түр зуур гарах шаардлага тохиолдвол салааны захирагчийн зөвшөөрлөөр холбооны хэрэгслүүдийг мэддэг бөгөөд ажиллуулж чаддаг хүнээр орлуулах.

197.6. Албан үүргээ гүйцэтгэх явцдаа ажлын байраа эзэнгүй орхих, албаны бус яриаг утсаар ярихгүй байх, холбооны өрөөнд томилгоот ээлжийн дарга, ажил хариуцдаг албан тушаалтнаас бусад хүмүүсийг оруулахыг хориглоно.

197.7. Томилгоот ээлжийг хүлээн авахдаа дуудлага хүлээн авагчийн үүрэг заавар, бусад бичиг баримтуудыг жагсаалтын дагуу хүлээн авахын зэрэгцээ холбооны бусад хэрэгслүүдийг шалгаж үзэх, өрөө байрны доторхи бүх эд хогшлыг хүлээн авч томилгоот ээлжийн даргад дээрх зүйлүүдийг хүлээн авсан тухай болон илэрсэн зөрчил дутагдлын талаар илтгэх.

197.8. Дуудлага хүлээн авагч нь телефон утсыг тогтмол шалгаж байхын зэрэгцээ аймаг нийслэлийн Онцгой байдлын газар, Онцгой байдлын ерөнхий газрын Шуурхай удирдлагын төвтэй тогтоосон цагийн хувиарийн дагуу холбоо барьж тэмдэглэл хөтлөн тайванаа илтгэж байх.

198. Гал түймэр гарсан тухай мэдээг хүлээн авмагц дуудлага хүлээн авагч дараах үүргийг гүйцэтгэнэ. Тухайн орон нутгийн Цагдаагийн газар, хэлтсийн шуурхай жижүүрт гал түймэр гарсан тухай мэдэгдэх Үүнд:

198.1. Телефон утсаар гал түймэр гарсан тухай мэдээ авмагц яриагаа таслахгүйгээр түгшүүрийн дохиог өгч, түүний дараагаар гал түймэр гарсан газрын хаяг, мэдээ өгсөн хүний нэрийг магадлаж, хэрэв бололцоо байвал гарсан гал түймрийн нөхцөл байдлыг лавлаж асуугаад гал түймрийн дуудлагын хуудсыг бичиж томилгоот ээлжийн даргад өгч, гарсан гал түймрийн нөхцөл байдлын тухай мэдээ авч чадсан бол тэр тухай мөн мэдэгдэх.

198.2. Өөрийн гал түймэр унтраах аврах ангийн үйлчлэх хүрээний бус газруудад гал түймэр гарсан тухай мэдээ хүлээн авбал түүнийгээ тухайн гал түймэр дээр очиж ажиллах үүрэг бүхий гал түймэр унтраах аврах анги, салбарт нэн даруй мэдэгдэх. Үйлчлэх хүрээг км, баг, дүүрэг, сумаар нь зааглах

198.3. Томилгоот ээлж гал түймрийг унтраахаар гарч явахад тухайн газрын гал унтраах шуурхай төлөвлөгөө хийгдсэн бол томилгоот ээлжийн даргад дуудлагын хуудсыг, шуурхай төлөвлөгөөний хамт өгөх.

198.4. Гал түймэр гарсан газраас гал түймэр унтраах удирдагч буюу түүний тушаалаар холбоогоор дамжуулан нэмэгдэл дуудлага өгвөл нэмэгдэл дуудлагаар очих гал түймэр унтраах аврах анги, хэсэгт гал гарсан газрын хаягийг дахин мэдэгдэх.

198.5. Томилгоот ээлжийн гарч явсан цаг, мэдээ өгсөн хүний нэр, бусад гал түймэр унтраах аврах ангиудыг нэмэгдэл дуудлагаар дуудсан цаг хугацаа, нэвтрүүлсэн ярианы хамт очсон, ирсэн цагтай нь тэмдэглэл хөтөлсөн байх.

198.6. Томилгоот ээлж, гал түймрийн дуудлагаар гарч явсан, буцаж ирсэн тухай дуудлага хүлээн авагчийн зааварт дурьдсан нэр бүхий албан тушаалтнуудад мэдэгдэх.

198.7. Томилгоот ээлжинд галд гарч явсан тухай болон гал түймэр дээр ажиллаж байгаа байдлын талаар мэдээлэл дамжуулах журмын дагуу холбогдох албан тушаалтнуудад мэдэгдэх.

### **Тавдугаар бүлэг**

#### **Томилгоот ээлжийн өдөр тутмын цагийн хуваарь**

199. Томилгоот ээлжийн цагийн хуваарьт нийт бие бүрэлдэхүүнд сургалт хүмүүжлийн болон мэргэжлийн сургалт, дадлагыг зохион байгуулах, хариуцсан техник зэвсэгт үйлчилгээ хийх, бэлэн байдлыг хангах, хооллох, амрах цагийг хамруулсан байвал зохино.

200. Томилгоот ээлжийн өдөр тутмын цагийн хуваарийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга батална.

201. Гал түймэр унтраах аврах анги, хэсгийн бие бүрэлдэхүүн өдөр тутамын болон дадлага сургуулилтыг явуулахдаа томилгоот ээлжийг бүрэн хүлээн авч бэлтгэл бэлэн байдлыг хангасны дараа явуулна.

202. Томилгоот ээлжийн бие бүрэлдэхүүнд заах хичээлүүдийг 6 цагаас хэтрүүлэхгүйгээр өдөр тутмын цагийн хуваарьт оруулна.

203. Гал унтраах тактикийн бэлтгэл сургуулийг анги, хэсгийн томилгоот хуваарьт байгаа гал унтраах тусгай зориулалтын автомашин техник, багаж зэвсэглэмжийг ашиглан хийх боловч гал түймрийн аюул гарсан үед томилгоот ээлж шуурхай дуудлагаар гарч явахад саад болохооргүйгээр зохицуулан зохион байгуулна.

204. Томилгоот ээлжийн үүргийг гүйцэтгэх явцдаа мэргэжлийн хичээлийн хөтөлбөрөөс гадуур гал унтраах тактикийн болон тархалтын сургуулийг хийх, шүхрийн дадлага, бие бялдрын бэлтгэл бэлэн байдал хангуулах, гал унтраах шуурхай төлөвлөгөө, карт боловсруулах, бие бүрэлдэхүүний гүйцэтгэх үүргүүдийг судлуулах, хариуцсан объектын галын аюулгүй байдлыг хангуулах зэрэг дадлагын хичээлүүдийг бэлтгэл бэлэн байдлаа алдахгүйгээр зохион байгуулж болно.

205. Томилгоот ээлжийн бие бүрэлдэхүүнтэй хөтөлбөрөөс гадна хичээллэх дадлага сургуулилтыг томилгоот ээлжийн дарга нараас өдрийн цагийн хуваарьтай зохицуулан явуулна.

206. Гал түймэр унтраах тусгай зориулалтын автомашин техник, багаж зэвсэглэмж, шүхэрт үйлчилгээ, цэвэрлэгээг болон ажлын байрыг дараагийн ээлжинд хүлээлгэн өгөхөд бэлтгэх ажлыг цагийн хуваарийн дагуу ээлжийн бие бүрэлдэхүүнээр гүйцэтгүүлнэ.

207. Гал унтраах тусгай зориулалтын автомашин техникт хийх засвар үйлчилгээг томилгоот хуваарьт болон бэлтгэлд байгаа машин техникийн байдлыг харгалзан анги, хэсгийн дарга / захирагч/-аас тогтооно.

Томилгоот ээлж гал түймрийн дуудлагаас буцаж ирсний дараа цэвэрлэгээг захирагчаас өгсөн үүргийн дагуу гүйцэтгэнэ.

208. Аж ахуйн ажлууд /өрөө тасалгаанд болон гал түймэр унтраах аврах анги, хэсгийн орчинд их цэвэрлэгээ хийх бусад аж ахуйн ажил/-ыг цагийн хуваарийн дагуу томилгоот ээлжийн захирагчийн зөвшөөрлөөр хийнэ. Томилгоот ээлжийн бие бүрэлдэхүүнийг ангийн байрнаас гадуур аж ахуйн ажил хийлгэхийг хориглоно.

**Зургаадугаар бүлэг**  
**Томилгоот ээлжинд зохиогдох**  
**дадлага сургалтын ажил**

209. Томилгоот ээлжинд зохиогдох дадлага сургалтын ажил нь бие бүрэлдэхүүнд хууль тогтоомж, төр засгийн бодлого шийдвэрийг хүргэх, хэрэгжүүлэх арга замыг зааж сургах, өргөсөн тангарагтаа үнэнч байх, албаны мэдлэг ур чадвараа сайжруулах, нарийн чанд сахилга бат, өндөр сонор сэрэмжтэй байж гал унтраах бэлтгэл бэлэн байдлыг найдвартай хангах, албандаа дур сонирхолтой болгох, алба, мэргэжлээрээ бахархах үзэл төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.

210. Томилгоот ээлжийн хугацаанд зохион явуулах дадлага сургалтын ажлыг гал түймэр унтраах аврах ангийн салааны захирагч, Сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн нар удирдан ангийн цагийн хуваарийн дагуу зохион байгуулна.

211. Томилгоот ээлж дээр зохион байгуулах дадлага сургалтын ажлыг Онцгой байдлын ерөнхий газар, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтсээс дэвшүүлсэн зорилт, гаргасан тушаал шийдвэрийг бие бүрэлдэхүүнд нэг бүрчлэн хүргэж ойлгуулахад чиглүүлнэ.

212. Гал түймэр унтраах аврах ангийн байранд үүрэг гүйцэтгэж буй томилгоот ээлжийг шуурхай дуудлагын дохиогоор гарч явахад саад болохуйц ажлуудыг зохион байгуулахыг хориглоно.

**Долоодугаар бүлэг**  
**Салааны захирагчийн нэмэгдэл үүрэг**

213. Салааны захирагч дараах нэмэгдэл үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

213.1. Гал түймэр унтраах удирдагч, шуурхай штабт ямар аргаар гал түймрийн тухай мэдээлэх.

213.2. Утас, цахилгаан, автомашин, холбооны хэрэгсэл гэмтэж эвдэрсэн тохиолдолд засах арга хэмжээ авахуулах.

213.3. Гал түймрийн дуудлагаар хүн хүч, техник хэрэгслийг бүрэн гаргах.

213.4. Нэмэгдэл хүчээр гарсан гал түймэр унтраах аврах анги, хэсэгтэй харилцан ажиллах.

213.5. Гал түймэр дээр мэргэжлийн албадтай хамтарч ажиллах журмыг мэддэг байх.

214. Салааны захирагчийн ажил үүргийн хуваарийг гал түймэр унтраах аврах анги, хэсгийн дарга /захирагч/ батлана. Ажил үүргийн нэмэгдэл хуваарьт дараах зүйлүүдийг тусгасан байна. Үүнд:

214.1. Томилгоот ээлж гал түймрийн дуудлагаар гарч явсан тухай хэнд ямар ээлж дарааллаар мэдэгдвэл зохих.

214.2. Аймаг, төв суурин доторхи хуваарьт газруудад гал түймэр гарсан тухай мэдээг хүлээн авмагц аврах, гал түймэр унтраах аврах ямар анги, хэсгийг дуудах ба хэнд мэдэгдэх.

214.3. Гал түймрийн дуудлагын дэс дараалал, харилцах ажиллагааны тухай тусгай үүргүүдийг мэдэх.

214.4. Албаны гүйцэтгэх үүргийн тухай нэмэгдэл үүргүүд ба холбоо дохионы ажиллагааны онцлогуудыг мэддэг байх.

#### **Галын түймрийн дуудлагын хуудас**

215. Гал түймрийн дуудлагын хуудас /5-р хавсралт/-ыг дуудлага хүлээн авагч хүлээн авах бөгөөд дуудлага гарсан тухай мэдээг хүлээн авмагц гал түймэр унтраах аврах анги, хэсгийн томилгоот хуваарьт байгаа бие бүрэлдэхүүнийг гарч ажиллуулах хуудсыг бичиж өгнө.

#### **Томилгоот ээлжийн цагийн хуваарь**

216. Томилгоот ээлжийн дотоод журам, цагийн хуваарийг ээлжийн даргын өрөөнд байрлуулна.

#### **Үйлчлэх хүрээний усан хангамж, гал унтраах гадна, дотор усны даралтат цэгийн тодорхойлолт жагсаалт**

217. Гал түймрийг унтраахад ашиглах худаг, усны нөөц гал унтраах гадна усны даралтат цэг, зам гарцын судалгааг томилгоот ээлж бүр хийж автомашинд байрлуулах бөгөөд улирал бүр заавал тодотгол хийсэн байна. Дээрхи судалгаа нь салааны захирагчид дэлгэмэл хэлбэрээр байх бөгөөд ээлж халалцах үед хүлээлцэж байна.

#### **Үйлчлэх хүрээний төв суурин газрын ерөнхий төлөвлөлтийн зураг**

218. Гал түймэр унтраах аврах анги, хэсгийн үйлчлэх хүрээнд хамрагдах нутаг дэвсгэр, объект, гэр хороололыг хэсэгчлэн хуваарилсан схем зураг гал түймэр унтраах аврах анги, хэсгүүдэд байх ёстой бөгөөд тэр схем зургийг дуудлага хүлээн, авагчийн өрөөнд байрлуулна.

219. Гал түймэртэй тэмцэх гэрээт ангийн хамгаалалтад байгаа объектын ерөнхий схем зураг мөн дуудлага хүлээн авагчийн өрөөнд байвал зохино.

#### **Гал унтраах багаж, зэвсэглэмжийн бүртгэл**

220. Гал унтраах тусгай зориулалтын автомашинд байгаа багаж зэвсэглэмжийн бүртгэлийг автомашин нэг бүр дээр мөн шүхэр, РЛО, цуравдагч, үлээгч аппарат, бүрийг паспортжуулан салааны захирагч, аж ахуйн нярав, техник зэвсэглэмж хариуцсан инженер нар гардан хариуцаж байх бөгөөд ээлж халалцах үед багаж зэвсэглэмжийн иж бүрдэл, бүрэн бүтэн байдлыг шалгаж хүлээлцэнэ. Гал түймэр, дадлага сургуулилтаас буцаж ирсэн үед бүх багаж зэвсэглэмжийг бүртгэн үзэж томиллолтод тэмдэглэнэ.

#### **Гал унтраах усан хангамжийг шалгах**

221. Гал унтраах усан хангамжийг /худаг, гал унтраах гадна, дотор усны даралтат цэг бусад төрлийн усны нөөц/ ангийн томилгоот ээлжээс тогтмол шалгах бөгөөд шалгасан дүнгийн талаар тэмдэглэл хөтөлнө. Томилгоот ээлжинд гарсан салааны захирагч ээлж халалцах үедээ тэмдэглэлийг дараагийн ээлжинд хүлээлгэн өгнө.

222. Онцгой байдлын байгууллагад хэрэглэгдэх нэр томъёо, тодорхойлолт

Оноолт номер	гал түймэр унтраах үндсэн албаны автомашинд тодорхой үүрэг хүлээсэн бие бүрэлдэхүүн
Гал түймэр унтраах	Гал түймрийн үед хүний амь насыг аврах, гал

	түймрийг унтраахын тулд тодорхой хүн хүч, техник хэрэгслээр тохирсон арга, хэлбэрийг ашиглан гүйцэтгэх үйл ажиллагаа
Гал унтраах тасаг	үндсэн, тусгай, туслах автомашинд үүрэг гүйцэтгэх боломжит бүрэлдэхүүн
Гал түймэр унтраах үеийн гал унтраах үйл ажиллагааны хэсэг	хамтын удирдлагад орж тодорхой хэсэгт, нэгдсэн үүрэг, зорилготойгоор хүн хүч, техник хэрэгслийг төвлөрүүлсэн хэсэг
Гал түймэр унтраах тархалт	гал түймрийн үед гал унтраах үйл ажиллагааны үүрэг гүйцэтгэхээр хүн хүч, техник хэрэгслийг бэлэн байдалд оруулсан байдал
Гал түймрийн тархан дэлгэрэлтийг зогсоох	гал түймрийг бүрэн унтраах нөхцлийг бүрдүүлж тархан дэлгэрэлтийг цаашид зогсооход чиглэсэн үйл ажиллагаа
Гал түймрийг бүрэн гүйцэд унтраах	гал түймэр дахин асах нөхцлийг болон шатлагыг бүрэн гүйцэд таслан зогсооход чиглэсэн үйл ажиллагаа
Гал түймэр унтраах нэмэлт дуудлага	урьдчилан боловсруулсан төлөвлөгөө болон дуудлагын журмын дагуу дэс дарааллаар гал түймэр унтраах аврах ангиудыг гаргах хуваарь
Гал түймэр унтраах үйл ажиллагааны техник зэвсэглэмж	гал унтраах тусгай зориулалтын автомашинд төхөөрмжлөгдсөн тодорхой үүрэг гүйцэтгэх чиглэлтэй гар буюу механикжсан багаж, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, аврах төхөөрөмж, гал түймэр унтраах зориулалтын багаж зэвсэглэмжийн иж бүрдэл
Гал түймэр унтраах зориулалтын усан хангамж	гал унтраах гадна, дотно усан хангамж, нөөц ус хадгалж ашиглахаар хийсэн инженер техникийн байгууламж, ус соруулж болохуйц гол, горхи, нуур цөөрөм
Галын мэдээлэл	гал түймрийн үед олон нийтэд зарлан мэдээлэх төхөөрөмж
Галын тархалт, дэлгэрэлт	орон зай, цаг хугацаагаар гал түймрийн параметрийн өөрчлөлт
Гал түймэр унтраах аврах анги, хэсгийн үйлчлэх хүрээ	дуудлагаар ажиллах гал түймэр унтраах аврах анги, хэсгийн нутаг дэвгэр
Гал түймэр унтраах дуудлагаар гарах дараалал	гал түймрийг унтраахын тулд нэмэлт хүн хүч, техник хэрэгслийг дуудах журмыг тодорхойлсон баримт бичиг.
Гал түймэр унтраах үйл ажиллагаанд оролцож буй хүн хүч, хэрэгсэл	гал түймрийг унтраахад шаардагдах гал унтраах техник, бодис болон гал түймэр унтраах аврах анги, хэсгийн бие бүрэлдэхүүн, дайчлагдсан ба сайн дураар тусалж буй иргэд
Гал түймрээс хүмүүсийг аврах	гал түймрийн аюултай бүсээс өөрөө бие даан гарч чадахгүй байгаа хүмүүсийг тухайн голомтоо с гаргах үйл ажиллагаа
Гал түймэр унтраах аврах ангийн тактикийн өгөгдөхүүн	тодорхой нэгж хугацаанд өөрсдийн техник хэрэгслийг ашиглан гал түймэр унтраах үйл ажиллагааны үүрэг даалгаврыг үр дүнтэйгээр гүйцэтгэх бие бүрэлдэхүүний чадвар
Гал түймэр унтраах үйл	гал түймрийн үед хүн хүч, хэрэгслийг нэгтгэн

ажиллагааны ар тал	төвлөрүүлж гал унтраах үйл ажиллагааны ар талын албыг зохион байгуулж найдвартай ажиллагааг хангах хэсэг
Гал түймэр унтраах хүн хүч, хэрэгслийг удирдах	гал түймрийн нөхцөл байдлыг судалсны үндсэн дээр гал унтраах үйл ажиллагааг амжилттай зохион байгуулах зорилготой хийгддэг /гал түймэр унтраах шуурхай штаб/ гал түймэр унтраах удирдагчийн үйл ажиллагаа
Гал түймэр унтраах шуурхай штаб	гал түймрийн үед хүн хүч, техник хэрэгсэл болон гал унтраах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах төв
Гал түймрийн нөхцөл байдал	гал түймрийн үеийн хайгуулын үр дүнд тогтоосон бодит байдал
Гал унтраах бодис	шатлагыг зогсоох нөхцлийг бүрдүүлэх чадвар бүхий физик-химийн шинж чанарыг агуулсан бодис
Гал түймэр	Гал хараа хяналтаас гарч, хүний амь нас, эрүүл мэнд, хувь хүн, хуулийн этгээдийн эд хөрөнгө, байгаль орчин, нийгэмд хохирол учруулахыг
Гал түймэр унтраах аврах анги, хэсэг	Гал түймэр унтраах аврах анги улсын хэмжээнд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмч хөрөнгийг гал түймрийн аюулаас авран хамгаалах, гал түймэр унтраах үйл ажиллагааг зохион байгуулах нэгдсэн удирдлагатай онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын үндсэн нэгж
Хушуучны байрлал	Гал түймэр унтраах үйл ажиллагааны үүрэг гүйцэтгэх үеийн хушуучны байрласан газар
Хүн хүч, хэрэгслийг татан оролцуулах төлөвлөгөө	Төв суурин газарт гарсан галыг унтраахын тулд татан оролцуулах хүн хүч, хэрэгслийн тоо, дэс дарааллыг тодорхойлсон баримт бичиг
Гал унтраах төлөвлөгөө	Улсын онц чухал болон галын аюултай объектод гарсан галыг унтраах зохион байгуулалтын асуудлыг боловсруулж гарын авлага болгон ашиглахад зориулсан баримт бичиг
Гал унтраах техник	Гал түймрийн аюулаас хүний амь нас болон эд хөрөнгө, үнэт материалыг аврах, гал түймрийн тархан дэлгэрэлтийг зогсоож, бүрэн унтраах тусгай зориулалтын автомашин техник, хэрэгсэл
Ой, хээрийн түймрийн цурам	Ой, хээрийн түймрийн тархалтыг хязгаарласан боловч галын голомтод шатлага үргэлжлэн явагдаж байгааг хэлнэ.
Ой, хээрийн түймрийн цурав	Ой, хээрийн түймрийн тархалтыг эсрэг байгалийн саадыг ашиглан зориуд угтуулж тавьсан шатлагыг хэлнэ.
Ой, хээрийн түймрийг бүрэн унтраах	Ой, хээрийн түймрийн эх үүсвэрийг дахин асахааргүйгээр таслан зогсоосон үйл ажиллагааг хэлнэ



Монгол Улсын Шадар сайдын 20/6-оны 5.  
дугаар сарын 18-ны өдрийн  
53. дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

ХҮН ХҮЧ, ХЭРЭГСЛИЙН ТООЦОО

Д/д	Гал түймэр унтраах аврах анги хэсэг	Ирсэн цаг минут	Гал түймэр унтраах, аврах үйл ажиллагааны оноолт номерын тоо	Гал түймэр унтраах, аврах үйл ажиллагааны үүрэг авсан цаг минут	Гал түймэр унтраах, аврах үйл ажиллагааны хэсгийн дугаар	Гүйцэтгэсэн ажил ба биелүүлсэн цаг минут	Гал түймэр унтраах, аврах үйл ажиллагаанаас буцсан цаг минут
А	Б	1	2	3	4	5	6

ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ УДИРДАГЧ \_\_\_\_\_

ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ АВРАХ АНГИ, ХЭСГИЙН ДАРГА  
/ЗАХИРАГЧ / \_\_\_\_\_

Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 5  
дугаар сарын 18-ны өдрийн  
53 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

МЭДЭЭЛЭЛ БОЛОН ЗАХИРАМЖИИН ТООЦОО

Д/д	Цаг минут	Юу дамжуулсан	Хэнд дамжуулсан	Хэнээс дамжуулсан	Хэн хүлээн авсан
А	1	2	3	4	5

ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ АВРАХ АНГИЙН

САЛААНЫ ЗАХИРАГЧ \_\_\_\_\_

ДУУДЛАГА

ХҮЛЭЭН АВАГЧ \_\_\_\_\_

Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 5  
дугаар сарын 18-ны өдрийн  
53 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

### ХАНЦУЙН ТАНИХ ТЭМДГИЙН ТОДОРХОЙЛОЛТ.

Гал түймэр унтраах удирдагч /ГТУУ/, штабын дарга /ШД /, арын албаны дарга /ААД/, гал түймэр унтраах хэсгийн дарга /ГТУХД/, авран хамгаалах хэсгийн дарга /АХХД/ болон холбоочин /Х/-гийн ханцуйн таних тэмдэг.

Ханцуйн таних тэмдэг нь улаан даавуун дээр цагаан өнгөөр ГТУУ, ШД, ГУХД, АХХД гэсэн товчилсон үсгүүдийг бичсэн байна.

Харин ААД, Х гэсэн товчилсон үсгийг цагаан даавуун дээр хараар бичнэ.

Товчилсон үсгийн өргөн нь 40 мм, өндөр нь 60 мм, бичээсийн мөрний өргөн нь 10 мм-ээр бичнэ.

300-400мм



Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 5  
дугаар сарын 18 ны өдрийн  
53 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт

ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ АВРАХ АНГИУДЫН ГАЛ ТҮЙМРИЙН ДУУДЛАГААР  
ГАРАХ ДАРААЛАЛ, ХҮЧ НЭМЭГДҮҮЛЭН АЖИЛЛАХ ҮЛГЭРЧЛЭЛ

Д/Д	Үйлчлэх хот дүүрэг	Анхны дуудлагаар гарах гал түймэр унтраах аврах анги №1	Хүч нэмэгдүүлсэн нэгдүгээр дуудлагаар №1 Н	Хүч нэмэгдүүлсэн хоёрдугаар дуудлагаар №2	Автомат дуудлагаар № 3	Хорт хий утаанаас хамгаалах дуудлагаар №4
1	Сүхбаатар	10-р ГТУАА	14-р ГТУАА 34-р ГТУАА	26-р ГТУАА 63-р ГТУАА	30-р ГТУАА 11-р ГТУАА 18-р ГТУАА	14-р ГТУАА 26-р ГТУАА
2	Чингэлтэй	10-р ГТУАА	34-р ГТУАА 63-р ГТУАА	14-р ГТУАА 26-р ГТУАА	18-р ГТУАА 11-р ГТУАА 30-р ГТУАА	63-р ГТУАА 26-р ГТУАА
3	Баянгол	10-р ГТУАА	26-р ГТУАА 34-р ГТУАА	14-р ГТУАА 18-р ГТУАА	63-р ГТУАА 30-р ГТУАА 11-р ГТУАА	26-р ГТУАА 18-р ГТУАА
4	Баянзүрх	63-р ГТУАА	10-р ГТУАА 14-р ГТУАА	26-р ГТУАА 34-р ГТУАА	30-р ГТУАА 11-р ГТУАА 18-р ГТУАА	10-р ГТУАА 14-р ГТУАА
5	Хан-Уул	14-р ГТУАА	10-р ГТУАА	30-р ГТУАА 63-р ГТУАА	18-р ГТУАА 34-р ГТУАА 11-р ГТУАА 26-р ГТУАА	10-р ГТУАА 26-р ГТУАА
5	Сонгинохайрхан	26-р ГТУАА	30-р ГТУАА 18-р ГТУАА	10-р ГТУАА 14-р ГТУАА	11-р ГТУАА 34-р ГТУАА	10-р ГТУАА 26-р ГТУАА
6	Улаанбаатар	хотын салбар	10-р ГТУАА 14-р ГТУАА	63-р ГТУАА 26-р ГТУАА	11-р ГТУАА 65-р ГТУАА 28-р ГТУАА 34-р ГТУАА 30-р ГТУАА	

ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ УДИРДАГЧ \_\_\_\_\_

ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАГЧ \_\_\_\_\_

Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 5  
дугаар сарын 18-ны өдрийн  
53 дугаар тушаалын 5 дугаар хавсралт


ГАЛЫН ТҮЙМРИЙН ДУУДЛАГЫН ХУУДАС № \_\_\_\_\_

1. Хаяг.....  
.....
2. Дуудлагын утга.....  
.....
3. Дуудлага өгсөн хүний нэр .....  
Утасны дугаар.....
4. Дуудлага авсан .....цаг .....минут  
.....он .....сар .....өдөр.


ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ ...-Р АНГИ, ХЭСГИЙН  
ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАГЧ.....

ЦАГИЙН ТЭМДЭГЛЭЛИЙГ ҮНЭН  
ЗӨВ ТЭМДЭГЛЭСЭН \_\_\_\_\_


Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 53 дугаар тушаалын 6 дугаар хавсралт




Гал сөнөөгчийн



Салааны захирагчийн




Гал түймэр унтраах аврах ангийн захирагчийн




ОБЕГ-ын удирдах албан тушаалтнууд болон гал түймэр унтраах штабын офицерууд

Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 5  
дугаар сарын 18-ны өдрийн  
53 дугаар тушаалын 7 дугаар хавсралт






ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ ШУУРХАЙ ШТАБЫН ШИРЭЭНИЙ ЗАГВАР.






Монгол Улсын Шадар Сайдын  
20/бонь 5 дугаар сарын 18-ны  
өдрийн 53 дугаар тушаалын  
8 дугаар хавсралт

## ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ ТОМЬЁОЛСОН ТЭМДЭГ

### 1. Объектын гал түймрийн таних тэмдэг

1.  Объектын гал түймрийн голомт
2.  Дээврийн хэсэгт гарсан гал түймэр
3.  Дулааны үйлчлэл бүхий дотор талын гал түймэр
4.  Объектын газар давхарт гарсан гал түймэр
5.  Шатлага эхэлж буй объект
6.  Объектын доторх өрөөний гал
7.  Утаажилтын бүс /хөх/
8.  Объектын доторх утаатай гал








### 2. Ой, хээрийн гал түймрийн таних тэмдэг

9.  Ой, хээрийн гал түймрийн голомт
10.  Ой, хээрийн гал түймрийн хэсэгчилсэн бүс
11.  Ой, хээрийн гал түймрийн тархалтын чиглэл (сум нь тархах чиглэл)















12.  Шуурган гал (салхины хурдаар хуйларсан гал)
13.  Цуравдах талбайн чиглэл
14.  Цуравдсан зурвас
15.  Зогоон татсан зурвас
16.  Цурманд орсон гал түймэр
17.  Унтарсан гал түймэр

### 3. Гал түймрийн бусад томъёолсон тэмдэг

18.  Түймрийн тархалтын өргөн
19.  Түймэр унтраах бүлгийн ажиллах хил
20.  Усны төв шугам дээр байрласан гадна галын гидрант
21.  Цагираг шугам дээр байрласан гадна галын гидрант
22.  Ус түгээгүүрийн цагираг шугам
23.  Ус түгээгүүрийн мухар шугам
24.  Дотор галын гидрант /галын кран/

4. Гал унтраах зориулалт бүхий тусгай тоногтой автомашины  
томьёолсон тэмдэг

25.  Гал түймэр унтраах үндсэн албаны автомашин (10 - гал түймэр унтраах аврах ангийн дугаар)
26.  Суурин хошуутай гал түймэр унтраах үндсэн албаны автомашин
27.  Гал түймэр унтраах үндсэн албаны автомашин (гал сөнөөгчийн кабингүй)
28.  Ус тээвэрлэгч
29.  Суурин хошуутай ус тээвэрлэгч
30.  Суурин хошуутай хөөрөг бүхий ус тээвэрлэгч
31.  Нисэх онгоцны гал түймэр унтраах автомашин
32.  Автомеханик шат
33.  Авто өргөгч
34.  Гэрэл, холбооны автомашин
35.  Зөөврийн мотопомптой автомашин


36.  Хорт хий, утаанаас хамгаалах албаны автомашин
37.  Штабын албаны автомашин
38.  Ой, хээрийн гал түймэр унтраах зориулалтын автомашин
39.  Гинжит дугуйтай автомашин
40.  Гинжит дугуйтай ой, хээрийн гал түймрийн техник (БМП)
41.  Гинжит дугуйтай ой, хээрийн гал түймрийн цэвэрлэгээний техник (БМП)
42.  Хүн тээврийн автобус
43.  Хүн тээврийн авто машин
44.  Гал түймэр унтраах зориулалттай галт тэрэг
45.  Төмөр замын гал түймэр унтраах багаж хэрэгсэл
46.  Чиргүүлтэй мотопомп
47.  Усны чиргүүл


48.  Зөөврийн мотопомп


### 5. Гал түймэр унтраах багаж хэрэгсэл

49.  “А” төрлийн хошуу

50.  “Б” төрлийн хошуу

51.  Агаар механикийн бага өсөлтийн хөөсний хошуу  
/свп-2, свп-4/

52.  Агаар механикийн өндөр өсөлтийн хөөсний хошуу  
/гпс-600, гпс-200/


53.  Дээвэр дээр байрласан хошуу

54.  Барилгын газар давхарт байрласан хошуу













55.  Хорт хий, утаанаас хамгаалах багтай байрласан хошуу

56.  Дунд өсөлтийн хөөсний генератор














57.  Хөөсний хошуу

58.  3 давхарт байрласан хошуу

59.  Суурьтай зөөврийн хошуу


60.  Хөөс өргөгч хошуу
61.  Байрлал өөрчилсөн хошуу
62.  Эвхдэг шат
63.  Араатай шат
64.  Сунадаг шат
65.  Гал түймэр унтраах даралтын хоолой
66.  Гал түймэр унтраах даралтын эвхээтэй хоолой
67.  Гал түймэр унтраах соролтын хоолой
68.  Гал түймэр унтраах даралтын нугалж эвхсэн хоолой
69.  Салаа тотго
70.  Салаа бэлчэр /2 тотготой/
71.  Салаа бэлчэр /3 тотготой/

72.  Салаа бэлчэр /4 тотготой/
73.  Хоолойн гүүр
74.  Ус цуглуулагч /Гидроэлеватор/
75.  Хөөс холигч
76.  Гадна галын гидрант дээр суурилуулах төхөөрөмж /стендер, пожарная колонка/
77.  Үүргэвчин шүршигч /РЛО/
78.  Үлээгч
79.  Моторт хөрөө
80.  Цуравдагч
81.  Химийн хөөсөн гал унтраагуур
82.  Нунтаг гал унтраагуур
83.  Нүүрсхүчлийн хийн зөөврийн гал унтраагуур /гар/

84.  Нүүрс хүчлийн хийн хөдөлгөөнт гал унтраагуур /тэргэнцэртэй/
85.  Галын автомат дохиолол
86.  Утаа зайлуулах төхөөрөмж
87.  Хөөсөөр гал унтраах төхөөрөмж
- 6. Аврах багаж хэрэгсэл**
88.  Гар өргөгч гидро 5 тн –с бага
89.  Гар өргөгч
90.  Төмөр татуурга
91.  Аврах шат
92.  Олсон шат
93.  Аврах дэвсгэр /Хийлдэг/
94.  Гудас
95.  Аврах дэвсгэр /Торон/
96.  Аврах шуудаг



Аврах хоолой



Тэлэгч багаж



Зүсэгч багаж

### 7. Бусад томъёолсон тэмдэг



Овоолготой шороо



Барилгын ерөнхий схем



Барилгын шатны хонгил



Барилгын газар давхарт орох шат



Барилгын гаднах байнгын шат



Барилгын дээврийн хөндийд гарах шат










Тагттай цонх









Гэр









108.  Шатсан гэр
109.  Төмөр бетон хашаа
110.  Чулуун хашаа
111.  Модон хашаа
112.  Нас барсан
113.  Түлэгдсэн, гэмтсэн хүн
114.  Барилгын эвдэрч нурж хэмхэрсэн хэсэг








### 8.Эргүүл, хяналт

115.  Хянах байр (А-аймгийн, ЦА-цэргийн ангийн, ОБА-онцгой байдлын алба гэх мэт тайлбар бичиглэл хийнэ)
116.  Эргүүл явганаар (Э-эргүүл, Э/ЦХ - цацраг, химийн эргүүл, А-аймгийн, Об-объектын, Ца-цагдаагийн, Г-галын, Э-эмнэлгийн гэх мэт бичнэ)
117.  Эргүүл машинтай (Э-эргүүл)
118.  Төмөр замын хяналт (тэмдгийн хажууд тээврийн хэрэгслийн төрлийг заана.)






119.  Эргүүл хийх маршрут
120.  Агаараас тандалт, ажиглалт хийх газар орон

## 9. Холбоо, зарлан мэдээлэл

121.  Холбооны зангилаа
122.  Дамжуулан нэвтрүүлэгч /станцын загварыг бичиглэлээр хийнэ/
123.  Гар станц (станцын загварыг бичиглэлээр хийнэ)
124.  Зөөврийн радио станц (станцын загварыг бичиглэлээр хийнэ)
125.  Үүргэвчийн радио станц (станцын загварыг бичиглэлээр хийнэ)
126.  Сансрын холбооны газрын станц
127.  Байршил тогтоох хүлээн авагч
128.  Радио, телевизийн нэвтрүүлэх станц
129.  Радио телевизийн хүлээн авах станц
130.  Чанга яригч
131.  Холбооны агаарын баганат шугам

132.  Холбооны нягтруулсан шугам
133.  Холбооны агаарын кабель шугам
134.  Холбооны газар доорх кабель шугам
135.  Дуут дохионы хэрэгсэл (Я-яндан, Х-хонх, М – механик дуут хэрэгсэл)
136.  Дуут дохиоллын цамхаг (сирень)
137.  Дуут дохионы хөдөлгөөнт хэрэгсэл (В-вагон, М-автомашин)
138.  Кабелийн худаг

#### 10. Цахилгаан эрчим хүчний тэмдэг

139.  Цахилгаан, эрчим хүчний станц
140.  Цахилгааны дэд станц
141.  Цахилгааны аваар техникийн хэсэг (ЦАТХ)
142.  Цахилгаан аваар техникийн тусгай бүлэг (ЦАТТб)
143.  Цахилгааны аваар техникийн бүлэг (ЦАТб)

Монгол Улсын Шадар Сайдын  
2016 оны 5 дугаар сарын 18-ны  
өдрийн 13 дугаар тушаалын  
9 дүгээр хавсралт

ДУУГУЙ ДОХИО



Зураг 1 ТАСАГ ЖАГС



Зураг 2 АНХААР



Зураг 3 ТАР ХУШУУ



Зураг 4 ПАРЕТНЫ ХУШУУ ӨГ



Зураг 5 ХӨӨСНИЙ ХУШУУ ӨГ



Зураг 6 ҮС ӨГ



Зураг 7 ҮС ӨГӨХИЙГ ЗОГСОО



Зураг 8 ЭВХДЭГ ШАТ ТАВЬ



Зураг 9 АРЛАТАЙ ШАТ ТАВЬ



Зураг 10 ГУРАВ СУНАДАГ ШАТ ТАВЬ



Зураг 11 ДАРАЛТ НӨМӨХ



Зураг 12 ДАРАЛТ ХАСАХ



Зураг 13 АЮУЛГҮЙ УХАР



Зураг 14 БАГ ӨМС



Зураг 15 БАГ ТАЙЛ



Зураг 16 ЭМНЭЛЭГ ДУУД



Зураг 17 ДОХИОГ ОЙЛГОСОНГҮЙ ДАВТ



Зураг 18 ДУУСГА